

Монгол Улс
Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ)

МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

**Төслийн төгсгөлийн тайлангийн хавсралт
Техникийн хамтын ажиллагааны төслийн
хүрээнд боловсруулсан бүтээгдэхүүн /
баримт бичиг**

II

2020 оны 1-р сар

**ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
БАЙГУУЛЛАГА (ЖАЙКА)**

**ОРИЕНТАЛ КОНСАЛТАНЦ ГЛОБАЛ ХК
КОКУСАЙ КОГЁО ХК**

**ОЁО ИНТЕРНАШНЛ КОРПОРАЦИ
ХОТЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ХҮРЭЭЛЭН**

**Хавсралт хэсэг: Техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд
боловсруулсан бүтээгдэхүүн/баримт бичиг**

Хавсралт I

1: Гамшгаас хамгаалах засаглал, барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлт, гамшгаас хамгаалах боловсролтой холбоотой заавар, журам, санамж бичгийн төсөл

【Үр дүн 1】

- 1-1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа хийх заавар 1-1-1
- 1-2 Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний техникийн зааварчилгаа
 - 1-2-1 Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний техникийн зааварчилгаа 1-2-1-1
 - 1-2-2 Газар хөдлөлтийн хохирлын үнэлгээнд Эксел программ ашиглах гарын авлага 1-2-2-1
 - 1-2-3 Хохирлын тооцоолол хийх Эксел программ 1-2-3-1
- 1-3 Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар 1-3-1
- 1-4 Улсын албаны газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар 1-4-1
- 1-5 Орон нутгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар 1-5-1
- 1-6 Санамж бичгийн төслүүд
 - 1-6-1 Санамж бичиг боловсруулах гарын авлага 1-6-1-1
 - 1-6-2 Санамж бичиг: Хүнс, эм хангамж, барилгын материал, усны хангамж, шуурхай тээвэр, түлш шатахуун, холбоо харилцаа, түр хоргодох байр, бохир зайлуулах тухай 1-6-2-1
- 1-7 ГОЗМС-ийн журам, холбогдох санамж бичгүүд
 - 1-7-1 ГОЗМС-ийн журам 1-7-1-1
 - 1-7-2 Гамшгийн мэдээлэл хамтран ашиглах гэрээ 1-7-2-1

【Үр дүн 2】

- 1-8 Газар хөдлөлтийн тэсвэрлэлийн үнэлгээ, хүчитгэлийн заавар – ЦТБ 1-8-1
- 1-9 Газар хөдлөлтийн тэсвэрлэлийн үнэлгээ, хүчитгэлийн заавар – угсармал 1-9-1

1-10 Газар хөдлөлтийн тэсвэрлэлийн үнэлгээ, хүчитгэлийн заавар – өрөгт.....	1-10-1
1-11 Газар хөдлөлтийн тэсвэрлэлийн үнэлгээ, хүчитгэлийн заавар – дэд бүтэц, ИШС.....	1-11-1

【Үр дүн 3】

1-12 Аюулгүй амьдрах ухаан сургалтын хөтөлбөр.....	1-12-1
--	--------

Хавсралт II

2: Гамшгаас хамгаалах засаглал, барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлт, гамшгаас хамгаалах боловсролтой холбоотой сургалтын хэрэглэгдэхүүн болон сургалт явуулах гарын авлага

【Үр дүн 2】

2-1 Газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтын гарын авлага	
2-1-1 Барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ, хүчитгэлийн сургалтын гарын авлага.....	2-1-1-1
2-1-2 Дэд бүтэц, ИШС-ний газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтын гарын авлага.....	2-1-2-1

3: Шинэчлэн боловсруулсан улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний төсөл болон гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах гарын авлага

3-1 Дархан-Уул аймгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө.....	3-1-1
3-2 Өмнөговь аймгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө.....	3-2-1
3-3 Нийслэлийн Баянгол дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө.....	3-3-1
3-4 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө.....	3-4-1
3-5 Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах гарын авлага (Аймаг, Нийслэлийн).....	3-5-1

4: Гамшгаас хамгаалах Цагаан ном, Цагаан ном боловсруулах гарын авлага

4-1 Цагаан ном боловсруулах гарын авлага.....	4-1-1
---	-------

Хавсралт II

**2: Гамшгаас хамгаалах засаглал,
барилгын газар хөдлөлтийн
тэсвэрлэлт, гамшгаас хамгаалах
боловсролтой холбоотой
сургалтын хэрэглэгдэхүүн болон
сургалт явуулах гарын авлага**

2-1 Газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтын гарын авлага

2-1-1 Барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ, хүчитгэлийн сургалтын гарын авлага

Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ, хүчитгэлийн
тухай сургалт зохион байгуулах гарын авлага

ЖАЙКА төслийн баг болон 2-р ажлын хэсэг

Гарчиг

1-р бүлэг. Ерөнхий зүйл	1
1.1 Гарын авлагын зорилго	1
1.2 Гарын авлагыг сайжруулах тухай.....	1
1.3 Гарын авлагыг хариуцах байгууллага.....	1
2-р бүлэг. Сургалтын хөтөлбөр.....	2
2.1 Сургалтын хөтөлбөрийн бүтэц.....	2
2.2 Сургалтаар багшлах багш нарыг сонгох.....	2
2.3 Сургалтад хамрагдах хүмүүсийг сонгох.....	2
2.4 Сургалтад ашиглах материал.....	2
2.5 Сургалтын хөтөлбөрийн жишээ	2
3-р бүлэг. Үнэлгээ	6
3.1 Өмнөх сургалтад ашигласан материал	6
3.2 Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний эксел файлыг ашиглах заавар.....	8
3.2.1 Цутгамал төмөр бетон барилгын үнэлгээ	8
3.2.2 Угсармал том хавтгаалжин барилгын газар үнэлгээ.....	14
3.2.3 Өрөгт барилгын үнэлгээ.....	18
4-р бүлэг. Хүчитгэл.....	22
4.1 Өмнөх сургалтад ашигласан материалууд.....	22

1-р бүлэг. Ерөнхий зүйл

1.1 Гарын авлагын зорилго

Цутгамал төмөр бетон, Угсармал том хавтгаалжин, Өрөгт бүтээцтэй барилгуудын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн аргачлалын тухай сургалтуудыг зохион байгуулахад тус гарын авлагыг ашиглана.

1.2 Гарын авлагыг сайжруулах тухай

Тус гарын авлага дах материалуудыг ашиглахдаа зохион байгуулахаар төлөвлөсөн сургалтын хөтөлбөртэйгээ уялдуулан агуулгыг нэмэх, хасах, засварлах замаар өөрчлөлт оруулж болно.

Өөрчлөлт оруулсан тохиолдолд ОБЕГ-т мэдэгдэнэ.

1.3 Гарын авлагыг хариуцах байгууллага

Гарын авлагыг ОБЕГ хариуцан хадгалана.

2-р бүлэг. Сургалтын хөтөлбөр

2.1 Сургалтын хөтөлбөрийн бүтэц

Үнэлгээ болон хүчитгэлийн сургалтыг зохион байгуулахдаа сургалтад хамрагдагсадын мэргэжил, ажлын туршлагыг харгалзан үзэж хөтөлбөрийг боловсруулна.

2.2 Сургалтаар багшлах багш нарыг сонгох

Багш нарыг сургагч багшийн сургалтад хамрагдсан хүмүүсээс сонгоно.

Мөн цаашид сургагч багшийн сургалтыг зохион байгуулж сургагч багш болсон хүмүүсээс сонгож болно.

2.3 Сургалтад хамрагдах хүмүүсийг сонгох

Сургалтыг зохион байгуулах тал сургалтын зорилгоос хамаарч сургалтад хамрагдах хүмүүсийг сонгох бөгөөд тусгайлан шаардлага тавигдахгүй.

Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа аргачлалуудыг аль болох ойлгуулахаар боловсруулахаас гадна хамрагдагсдын тоог тохиримжтой байдлаар байлгах шаардлагатай.

2.4 Сургалтад ашиглах материал

Сургалтын материалыг сургалт зохион байгуулах тал бэлдэнэ.

Материалын агуулгыг сургалтаар багшлах багш, зохион байгуулагч нар тусгайлан бэлдэж болно. Мөн тус гарын авлагын дараагийн бүлэгт заасан материалуудаас ашиглаж болно.

2.5 Сургалтын хөтөлбөрийн жишээ

Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний тухай сургалтын хөтөлбөрийн жишээг хүснэгт 2.5-1-т үзүүлэв. Үүнд Цутгамал төмөр бетон, Угсармал том хавтгаалжи, Өрөгт бүтээцтэй барилга гэсэн 3 төрлийн бүтээцийн үнэлгээний тухай аргачлалыг хамруулсан тул 3-н өдрийн сургалт зохион байгуулагдсан. Эхний өдөр нь Үнэлгээний тухай ерөний ойлголт, 2 болон 3 дах өдөр нь дээрх бүтээцүүдийн үнэлгээний аргачлалын тухай болно. Сургалтыг ойлгомжтой болгох үүднээс лекц, дасгал ажлуудыг хослуулан зохион байгуулсан.

Цаашид сургалт зохион байгуулахдаа бүтээцийн төрөл тус бүрээр зохион байгуулж болох ба хүснэгт дэх шаардлагатай хэсгүүдээс түүвэрлэн авч хөтөлбөрийг

боловсруулж болно.

Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээнд ашиглагдах багаж (Үл эвдэх сорилын багаж) ашиглах тухай сургалтын хөтөлбөрийн жишээг хүснэгт 2.5-2-т үзүүлэв. Тус сургалтыг зохион байгуулах үед хичээлийн танхимын бололцооноос хамаарч 2 өдөрийн хөтөлбөрөөр зохион байгуулсан боловч агуулгын хувьд 1 бүтэн өдрийн хөтөлбөр болно.

Барилгын хүчитгэлийн тухай сургалтын хөтөлбөрийн жишээг хүснэгт 2.5-3-т үзүүлэв. Эхний өдөр нь холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны танилцуулга, Япон улс дах тогтолцооны тухай агуулгуудыг багтаасан ба 2 дах өдрөөс хүчитгэлийн аргачлалын үндсэн агуулгыг оруулсан. Сургалтад хамрагдагсад илүү ойлгомжтой байх үүднээс лекц ба хүчитгэлийн жишээ зураг төслийн тайлбарыг хослуулан зохион байгуулсан.

Хүснэгт 2.5-1 Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний тухай сургалтын хөтөлбөрийн жишээ

Өдөр	Цаг	Сэдэв
1	Үдээс өмнө	Нээлтийн үг
		Сургалтын танилцуулга
		Шинээр боловсруулгдсан БД-үүдийн тухай танилцуулга
		Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн тухай БХБЯ-ны бодлого
		Барилгын паспортжуулалтын тухай НХБХГ-ын үйл ажиллагаа
	Үдээс хойш	Япон Улсад тохиолдолж байсан газар хөдлөлтийн гамшиг ба хариу арга хэмжээ
		Япон Улсын барилгыг газар хөдлөлтөд тэсвэртэй төсөллөх аргачлал ба үнэлгээний аргачлалын тухай
2	Үдээс өмнө	Цутгамал төмөр бетон барилгын үнэлгээ /Лекц/
		Цутгамал төмөр бетон барилгын үнэлгээ /Дасгал ажил/
	Үдээс хойш	Угармал том хавтгаалжин барилгын үнэлгээ /Лекц/
		Угармал том хавтгаалжин барилгын үнэлгээ /Дасгал ажил/
3	Үдээс өмнө	Өрөгт барилгын үнэлгээ /Лекц/
		Өрөгт барилгын үнэлгээ /Дасгал ажил/
	Үдээс хойш	Япон дах барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний тогтолцоо
		Барилгын биет судалгаа, үл эвдэх сорилын багажны тухай
		Гэрчилгээ гардуулах
		Хаалтын үг

Хүснэгт 2.5-2 Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээнд ашиглах багажны тухай
сургалтын хөтөлбөрийн жишээ

Өдөр	Цаг	Сэдэв
1	Үдээс хойш	Нээлтийн үг
		Багажны танилцуулга
		Сургалтын танилцуулга
		Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ ба хэмжилтийн багаж
		Барилгын паспортжуулалт ба хэмжилтын багаж
		Шмидтийн алх ашиглах тухай (Лекц ба дадлага)
2	Үдээс хойш	Профометр ашиглах тухай (Лекц ба дадлага)
		Pundit Lab+ ашиглах тухай (Лекц ба дадлага)
		Үл эвдэх сорилын тухай
		Гэрчилгээ олгох
		Хаалтын үг

Хүснэгт. 2.5-3 Барилгын хүчитгэлийн аргачлалын тухай сургалтын хөтөлбөрийн жишээ

Өдөр	Цаг	Сэдэв
1	Үдээс өмнө	Нээлтийн үг
		БХБЯ-аас баримтлаж буй бодлого
		Шинээр боловсруулсан БД-үүдийн тухай
		ОБЕГ-аас баримтлаж буй бодлого
		НХБХГ-аас хэрэгжүүлж буй барилгын паспортжуулалтын тухай
		Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам
		Япон дах Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ ба хүчитгэл
	Үдээс хойш	Хялбарчилсан ба нарийвчилсан үнэлгээний ялгаа
		Биет судалгаанд ашиглагдах үл эвдэх сорилын багажны тухай
		Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал ба хэмжилтийн багаж
2	Үдээс өмнө	Цутгамал төмөр бетон барилгын нарийвчилсан үнэлгээний аргачлал (лекц)
		Цутгамал төмөр бетон барилгын нарийвчилсан үнэлгээний аргачлал (Дасгал ажил)
	Үдээс хойш	Том хавтгаалжин угсармал барилгын нарийвчилсан үнэлгээний аргачлал (лекц)
		Том хавтгаалжин угсармал барилгын нарийвчилсан үнэлгээний аргачлал (Дасгал ажил)
3	Үдээс өмнө	Барилгын хүчитгэлийн зарчим
		Цутгамал төмөр бетон барилгын хүчитгэлийн аргачлал
		Цутгамал төмөр бетон барилгын хүчитгэлийн жишээ зураг төсөл
	Үдээс хойш	Том хавтгаалжин угсармал барилгын хүчитгэлийн аргачлал
		Том хавтгаалжин угсармал барилгын хүчитгэлийн жишээ зураг төсөл
		Өрөгт бүтээцтэй барилгын хүчитгэлийн аргачлал
		Өрөгт бүтээцтэй барилгын хүчитгэлийн жишээ зураг төсөл
		Гэрчилгээ гардуулах
Хаалтын үг		

3-р бүлэг. Үнэлгээ

3.1 Өмнөх сургалтад ашигласан материал

Төслөөс зохион байгуулсан сургалтуудад ашигласан файлуудыг хүснэгт 3.1-1 болон 3.1-2-т үзүүлэв. Файлуудын нэрс нь сургалтын хөтөлбөртэй уялдуулсан бөгөөд хамгийн эхний цифр нь сургалтын өдрийн дугаар, зураасны дараах үсэг нь А бол үдээс өмнө, Р бол үдээс хойш, түүний дараах тоо нь дарааллыг заана. Материалын хэл нь М бол Монгол хэл, Е бол Англи хэл, J бол Япон хэл дээр байгааг илэрхийлнэ.

Эдгээр файлуудын электрон хувилбар нь ОБЕГ-т хадгалагдаж байгаа болно.

Багаж ашиглах тухай сургалтын дадлага ажилаар ШУТИС-ын барилгын материалын лабораториос бетоны сорилын бэлдэцийг түр зээлж ашигласан. Мөн, арматур илрүүлэх багажинд зориулж бэлдэцийг шинээр хийсэн.

Хүснэгт 3.1-1 Барилгын үнэлгээний сургалтад ашигласан файлууд

Файлын нэрс	Хэл	Файлын формат
1-A1.Introduction of Training course	М	Power Point
1-A2.Introduction of new BDs	М	Power Point
1-A3.Policy of MCUD	М	Power Point
1-A4.Seismic diagnosis in UB	М	Power Point
1-P1.General Concept of Seismic diagnosis (1)	М/Е	Power Point
1-P2.General Concept of Seismic diagnosis (2)	М/Е	Power Point
2-A1.Seismic Evaluation of RC Building (1)	М	Power Point
2-A2.Seismic Evaluation of RC Building (2)	М/Е	Excel
2-P1.Seismic Evaluation of PC Building (1)	М	Power Point
2-P2.Seismic Evaluation of PC Building (2)	М/Е	Excel
3-A1.Seismic Evaluation of Masonry Building(1)	М	Power Point
3-A2.Seismic Evaluation of Masonry Building(2)	М/Е	Excel
3-A3.General Concept of Seismic Diagnosis (3)	М/J	Power Point

Хүснэгт 3.1-2 Барилгын үнэлгээнд ашиглах багажны тухай сургалтын файлууд

Файлын нэрс	Хэл	Файлын формат
1-A1.Introduction of Training course	M	Power Point
1-A2.Introduction of new BDs	M	Power Point
1-A3.Policy of MCUD	M	Power Point
1-A4.Seismic diagnosis in UB	M	Power Point
1-P1.GeneralConcept of Seismic diagnosis (1)	M/E	Power Point
1-P2.GeneralConcept of Seismic diagnosis (2)	M/E	Power Point
2-A1.Seismic Evaluation of RC Building (1)	M	Power Point
2-A2.Seismic Evaluation of RC Building (2)	M/E	Excel
2-P1.Seismic Evaluation of PC Building (1)	M	Power Point
2-P2.Seismic Evaluation of PC Building (2)	M/E	Excel
3-A1.Seismic Evaluation of Masonry Building(1)	M	Power Point
3-A2.Seismic Evaluation of Masonry Building(2)	M/E	Excel
3-A3.General Concept of Seismic Diagnosis (3)	M/J	Power Point

3.2 Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний эксел файлыг ашиглах заавар

Цутгамал төмөр бетон, Угсармал том хавтгаалжин, Өрөгт бүтээцтэй барилгуудын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний эксел файлуудыг хэрхэн ашиглах тухай тайлбар болно.

3.2.1 Цутгамал төмөр бетон барилгын үнэлгээ

Цутгамал төмөр бетон барилгын үнэлгээнд хавсарлт дах эксел файлыг ашиглана. Экселийн файл нь үнэлгээний үр дүнг тооцох sheet (давхар, чиглэл тус бүрээр сорь хийх замаар бодолтыг хийнэ), Хэлбэрийн индексийг тооцох sheet, насжилтын индексийг тооцох sheet, төсөллөтийн үеийн хөндлөн хүчний тооцох sheet-үүдээс бүрдэнэ.

(1) Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн хязгаарын индекс I_{s0} -ийг тооцох

Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс I_{s0} -ийг тооцох хэсгийг зураг 3.2.1-1-т үзүүлэв.

Үнэлгээ хийх барилгын талбайн газар хөдлөлтийн баллыг сонгох бөгөөд “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” /БНБД 22-01-01*/2006/-г ашиглана.

А илтгэлцүүрийн утга ба бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн хязгаарын индекс I_{s0} -ын утгууд автоматаар тооцогдоно.

Барилгын талбайн тооцооны газар хөдлөлтийн балл		7
Барилгын талбайн тооцооны газар хөдлөлтийн ба ллаас хамаарах илтгэлцүүр	A=	0.1
	I_{s0} =	0.10

Зураг 3.2.1-1 Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн хязгаарын индексийг тооцох хэсэг

(2) Барилгын мэдээллийг оруулах хэсэг

Барилгын мэдээллийг оруулах хэсгийг зураг 3.2.1-2-т үзүүлэв.

- Барилгын мэдээлэлд давхрын тоо, барилгын өндөр, барилгын урт, өргөнийг гараас оруулана.
- Барилгын үндсэн хувийн хэлбэлзлийн үндсэн үеийг тооцохдоо диафрагамгүй каркас эсвэл холбоостой болон рам-холбоостой каркас гэсэн хоёр сонголтоос сонгоно. Үр дүнд нь баруун нүдэнд хувийн хэлбэлзлийн үндсэн үе автоматаар тооцогдон гарна.
- Барилгын талбайн хөрсний зэргийг сонгосноор нормын спектр муруйнд харгалзах динамик илтгэлцүүр автоматаар бодогдоно.

- Үнэлгээ хийж буй давхар (Газраас дээших давхар)-ын дугаарыг гараас оруулана. Үр дүнд нь тухайн давхраас дээших барилгын талбай бодогдоно.
- Нэгж талбайд ногдох барилгын жинг гараас оруулана. Цутгамал төмөр бетоны хувьд 12 кН/м^2 -аар тооцож болно. Үр дүнд нь тухайн давхрын хүлээж авч байгаа нийт босоо ачаа бодогдоно.

Барилгын давхрын тоо	n	=	7		
Барилгын өндөр (м)	H	=	20	(м)	
Барилгын урт (м)		=	15	(м)	
Барилгын өргөн (м)		=	15	(м)	
Цутгамал төмөр бетон барилгын үндсэн хувийн хэлбэлзлийн үе	T_l	=	Холбоостой болон рам-хөлбоостой каркас	0.473	(сек)
Барилгын буурь хөрсийг газар хөдлөлийн шинж чанараар ангилсан зэрэг		=	1		
Барилгын хувийн хэлбэлзлийн нэгдүгээр хэлбэрт харгалзах динамик илгээлцүүр	β_l	=	2.30		
Үнэлгээ хийж буй давхрын дугаар	i	=	1		
Үнэлгээ хийж буй болон түүнээс дээш давруудын нийт талбай	A_l	=	1575.00	(м ²)	
Барилгын нэгж талбайд ногдох босоо ачаа	w	=	12	(кН/м ²)	Хялбарчилсан үнэлгээнд $w=12 \text{ кН/м}^2$ гэж авна.
Тухайн давхраас дээш давхруудаас ирэх нийт босоо ачаа	ΣW	=	18900.00	(кН)	

Зураг 3.2.1-2 Барилгын мэдээллийг оруулах хэсэг

(3) Барилгын даацын элементүүдийн мэдээллийг оруулах

Барилгын даацын элементүүд (Диафрагм хана, багана)-ийн мэдээллийг оруулах хэсгийг зураг 3.2.1-3-т үзүүлэв.

- Барилгын үнэлгээ хийх чиглэлийг гараас оруулна. Аль чиглэлийн үнэлгээг хийж байгааг энэ нүднээс харах зориулалттай.
- Диафрагм ханын дугаар тус бүрээр мэдээллийг оруулна.
 - Ханын тэмдэглэгээ, рамын дугаарыг гараас оруулна.
 - Ханын төрлийг сонгож оруулах бөгөөд хоёр талдаа баганатай хана бол w_1 , нэг баганатай хана бол w_2 , баганагүй хана бол w_3 -ыг тус тус сонгоно.
 - Хана тус бүрийн зузаан, урт, тоог гараас оруулна.
 - Үр дүнд нь диафрагм хана тус бүрийн хөндлөн огтлолын талбай автоматаар бодогдно.
- Баганын тухайд мөн адил баганын дугаар тус бүрээр мэдээллийг оруулна.
 - Баганын тэмдэглэгээ, рамын дугаарыг гараас оруулна.
 - Баганын төрөл нь түүний геометр хэмжээнээс хамаарч автоматаар бодогдож гарах тул гараас оруулах шаардлагагүй.
 - Баганын огтлолын өргөн, өндөр, цэвэр өндөрийг гараас оруулна. Үр дүнд нь баганын цэвэр өндөр ба огтлолын харьцаа бодогдож, баганын төрөл автоматаар тогтоогдоно.
 - Баганын тоог гараас оруулна.
 - Дээрх өгөгдлүүдийг оруулснаар баганын төрөл тус бүрийн хөндлөн огтлолын талбай автоматаар бодогдоно.

x								
Үнэлгээ хийх чиглэл (Х,У чиглэл)								
Үнэлгээ хийж буй давхрын газар хөдлөлтийн үйлчлэлийг тооцоолж буй чиглэлд ажиллах ханын нийт хөндлөн огтлолын талбайг тооцох								
Диафрагм ханын тэмдэглэгээ	Рамын дугаар	Ханын ангилал w1,w2,w3	Ханын зузаан t (м)	Ханын урт (нээллийн уртыг хассан урт) L (м)	Ханын тоо N	Хоёр баганатай хана $A_{w1} (м^2)$	Нэг баганатай хана $A_{w2} (м^2)$	Баганагүй хана $A_{w3} (м^2)$
W1	1	w1	0.2	6	2	2.4		
W2	3	w2	0.15	6	1		0.9	
W3	4	w3	0.2	3	1			0.6
Нийлбэр						2.4	0.9	0.6

Үнэлгээ хийж буй давхрын багануудын хөндлөн огтлолын талбайг тооцох										
Баганын тэмдэглэгээ	Рамын дугаар	Баганын ангилал c1,c2,sc	Баганын хөндлөн огтлолын өргөн $B(м)$	Баганын хөндлөн огтлолын өндөр $D(м)$	Баганын цэвэр өндөр $h_0(м)$	h_0/D	Баганын тоо N	$A_{c1}(м^2)$	$A_{c2}(м^2)$	$A_{sc}(м^2)$
C1	1	c1	0.6	0.6	3	5.00	4	1.44		
C2	3	c2	0.4	0.4	3	7.50	2		0.32	
C3	4	sc	0.6	0.6	1	1.67	2			0.72
Нийлбэр								1.44	0.32	0.72

Зураг 3.2.1-3 Барилгын даацын элементүүд (Диафрагм хана, багана)-ийн мэдээллийг оруулах хэсэг

(4) Материалын бат бэхийг оруулах ба Бүтээцийн газар хөдлөлтийн суурь индекс E_0 -ийн тооцоо

Материалын бат бэхийг оруулах ба Бүтээцийн газар хөдлөлтийн суурь индекс E_0 -ийн тооцох хэсгийг зураг 3.2.1-4-т үзүүлэв.

- Бетоны шахалтын бат бэхийг гараас шууд оруулах ба үр дүнд нь бат бэхээс хамаарсан засварлах илтгэлцүүр β_c автоматаар бодогдно.
- Даацын элемент тус бүрийн бат бэхийн индекс C болон үнэлгээ хийж буй давхрын дугаараас хамаарах хөндлөн хүчийг хувиарлах илтгэлцүүрүүд автоматаар бодогдоно.
- Дээрх өгөгдлүүдийн үр дүнд бүтээцийн газар хөдлөлтийн суурь индекс E_0 автоматаар бодогдно.

Бат бэхийн индексийг тооцох

Cw	$=(\tau_{w1}A_{w1}+\tau_{w2}A_{w2}+\tau_{w3}A_{w3})\beta_c/\Sigma W$ (4.3)	0.51
Cc	$=(\tau_{c1}A_{c1}+\tau_{c2}A_{c2})\beta_c/\Sigma W$ (4.4)	0.09
Csc	$=\tau_{sc}A_{sc}\beta_c/\Sigma W$ (4.5)	0.06

Үгүүд: $\tau_{w1}=3,000$, $\tau_{w2}=2,000$, $\tau_{w3}=1,000$, $\tau_{c1}=1,000$, $\tau_{c2}=700$, $\tau_{sc}=1,500(kH/m^2)$

Бүтээцийн газар хөдлөлт гэсвэрлэлийн суурь индексийг тооцох

E_0	$=\{(n+1)/(n+i)\}(C_w+\alpha_1 C_c)F_w$ (4.1)	0.570
	$=\{(n+1)/(n+i)\}(C_{sc}+\alpha_2 C_w+\alpha_3 C_c)F_{sc}$ (4.2)	0.365
Бо-ийг (4.1) болон (4.2) томьёогоор тодорхойлж аль их утгыг авна		$E_0=$ 0.570

$$F_c = \begin{cases} 20 & (H/mm^2) \text{ if } F_c > 20: \sqrt{(F_c/20)} \\ 1.00 & \text{if } F_c \leq 20: F_c/20 \end{cases}$$

$$1H/mm^2 = 1000kH/m^2$$


$$\alpha_1 = \begin{cases} 1.00 & F_w=1.0, F_{sc}=0.8 \\ 0.7 & \alpha_1=0.7 \text{ if } C_w \neq 0 \text{ or } \alpha_1=1.0 \text{ if } C_w=0, \\ & \alpha_2=0.7, \alpha_3=0.5 \end{cases}$$

Зураг 3.2.1-4 Материалын бат бэхийг оруулах ба Бүтээцийн газар хөдлөлтийн суурь индекс E_0 -ийн тооцох хэсэг

(5) Үнэлгээний үр дүн

Үнэлгээний үр дүнг харуулах хэсгийг зураг 3.2.1-5-г үзүүлэв.

- Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс I-ийн тооцоход шаардлагатай индекс (суурь индекс E_0 , хэлбэрийн индекс S_D , насжилтын индекс T, динамик илтгэлцүүрээс хамаарах утга $1/\beta_1$)-үүд харагдах бөгөөд хэлбэрийн индекс S_D болон насжилтын индекс T нь тусдаа sheet-ээр тооцсон үр дүнгээс автоматаар орж ирнэ.
- Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс I_s нь дээрх индексүүдийн үржвэрээр илэрхийлэгднэ.
- Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс I_s болон хязгаарын индекс I_{s0} -ийн харьцаанаас үнэлгээний үр дүн автоматаар илэрхийлэгдэнэ.



Зураг 3.2.1-5 Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний үр дүнг харуулах хэсэг

(6) Хэлбэрийн индекс S_D -г тооцох

Хэлбэрийн индекс S_D -г тооцох хэсгийг зураг 3.2.1-6-г үзүүлэв.

- Хэлбэрийн индекс S_D -г тооцох хүснэгтээс тохирох хэсэгт гараас цифр эсвэл үсэг (жишээ нь х) гараас оруулна.
 - Гараас өгөгдөл оруулаагүй нүд үлдсэн тохиолдолд $S_D=0$ болно.
 - Мөн нэг мөрөнд хэд хэдэн өгөгдөл оруулсан тохиолдолд алдаа заана.
 - Зоорийн давхаргүй тохиолдолд h хэсэгт 0.8-д харгалзах нүдэнд өгөгдөл оруулна.
- Харгалзах хэсэгт өгөгдөл оруулахдаа тус sheet дэх тайлбар зургуудыг ашиглана.
- Хүснэгт дэх хамгийн доод нүдэнд хэлбэрийн индекс S_D -ийн утга гарна.

		G_i				R_i	q_i			
		1.0		0.9	0.8	R_{1i}				
Байгуулалтын хэлбэр	a	Байгуулалтын зөв байдал	$a \leq 0.1$	x	$0.1 < a \leq 0.3$		$0.3 < a$	0.9	1.0	0.9
	b	Урт өргөний харьцаа	$b \leq 5$	x	$5 < b \leq 8$		$8 < b$	0.9	0.5	1.0
	c	Байгуулалтын нарийссан хэсгийн харьцаа	$0.8 \leq c$		$0.5 < c \leq 0.8$	x	$c < 0.5$	0.8	0.5	0.9
	d	Заадас	$1/100 \leq d$	x	$1/200 \leq d < 1/100$		$d < 1/200$	0.9	0.5	1.0
	e	Онгорхой талбай	$e \leq 0.1$	x	$0.1 < e \leq 0.3$		$0.3 < e$	0.9	0.5	1.0
	f	Онгорхойн байрлал	$f_1 \leq 0.4$ and $f_2 \leq 0.1$	x	$f_1 \leq 0.4$ and $0.1 < f_2 \leq 0.1$		$0.4 < f_1$ or $0.3 < f_2$	0.9	0.25	1.0
Өндрийн хэлбэр	h	Зоорины давхар	$1.0 \leq h$	x	$0.5 \leq h < 1.0$		$h < 0.5$	0.9	1.0	1.1
	i	Давхруудын өндрийн дагуух жигд байдал	$0.8 \leq i$	x	$0.7 \leq i < 0.8$		$i < 0.7$	0.9	0.5	1.0
	j	Уян давхар	Уян даьхаргүй	x	Уян давхартай		Тийм. Төвийн бүс уян давхартай	0.9	1.0	0.9
									S_D	0.6

Зураг3.2.1-6 Хэлбэрийн индекс S_D -г тооцох хэсэг

(7) Насжилтын индекс Т-г тооцох

Насжилтын индекс Т-г тооцох хэсгийг зураг 3.2.1-7-т үзүүлэв.

- Насжилтын индекс Т-г тооцох хүснэгтээс тохирох хэсэгт гараас цифр эсвэл үсэг (жишээ нь х) гараас оруулна.
 - Гараас өгөгдөл оруулаагүй нүд үлдсэн тохиолдолд $T=0$ болно.
 - Мөн хэд хэдэн өгөгдөл оруулсан тохиолдолд алдаа заана.
- Хүснэгт дэх хамгийн доод насжилтын индекс Т-ийн утга гарна.

[A] Шалгах зүйлс	[B] Насжилт, элэглийн түвшин	сонгох хэсэг	[B] T
Харагдахуйц хэв гажилт	Барилга нь хазайсан эсвэл жигд бус суултад орсон.		0.7
	Барилга нь асгаасан дээр баригдсан	x	0.9
	Дам нуруу болон багана нь нүдэн баримжаагаар мэдэгдэхүйц хэв гажилтад орсон.		0.9
	Дээрхийн алинд нь ч хамаарахгүй.		1
Хана, баганын ан цав	Бороо, цасны ус нэвчсэнээс арматурт зэврэлтэд ажиглагдсан.		0.8
	Баганад нүдэнд харагдахуйц ташуу ан цав гарсан.		0.9
	Гадна ханад маш олон ан цав гарсан.	x	0.9
	Бороо, цасны ус нэвчсэн боловч арматур зэврэлтэд ороогүй.		0.9
	Дээрхийн алинд нь ч хамаарахгүй.		1
Галын үйлчлэлд эсэх	Галын ул мөр нь илт харагдахуйц.		0.7
	Галд өртөж байсан боловч ул мөр нь арилсан.	x	0.8
	Галд өртөж байгаагүй.		1
Ашиглалт	Химийн бодис ашиглаж байсан.		0.8
	Химийн бодис ашиглаж байгаагүй.	x	1
Насжилт	30 жилээс дээш		0.8
	20 жилээс дээш	x	0.9
	20 жилээс доош		1
Гадна болон дотор заслын байдал	Гадна фасад нь нүдэнд харагдахуйц элэгдэж ховхорсон.		0.9
	Дотор заслын материал нь илт хуучирч ховхорсон.	x	0.9
	Илт хуучирч элэгдсэн байдал ажиглагдаагүй.		1
0.8			

Зураг 3.2.1-7 Насжилтын индекс T-г тооцох хэсэг

3.2.2 Угсармал том хавтгаалжин барилгын газар үнэлгээ

Угсармал том хавтгаалжин барилгын үнэлгээнд хавсарлт дах эксел файлыг ашиглана. Экселийн файл нь үнэлгээний үр дүнг тооцох sheet (давхар, чиглэл тус бүрээр сорь хийх замаар бодолтыг хийнэ), Хэлбэрийн индексийг тооцох sheet, насжилтын индексийг тооцох sheet, төсөллөлтийн үеийн хөндлөн хүчний тооцох sheet-үүдээс бүрдэнэ.

(1) Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн хязгаарын индекс I_{s0} -ийг тооцох

Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс I_{s0} -ийг тооцох хэсгийг зураг 3.2.2-1-т үзүүлэв.

Үнэлгээ хийх барилгын талбайн газар хөдлөлтийн баллыг сонгох бөгөөд “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” /БНБД 22-01-01*/2006/-ын дагуу тухай баллд харгалзах А илтгэлцүүрийн утга нь бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн хязгаарын индекс I_{s0} –ын утга болж автоматаар тооцогдоно.

Барилгын талбайн тооцооны газар хөдлөлтийн балл
Барилгын талбайн тооцооны газар хөдлөлтийн баллаас хам
аарах илтгэлцүүр

	7
A=	0.1
I_{s0} =	0.10

Зураг 3.2.2-1 Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн хязгаарын индексийг тооцох хэсэг

(2) Барилгын мэдээллийг оруулах хэсэг

- Барилгын мэдээллийг оруулах хэсгийг зураг 3.2.1-2-г үзүүлэв
- Барилгын давхрын тоо (5, 9, 12 давхар)-г сонголтоор оруулна.
- Барилгын мэдээлэлд давхрын тоо, барилгын өндөр, барилгын урт, өргөнийг гараас оруулна.
- Барилгын үндсэн хувийн хэлбэлзлийн үндсэн үеийг тооцохдоо хамгийн их утга эсвэл дундаж утгыг сонгоно. Үр дүнд нь баруун нүдэнд хувийн хэлбэлзлийн үндсэн үе автоматаар тооцогдон гарна. Хувийн хэлбэлзлийн үеийг тусгайлан хэмжээгүй тохиолдолд хамгийн бага утгыг сонгох нь зүйтэй.
- Барилгын талбайн хөрсний зэргийг сонгосноор нормын спектр муруйнд харгалзах динамик илтгэлцүүр автоматаар бодогдоно.
- Үнэлгээ хийж буй давхар (Газраас дээших давхар)-ын дугаарыг гараас оруулна. Үр дүнд нь тухайн давхраас дээших барилгын талбай бодогдоно.
- Нэгж талбайд ногдох барилгын жинг гараас оруулна. Угсармал том хавтгаалжин барилгын хувьд 12 кН/м^2 -аар тооцож болно. Үр дүнд нь тухайн

давхрын хүлээж авч байгаа нийт босоо ачаа бодогдоно.

- Ханын хавтгаалжийн хэвтээ чиглэл дэх уулзварын арматурын нийт хөндлөн огтлолын талбай, урсгалтын хязгаарын утгыг гараас оруулна. Тодорхойгүй тохиолдолд хоосон орхиж болно.

■ Бүтээлийн газар хөдлөлт гэсвэрлэлийн индекс I_s						
Барилгын давхрын тоо	n	=	9			
Барилгын урт (м)		=	23.7	(м)		
Барилгын өргөн (м)		=	12.68	(м)		
Цутгамал төмөр бетон барилгын үндсэн хувийн хэлбэлзлийн үе	T_j	=	Хамгийн бага утга	0.280	(сек)	
Барилгын буурь хөрсний газар хөдлөлийн шинж чанараар ангилсан зэрэг		=	II			
Барилгын хувийн хэлбэлзлийн нэгдүгээр хэлбэрт харгалзах динамик илтгэлцүүр	β_j	=	2.50			
Үнэлгээ хийж буй давхрын дугаар	i	=	1			
Үнэлгээ хийж буй болон түүнээс дээш давруудын нийт талбай	A_f	=	2704.64	(м ²)		
Барилгын нэгж талбайд ногдох босоо ачаа	w	=	12	(кН/м ²)		Хялбарчилсан үнэлгээнд $w = 12$ кН/м ² гэж авна.
Тухайн давхраас дээш давруудаас ирэх нийт босоо ачаа	ΣW	=	32455.73	(кН)		
Хэвтээ чиглэл дэх уулзварын тооцонд ашиглах арматурын нийт хөндлөн огтлолын талбай	ΣA_h	=		(мм ²) =	0	(м ²)
Арматурын урсгалтын хязгаар	σ_y	=		(Н/мм ²) =	0	(кН/м ²)

Зураг 3.2.2-2 Барилгын мэдээллийг оруулах хэсэг

(3) Даацын хануудын мэдээллийг оруулах хэсэг

Даацын хануудын мэдээллийг оруулах хэсгийг зураг 3.2.2-3-т үзүүлэв.

- Барилгын үнэлгээ хийх чиглэлийг гараас оруулна. Аль чиглэлийн үнэлгээг хийж байгааг энэ нүднээс харах зориулалттай.
- Даацын ханын дугаар тус бүрээр мэдээллийг оруулна.
 - Ханын тэмдэглэгээ, рамын дугаарыг гараас оруулна.
 - Хана тус бүрийн зузаан, урт, тоог гараас оруулна.
 - Үр дүнд нь хана тус бүрийн хөндлөн огтлолын талбай, огтлолцсон ханаас хамааран ихэсгэх илтгэлцүүр, шилжисхийлтийн эсэргүүцэл автоматаар бодогдно.

Үнэлгээ хийж буй угсармал хавтгаалжин даацын хана		Ханын зузаан	Ханын урт	Ханын тоо	Ханын хөндлөн огтлолын талбай	Огтлолцсон ханын нөлдөөг тооцсон илтгэлцүүр	Тооцонд ашиглах ханын шилжисхийлтийн эсэргүүцэл	Ханын хүлээж авах хөндлөн хүч
Тэнхлэгийн дугаар	Ханын тэмдэглэгээ	t (м)	L (м)	N	A_{hj} (м ²)	α_j	τ_{hj} (кН/м ²)	$\Sigma \tau_{hj} A_{hj}$ (кН)
А	WA1	0.100	2.400	1	0.2400	1.25	1250.0	300.00
	WA2	0.100	1.600	2	0.3200	1.96	1960.0	627.20
	WA3	0.100	2.000	2	0.4000	1.77	1768.0	707.20
	WA4	0.100	1.650	1	0.1650	1.93	1930.9	318.60
	WA5	0.100	1.300	1	0.1300	2.18	2181.5	283.60
	WA6	0.100	1.510	1	0.1510	2.02	2017.2	304.60
В	WB1	0.160	0.600	1	0.0960	1.00	1000.0	96.00
	WB2	0.160	1.000	1	0.1600	1.57	1568.8	251.00
	WB3	0.160	0.880	1	0.1408	2.68	2500.0	352.00
	WB4	0.160	0.780	1	0.1248	1.50	1500.0	187.20
	WB5	0.160	8.720	1	1.3952	1.32	1321.1	1843.20
	WB6	0.160	4.980	1	0.7968	1.32	1317.3	1049.60
	WB7	0.160	2.760	1	0.4416	1.66	1659.4	732.80

Зураг 3.2.2-3 Даацын ханын тооцооны хэсэг

(4) Огтлолцсон ханын тооцоо

Огтлолцсон ханын тооцооны хэсгийг зураг 3.2.2-4-т үзүүлэв.

- Тооцож буй даацын ханын дугаар тус бүрээр мэдээллийг оруулна.
 - Ханын тэмдэглэгээ, рамын дугаарыг гараас оруулна.
 - Хана тус бүрийн зузаан, урт, тоог гараас оруулна.
 - Огтлолцсон хана (4 хүртэл) тус бүрийн зузаан, урт, зэргэлдээ хана хүртлэх зайг гараас оруулах ба огтлолцсон хануудын тооцооны урт автоматаар бодогдоно.
 - Тооцож буй ханатай огтлолцсон ханын тоо 4-өөс олон тохиолдолд оролцоо багатай огтлолцсон хана (урт нь богино, зузаан нь нимгэн хана)-ыг орхино.
 - Дээрх өгөгдлүүдийг оруулсанаар огтлолцсон ханаас хамаарах тооцож буй ханын шилжисхийлтийн эсэргүүцлийг ихэсгэх илтгэлцүүр, огтлолцсон хануудын ашигтай талбай, огтлолцсон хануудын хөндлөн огтлолын талбайнууд тус тус бодогдон гарна.
- Дээрх өгөгдлүүдийн үр дүнд тооцож буй чиглэл дэх даацын хануудын болон огтлолцсон хануудын хөндлөн огтлолын талбайнууд бодогдоно.

Үнэлгээ хийж буй угсармал хавта алжин даацын хана		Огтлолцсон угсармал хавта алжин даацын хануудын өгөгдөл										Огтлолцсон ханын шилжисхийлтийн эсэргүүцлийг ихэсгэх илтгэлцүүр	Огтлолцсон ханын тооцоонд орох хэсгийн хөндлөн огтлолын талбай	Огтлолцсон ханын нийт хөндлөн огтлолын талбай
Тэнхлэгийн дугаар	Ханын тэмдэглэгээ	Огтлолцсон хана 1				Огтлолцсон хана 2				Ханын зузаан	Ханын урт			
		Ханын зузаан	Ханын урт	Зэргэлдээ хана хүртлэх зай	Ханын тооцоонд орох урт	Ханын зузаан	Ханын урт	Зэргэлдээ хана хүртлэх зай	Ханын тооцоонд орох урт					
		(м)	Ц(м)	(м)	Л(м)	(м)	Ц(м)	(м)	Л(м)	(м)	a_i	$A_{oi}(m^2)$	$A_{oi}(m^2)$	
А	WA1	0.100	2.400	5.220	0.600				0.000		1.25	0.0600	0.2400	
	WA2	0.160	3.300	5.220	0.960				0.000		1.96	0.1536	0.4176	
	WA3	0.160	3.300	5.220	0.960				0.000		1.77	0.1536	0.4176	
	WA4	0.160	3.300	5.220	0.960				0.000		1.93	0.1536	0.4176	
	WA5	0.160	5.220	5.220	0.960				0.000		2.18	0.1536	0.4176	
	WA6	0.160	5.220	5.220	0.960				0.000		2.02	0.1536	0.4176	
В	WB1				0.000				0.000		1.00	0.0000	0.0000	
	WB2	0.100	0.720	5.220	0.600	0.100	0.310	1.720	0.310		1.57	0.0910	0.1030	
	WB3	0.160	0.620	5.220	0.620	0.160	1.720	1.720	0.860		2.68	0.2368	0.2368	
	WB4	0.160	0.780	0.780	0.390				0.000		1.50	0.0624	0.0624	
	WB5	0.160	0.920	5.220	0.920	0.160	5.220	5.220	0.960	0.160	1.32	0.4480	0.7120	
	WB6	0.160	0.620	5.220	0.620	0.160	5.220	5.220	0.960		1.32	0.2528	0.5168	
	WB7	0.160	5.220	5.220	0.960	0.160	1.720	1.720	0.860		1.66	0.2912	0.5552	
Тооцож буй чиглэлийн даацын ханын нийт хөндлөн огтлолын талбай		Огтлолцсон ханын тооцоонд орох хөндлөн огтлолын талбай		Огтлолцсон ханын нийт хөндлөн огтлолын талбай		Даацын ханын нийт хөндлөн огтлолын талбай								
$A_{oi}(m^2)$		$A_{oi}(m^2)$		$A_{oi}(m^2)$		$A_{oi}(m^2)$								
8.80		4.50		9.6332		18.44								

Зураг 3.2.2-4 Огтлолцсон ханын тооцооны хэсэг

(5) Материалын бат бэхийг оруулах ба Бүтээцийн газар хөдлөлтийн суурь индекс E_0 -ийн тооцоо

Материалын бат бэхийг оруулах ба Бүтээцийн газар хөдлөлтийн суурь индекс E_0 -ийн тооцоо хэсгийг зураг 3.2.2-5-т үзүүлэв.

- Бетоны шахалтын бат бэхийг гараас шууд оруулах ба үр дүнд нь бат бэхээс хамаарсан засварлах илтгэлцүүр β_c автоматаар бодогдно.

- Даацын хана, хэвтээ чиглэл дэх уулзварын бат бэхийн индекс C болон үнэлгээ хийж буй давхрын дугаараас хамаарах хөндлөн хүчийг хувиарлах илтгэлцүүрүүд автоматаар бодогдоно.
- Дээрх өгөгдлүүдийн үр дүнд бүтээцийн газар хөдлөлтийн суурь индекс E_0 автоматаар бодогдно.

Бат бэхийн индексийг тооцох		
C_w	$= \sum(\tau_{wy} \cdot A_{wy}) / \sum W$ (4.3)	0.478
C_b	$= 0.7(\sum A_n \sigma_y) / \sum W + 0.7(A_{wo} + A_{wo}) / \sum A_w$ (4.3)	0.505
		0.478

F_c	25	(Н/мм ²)	if $F_c > 20: \sqrt{F_c/20}$,
β_c	1.12		if $F_c \leq 20: F_c/20$

Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн суурь индексийг тооцох		
E_0	$= (n+1)/(n+i) \cdot C_w \cdot F$ (4.1)	0.478

$(n+1)/(n+i)$	1.00
---------------	------

Зураг 3.2.2-5 Материалын бат бэхийг оруулах ба Бүтээцийн газар хөдлөлтийн суурь индекс E_0 -ийн тооцох хэсэг

(6) Үнэлгээний үр дүн

Үнэлгээний үр дүнг харуулах хэсгийг зураг 3.2.2-6-г үзүүлэв.

- Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс I -ийн тооцоход шаардлагатай индекс (суурь индекс E_0 , хэлбэрийн индекс S_D , насжилтын индекс T , динамик илтгэлцүүрээс хамаарах утга $1/\beta_1$)-үүд харагдах бөгөөд хэлбэрийн индекс S_D болон насжилтын индекс T нь тусдаа sheet-ээр тооцсон үр дүнгээс автоматаар орж ирнэ.
- Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс I_s нь дээрх индексүүдийн үржвэрээр илэрхийлэгднэ.
- Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс I_s болон хязгаарын индекс I_{s0} -ийн харьцаанаас үнэлгээний үр дүн автоматаар илэрхийлэгдэнэ.

■ Үр дүн						
E_0	0.478	$\gg I_s = E_0 \cdot S_D \cdot T \cdot (1/\beta_1) =$	0.108	\geq	$I_{s0} =$ 0.10	Тэсвэргэй
S_D	0.708					
T	0.800					
$1/\beta_1$	0.400					

Зураг 3.2.2-6 Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний үр дүнг харуулах хэсэг

(7) Хэлбэрийн индекс S_D , насжилтийн индекс T -г тооцох

Хэлбэрийн индекс S_D , насжилтийн индекс T -г тооцоог тус гарын авлагын 3.2.1(6), (7) бүлэгтэй адилаар тооцно.

3.2.3 Өрөгт барилгын үнэлгээ

Өрөгт барилгын үнэлгээнд хавсарлт дах эксел файлыг ашиглана. Экселийн файл нь үнэлгээний үр дүнг тооцох sheet (давхар, чиглэл тус бүрээр сорь хийх замаар бодолтыг хийнэ), Хэлбэрийн индексийг тооцох sheet, насжилтын индексийг тооцох sheet, төсөллөлтийн үеийн хөндлөн хүчний тооцох sheet-үүдээс бүрдэнэ.

(1) Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн хязгаарын индекс I_{s0} -ийг тооцох

Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс I_{s0} -ийг тооцох хэсгийг зураг 3.2.1-1-т үзүүлэв.

Үнэлгээ хийх барилгын талбайн газар хөдлөлтийн баллыг сонгох бөгөөд “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” /БНБД 22-01-01*/2006/-ын дагуу тухай баллд харгалзах А илтгэлцүүрийн утга нь бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн хязгаарын индекс I_{s0} –ын утга болж автоматаар тооцогдоно.

Барилгын талбайн тооцооны газар хөдлөлтийн балл		7
Барилгын талбайн тооцооны газар хөдлөлтийн балл аас хамаарах илтгэлцүүр	A=	0.1
	I_{s0} =	0.10

Зураг 3.2.3-1 Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн хязгаарын индексийг тооцох хэсэг

(2) Барилгын мэдээллийг оруулах хэсэг

Барилгын мэдээллийг оруулах хэсгийг зураг 3.2.3-2-т үзүүлэв.

- Барилгын мэдээлэлд давхрын тоог сонголтоор оруулна.
- Барилгын урт, өргөнийг гараас оруулна.
- Барилгын талбайн хөрсний зэргийг сонгох боловч өрөгт барилгын хувьд нормын спектр муруйнд харгалзах динамик илтгэлцүүрийн утгыг тогтмол 2.5-аар авна.
- Үнэлгээ хийж буй давхар (Газраас дээших давхар)-ын дугаарыг гараас оруулна. Үр дүнд нь тухайн давхраас дээших барилгын талбай бодогдоно.
- Нэгж талбайд ногдох барилгын жинг гараас оруулна. Өрөгт барилгын хувьд 20 кН/м²-аар тооцож болно. Үр дүнд нь тухайн давхрын хүлээж авч байгаа нийт босоо ачаа бодогдоно.

Барилгын давхрын тоо	n	=	4	
Барилгын урт (м)		=	72	(м)
Барилгын өргөн (м)		=	12	(м)
Барилгын буурь хөрсийг газар хөдлөлтийн шинж чанараар ангилсан зэрэг		=	II	
Барилгын хувийн хэлбэлзлийн нэгдүгээр хэлбэрт харгалзах динамик илтгэлцүүр	β_I	=	2.50	
Үнэлгээ хийж буй давхрын дугаар	i	=	1	
Үнэлгээ хийж буй болон түүнээс дээш давруудын нийт талбай	A_i	=	3456.00	(м ²)
Барилгын нэгж талбайд ногдох босоо ачаа	w	=	16.2	(кН/м ²)
Тухайн давхраас дээш давхруудаас ирэх нийт босоо ачаа	ΣW	=	55987.20	(кН)

Хялбарчилсан үнэглээнд $w=20$ кН/м² гэж авна.

Зураг 3.2.3-2 Барилгын мэдээллийг оруулах хэсэг

(3) Барилгын даацын элементүүдийн мэдээллийг оруулах

Даацын хануудын мэдээллийг оруулах хэсгийг зураг 3.2.3-3-т үзүүлэв.

- Барилгын үнэлгээ хийх чиглэлийг гараас оруулна. Аль чиглэлийн үнэлгээг хийж байгааг энэ нүднээс харах зориулалттай.
- Даацын ханын дугаар тус бүрээр мэдээллийг оруулна.
 - Ханын тэмдэглэгээ, рамын дугаарыг гараас оруулна.
 - Ханын төрлийг сонголтоор оруулах харгалзах ханын зузаан нь түүний баруун талын нүдэнд гарна.
 - Ханын урт, тоо, зэргэлдээ нээлхийн өндөр (2 талдаа нээлхийтэй тохиолдолд өндөр талыг оруулна)-ийг гараас оруулна.
 - Үр дүнд нь хана тус бүрийн хөндлөн огтлолын талбай, нээлхийн өндөр ба ханын уртын харьцаа, нээлхийг бодолцсон бууруулах илтгэлцүүр, ханын шилжисхийлтийн эсэргүүцэл, хүлээж авч чадах хөндлөн хүч автоматаар бодогдоно.
- Тооцож буй чиглэл дэх бүх даацын ханын мэдээллийг оруулсаны дараа тухай нийт хөндлөн огтлолын талбай болон хүлээж авч чадх нийт хөндлөн хүч хүснэгтийн доод буланд тооцогдон гарна.

Үнэлгээ хийж буй өрөгт хана		Ханын зузаан	Ханын урт	Ханын тоо	Ханатай зэргэлдээ нэлхийн өндөр	Ханын хөндлөн огтлолын талбай	Нээлхийн өндөр ба ханын уртын харьцаа	Нээлхийг бодролсон бууруулах илтэлшүүр	Өргийн шилжинсхийлт (таслагдах)-ийн эсэргүүцэл	Ханын хүлээж авах хөндлөн хүч	
Ханын байршил	Ханын тэмдэглэгээ	t(m)	L(m)	N	h(m)	$A_w(m^2)$	h/L	α	$\tau_w(N/mm^2)$	$Q_u = \alpha \cdot \tau_w \cdot A_w (kH)$	
Дагуу тэнхлэг	Хөндлөн тэнхлэг										
A	1	EW64	0.64	2.015	1	1.750	1.2896	0.87	1.00	0.50	649.15
A	3	EW64	0.64	2.425	1	1.750	1.5520	0.72	1.00	0.50	781.24
A	3-4	EW64	0.64	0.880	1	2.550	0.5632	2.90	0.10	0.50	28.99
A	4	EW64	0.64	2.425	1	1.750	1.5520	0.72	1.00	0.50	781.24

• • • •

C	4	EW64	0.64	3.960	1	1.960	2.5344	0.49	1.00	0.50	1275.75
C	5-16	EW64	0.64	0.960	18	1.960	11.0592	2.04	0.96	0.50	5334.96
C	16	EW64	0.64	0.925	1	1.960	0.5920	2.12	0.88	0.50	262.56
						Нийлбэр	62.94				30965.34

Зураг 3.2.3-3 Даацын хануудын мэдээллийг оруулах хэсэг

(4) Материалын бат бэхийг оруулах ба Бүтээцийн газар хөдлөлтийн суурь индекс E_0 -ийн тооцоо

Материалын бат бэхийг оруулах ба Бүтээцийн газар хөдлөлтийн суурь индекс E_0 -ийн тооцох хэсгийг зураг 3.2.3-4-т үзүүлэв.

- Тооцож буй чиглэл дэх даацын ханын нийт хөндлөн огтлолын талбай бодогдсон байна.
- Баруун нүдэнд нь тооцож буй чиглэлтэй перпендикуляр чиглэл дэх даацын хануудын нийт хөндлөн огтлолын талбайг гараас оруулна.
 - Тооцож буй чиглэлтэй перпендикуляр чиглэл дэх тооцооны sheet-ээс утгыг авч оруулна.
 - Хучилтын чиглэлийг бодолцожу оруулах шаардлагатай.
- Тухайн давхрын нийт даацын ханын хөндлөн огтлолын талбай гарна.
- Өргийн тоосгоны болон зуурмагийн маркаас хамааруулж “Өрөгт ба арматуурласан өрөгт бүтээц /БНБД 2.03.02-90/”-ээс шахалтын бат бэхийг гараас оруулах ба үр дүнд нь өргийн суналтын эсэргүүцэл, дагуу хүчдэл, хүлээж авч чадах хөндлөн хүч автоматаар бодогдно.
- Дээрх өгөгдлүүдийн үр дүнд бүтээцийн газар хөдлөлтийн суурь индекс E_0 автоматаар бодогдно.

Тооцож буй чиглэлийн даацын ханын нийт х/о талбай	Перпиндик уялр чиглэлийн ханын х/о талбай	Даацын ханын нийт х/о талбай
$A_w (m^2)$	$A_{we} (m^2)$	$\sum A_w (m^2)$
62.94	40.00	102.94

Тооцоонд ашиглах өрөгт бүтээцийн шалхалтын эсэргүүцэл	Тооцоонд ашиглах өрөгт бүтээцийн суналтын эсэргүүцэл	Даацын ханад үүсэх дагуу хүчдэл	Өргийн шилжисхийлт (таслагдах)-ийн эсэргүүцэл
$R (H/mm^2)$	$R_{сун}(H/mm^2)$	$\sigma_0(H/mm^2)$	$\tau_w (H/mm^2)$
2.84	0.284	0.54	0.50

Бат бэхийн индексийг тооцох

C	$= Q_u / \Sigma W$ (4.3)	0.553
-----	--------------------------	-------

Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн суурь индексийг тооцох

E_0	$= (n+1)/(n+i) \cdot C \cdot F$ (4.1)	0.553	$(n+1)/(n+i) =$	1.00
-------	---------------------------------------	-------	-----------------	------

Зураг 3.2.3-4 атериалын бат бэхийг оруулах ба Бүтээцийн газар хөдлөлтийн суурь индекс E_0 -ийн тооцох хэсэг

(5) Үнэлгээний үр дүн

Үнэлгээний үр дүнг харуулах хэсгийг зураг 3.2.3-5-г үзүүлэв.

- Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс I -ийн тооцоход шаардлагатай индекс (суурь индекс E_0 , хэлбэрийн индекс S_D , насжилтын индекс T , динамик илтгэлцүүрээс хамаарах утга $1/\beta_1$)-үүд харагдах бөгөөд хэлбэрийн индекс S_D болон насжилтын индекс T нь тусдаа sheet-ээр тооцсон үр дүнгээс автоматаар орж ирнэ.
- Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс I_s нь дээрх индексүүдийн үржвэрээр илэрхийлэгднэ.
- Бүтээцийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн индекс I_s болон хязгаарын индекс I_{s0} -ийн харьцаанаас үнэлгээний үр дүн автоматаар илэрхийлэгдэнэ.

■ Үр дүн						
$E_0 =$	0.553	$I_s = E_0 \cdot S_D \cdot T \cdot (1/\beta_1) =$	0.113	\geq	$I_{s0} =$ 0.10	Тэсвэртэй
$S_D =$	0.637					
$T =$	0.8					
$1/\beta_1 =$	0.40					

Зураг 3.2.3-5 Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний үр дүнг харуулах хэсэг

(6) Хэлбэрийн индекс S_D , насжилтийн индекс T -г тооцох

Хэлбэрийн индекс S_D , насжилтийн индекс T -г тооцоог тус гарын авлагын 3.2.1(6),

(7) бүлэтэй адилаар тооцно.

4-р бүлэг. Хүчитгэл

4.1 Өмнөх сургалтад ашигласан материалууд

Төслөөс зохион байгуулсан сургалтууд ашигласан файлуудыг хүснэгт 3.1-1 болон 3.1-2-т үзүүлэв. Файлуудын нэрс нь сургалтын хөтөлбөртэй уялдуулсан бөгөөд хамгийн эхний цифр нь сургалтын өдрийн дугаар, зураасны дараах үсэг нь А бол үдээс өмнө, Р бол үдээс хойш, түүний дараах тоо нь дарааллыг заана. Материалын хэл нь М бол Монгол хэл, Е бол Англи хэл, J бол Япон хэл дээр байгааг илэрхийлнэ.

Эдгээр файлуудын электрон хувилбар нь ОБЕГ-т хадгалагдаж байгаа болно.

Хүснэгт 3.1-1 Барилгын хүчиитгэлийн тухай сургалтад ашигласан файлууд

File Name	Language	File Type
1-A1.Policy of MCUD	M	Power Point
1-A2.Introduction of new BDs	M	Power Point
1-A3.Policy of NEMA	M	Power Point
1-A4.Seismic Diagnosis in UB	M	Power Point
1-A5.Regulation about Seismic diagnosis	M	Word
1-A6.Seismic Evaluation&Retrofit in Japan	M/J	Power Point
1-P1.1st&2nd level diagnosis	M/J	Power Point
1-P2.Seismic equipment	M	Power Point
1-P3.Equipmenti&Seismic Diagnosis	M	Power Point
2-A1.Lecture of 2nd level diagnosis of RC	M	Power Point
2-A2.Exercise of 2nd level diagnosis of RC(1)-(4)	M	Excel
2-P1.Lecture of 2nd level diagnosis of PC	M	Power Point
2-P2.Exercise of 2nd level diagnosis of PC	M	Excel
3-A1. Outline of retrofit	M/J	Power Point
3-A2.Lecture of Retrofit_RC	M	Power Point
3-A3.Explanation of Retrofit_RC	M	PDF
3-P1.Lecture of Retrofit_PC	M	Power Point
3-P2.Explanation of Retrofit_PC	M	PDF
3-P3_Masonry_Out plane	M/J	Excel
3-P4.Lecture of Retrofit_Masonry	M/J	Power Point
3-P5.Masonry RT drawings	M	PDF

2-1-2 Дэд бүтэц, ИШС-ний газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтын гарын авлага

Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт
тэсвэрлэлтийн үнэлгээний тухай сургалт зохион байгуулах гарын
авлага

ЖАЙКА төслийн баг болон 2-р ажлын хэсэг

Гарчиг

1-р бүлэг. Ерөнхий зүйл	1
1.1 Гарын авлагын зорилго	1
1.2 Гарын авлагын сайжруулах тухай	1
1.3 Гарын авлагыг хариуцах байгууллага	1
2-р бүлэг. Сургалтын хөтөлбөр	2
2.1 Сургалтын хөтөлбөрийн бүтэц	2
2.2 Сургалтаар багшлах багш нарыг сонгох	2
2.3 Сургалтад хамрагдах хүмүүсийг сонгох	2
2.5 Сургалтын хөтөлбөрийн жишээ	2
3-р бүлэг. Үнэлгээ	4
3.1 Өмнөх сургалтад ашигласан материал	4
3.2 Дэд бүтэц, ИШС-ний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний эксел файлыг ашиглах заавар	5
3.2.1 Газар хөдлөлтийн үед авто замд үүсэх эрсдэлийн үнэлгээ	5
3.2.2 Газар хөдлөлтийн үед гүүрэнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээ	6
3.2.3 Газар хөдлөлтийн үед ус хангамжийн сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээ	7
3.2.4 Газар хөдлөлтийн үед ариутгах татуургын сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээ	8
3.2.5 Газар хөдлөлтийн үед дулаан хангамжийн шугам сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээ	9
3.2.6 Газар хөдлөлтийн үед цахилгаан шугам сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээ	10
4-р бүлэг. Дүгнэлт	11

1-р бүлэг. Ерөнхий зүйл

1.1 Гарын авлагын зорилго

Дараах дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнүүдийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалын тухай сургалтуудыг зохион байгуулахад тус гарын авлагыг ашиглана.

- Авто зам
- Гүүр
- Ус хангамжийн сүлжээ
- Ариутгах татуургын сүлжээ
- Дулаан хангамжийн сүлжээ
- Цахилгаан хангамжийн шугам сүлжээ

1.2 Гарын авлагын сайжруулах тухай

Тус гарын авлага дах материалуудыг ашиглахдаа зохион байгуулахаар төлөвлөсөн сургалтын хөтөлбөртэйгээ уялдуулан агуулгыг нэмэх, хасах, засварлах замаар өөрчлөлт оруулж болно. Өөрчлөлт оруулсан тохиолдолд ОБЕГ-т мэдэгдэнэ.

1.3 Гарын авлагыг хариуцах байгууллага

Гарын авлагыг ОБЕГ хариуцан хадгалана.

2-р бүлэг. Сургалтын хөтөлбөр

2.1 Сургалтын хөтөлбөрийн бүтэц

Дэд бүтэц, ИШС-ний үнэлгээний сургалтыг зохион байгуулахдаа сургалтад хамрагдагсадын мэргэжил, ажлын туршлагыг харгалзан үзэж хөтөлбөрийг боловсруулна.

2.2 Сургалтаар багшлах багш нарыг сонгох

Багш нарыг сургагч багшийн сургалтад хамрагдсан хүмүүсээс сонгоно. Мөн цаашид сургагч багшийн сургалтыг зохион байгуулж сургагч багш болсон хүмүүсээс сонгож болно.

2.3 Сургалтад хамрагдах хүмүүсийг сонгох

Сургалтыг зохион байгуулах тал сургалтын зорилгоос хамаарч сургалтад хамрагдах хүмүүсийг сонгох бөгөөд тусгайлан шаардлага тавигдахгүй. Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа аргачлалуудыг аль болох ойлгуулахаар боловсруулахаас гадна хамрагдагсдын тоог тохиримжтой байдлаар байлгах шаардлагатай.

2.5 Сургалтын хөтөлбөрийн жишээ

Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний тухай сургалтын хөтөлбөрийн жишээг хүснэгт 2.5-1-т үзүүлэв. Хөтөлбөрт үдийн завсралга, цайны завсарлаг, дурсгалын зураг авхуулах хэсгүүийг хассан байгаа тул шаардлагатай бол оруулж болно.

Үдээс өмнөх лекц нь дэд бүтэц, ИШС-ний байгууламжийн газар хөдлөлтийн үеийн хохиролыг тайлбарлах бөгөөд сургалтад хамрагдагсадад үнэлгээний ач холбогдлыг ойлгуулахад оршино. Үдээс хойших хэсэгт шинээр боловсруулагдсан БД-ийн тухай тайлбарлаж тус дүрмийн агуулыг таниулна. Мөн аргачлалыг илүү дэлгэрэнгүй ойлгуулах үүднээс эксел файл ашиглаж дасгал ажиллана. Эксел файлын тухай дараагийн бүлэгт дэлгэрэнгүй тайлбарлана.

Хүснэгт 2.5-1 Дэд бүтэц, ИШС-ний байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний тухай сургалтын хөтөлбөрийн жишээ

Өдөр	Цаг	Сэдэв
1	Үдээс өмнө	Нээлтийн үг
		Япон улсад тохиолдож байсан газар хөдлөлтийн гамшиг ба Дэд бүтэц, ИШС-ний байгууламжийн хохирол
		Монгол Улсын Дэд бүтэц, ИШС-ний байгууламжийн тухай
	Үдээс хойш	Шинээр боловсруулсан БД-ийн танилуулга
		Дасгал ажил
		Дүгнэлт
		Гэрчилгээ гардуулах
		Хаалтын үг

3-р бүлэг. Үнэлгээ

3.1 Өмнөх сургалтад ашигласан материал

Төслөөс зохион байгуулсан сургалтуудад ашигласан файлуудыг хүснэгт 3.1-1 болон 3.1-2-т үзүүлэв. Файлуудын нэрс нь сургалтын хөтөлбөртэй уялдуулсан бөгөөд хамгийн эхний цифр нь сургалтын өдрийн дугаар, зураасны дараах үсэг нь А бол үдээс өмнө, Р бол үдээс хойш, түүний дараах тоо нь дарааллыг заана. Материалын хэл нь М бол Монгол хэл, Е бол Англи хэл, J бол Япон хэл дээр байгааг илэрхийлнэ.

Хүснэгт 3.1-1. Дэд бүтэц, ИШС-ний үнэлгээний сургалтад ашигласан файлууд

Файлын нэрс	Хэл	Файлын формат
1-A1.Past Damage to the Infra-Lifeline in Japan	М	Power Point
1-A2.Current situation of the Structures in Mongolia	М	Power Point
1-P1.Introduction of new BD	М	Power Point
1-P2 .Exercise of Seismic Evaluation	М	Power Point
1-P3 .Seismic evaluation sheet _Infralifeline	M/E	Excel
1-P4.Summary	М	Power Point

3.2 Дэд бүтэц, ИШС-ний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний эксел файлыг ашиглах заавар

Дэд бүтэц, ИШС-ний байгууламжийн газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний эксел файлуудыг хэрхэн ашиглах тухай тайлбар болно.

3.2.1 Газар хөдлөлтийн үед авто замд үүсэх эрсдэлийн үнэлгээ

Авто замын эрсдэлийн үнэлгээний эксел файлыг зураг 3.2.1-1-т үзүүлэв.

Өгөгдөл хэсэгт үнэлгээ хийж буй авто замын хөрсний зэрэг болон газар хөдлөлтийн эрчимийг сонголтоор оруулна. Хөрсний зэрэг болон баллыг сонгохдоо “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” /БНБД 22-01-01*/2006/-ийг ашиглаж болно.

Үр дүнгийн хэсэгт эвдрэх цэгийн тоо (Цэг/км) гарна. Сонгосон хөрсний зэрэг, газар хөдлөлтийн эрчимд харгалзах замын нийт уртыг эвдрэх цэгийн тоондоо үржүүлж тухай замд үүсэх нийт эвдрэх цэгийн тоог гаргана.

Өгөгдөл	Хөрсний зэрэг	БНБД 22.01.01*/2006	2-р зэрэг
	Газар хөдлөлтийн эрчим	МСК шаталбараар	8
Үр дүн	Эвдрэх цэгийн тоо	0.13	Цэг/км

Зураг 3.2.1-1 Авто замд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээг тооцох хэсэг

3.2.2 Газар хөдлөлтийн үед гүүрэнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээ

Гүүрийн эрсдэлийн үнэлгээний эксел файлыг зураг 3.2.2-1-г үзүүлэв.

Өгөгдөл оруулах хэсгийн эхний хэсэг нь хөрсний мэдээлэл бөгөөд хөрсний зэрэг, хөрсний шингэрэл болох магадлалыг сонголтоор оруулна. Дараагийн хэсэг нь гүүрийн хийцлэлтэй холбоотой хэсэг бөгөөд дам нурууны төрөл, тулах хэсэг, тулгуурын өндөр, алгаслалын тоо, ригелийн тулаас, суурийн төрөл, үндсэн материал зэргийг сонголтоор оруулна. Эцэст нь тухай гүүрийн байрлал дах газар хөдлөлтийн эрчмийг сонголтоор оруулна.

Сонголт тус бүрт харгалзах утгууд баруун талын нүдэнд гарч эдгээрийн үржвэр нь нийт оноо болж гарна. Нийт оноо хэд гарснаас хамаарч гүүрийн эвдрэлийн түвшинг тодорхойлдоно. Эвдрэлийн түвшин (А, В, С гэсэн 3 түвшинтэй) нь тайлбарын хамт харагдана.

Өгөгдөл		
Хөрсний зэрэг	2-р зэрэг	1.00
Хөрсний шингэрэлт болох магадлал	Тодорхойгүй	2.00
Дам нурууны төрөл	Үргэлж дамнуруут гүүр	2.00
Тулах хэсэг	Унахаас сэргийлсэн хамгаалалттай	0.60
Тулгуурын өндөр	10 м-ээс өндөр	1.70
Алгаслын тоо	1	1.00
Ригелийн тулаас	Богино (тулаасны урт (см)/алгасалын урт (м<1)	1.20
Суурийн төрөл	Pile bent	1.40
Үндсэн материал	Бусад	1.00
Газар хөдлөлтийн эрчим	11 ба түүнээс өндөр	3.90
Нийт оноо (=Оноо тус бүрийн үржвэр)		26.73
Үр дүн		
Эвдрэлийн түвшин	Түвшин В	
Тайлбар	Хэсэгчлэн эвдрэлд орно	

Зураг 3.2.2-1 Гүүрэнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээ

3.2.3 Газар хөдлөлтийн үед ус хангамжийн сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээ

Ус хангамжийн сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээний эксел файлыг зураг 3.2.3-1-г үзүүлэв.

Өгөгдөл хэсэгт хөрсний шингэрэлт болох магадлалыг сонголтоор оруулна. Дараа нь шугамын материалын төрөл, голчыг сонголтоор оруулна. Эцэст нь газар хөдлөлтийн эрчмийг сонгоно.

Дээрх өгөдлүүдийг оруулсанаар Стандадарт магадлал хэсэг автоматаар бодогдох эцсийн үр дүнг бодоход энэ утга хэрэглэгдэнэ.

Эцсийн үр дүн нь эвдрэх цэгийн тоо (км/цэг)-оор гарна. Сонгосон хөрсний зэрэг, газар хөдлөлтийн эрчимд харгалзах ус хангамжийн сүлжээний нийт уртыг эвдрэх цэгийн тоондоо үржүүлж тухай шугамд үүсэх нийт эвдрэх цэгийн тоог гаргана.

Ө г ө г д ө л			
Хөрсний шингэрэлт болох магадлал	Бага	2.00	[Cl]
Материал	Ширэм	1.70	[Cpd]
Голч	Тодорхойгүй		
Газар хөдлөлтийн эрчим	7	24.0	cm/s
Стандарт магадлал		0.01	[Rs]
Ү р д ү н			
Эвдрэх магадлал : Rsm		0.031	Points/km

Зураг 3.2.3-1 Ус хангамжийн сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээг тооцох хэсэг

3.2.4 Газар хөдлөлтийн үед ариутгах татуургын сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээ

Ариутгах татуургын сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээний эксел файлыг зураг 3.2.4-1-г үзүүлэв.

Өгөгдөл хэсэгт хөрсний нөлөөг бодолцсон хөрсний шингэрэлт болох магадлалыг сонголтоор оруулна. Дараа нь шугамын материалын төрлийг сонголтоор оруулж, эцэст нь газар хөдлөлтийн эрчмийг сонгоно.

Дээрх өгөгдлүүдийг сонголтоор оруулсанаар үр дүнг бодоход шаардлагатай утгууд гарах автоматаар бодогдоно.

Үр дүн нь эвдрэх магадлал (Шугамын уртад харгалзах эвдрэх шугамын урт: км/км)-аар гарна. Сонгосон хөрсний зэрэг, газар хөдлөлтийн эрчимд харгалзах ариутгах татуургын сүлжээний нийт уртыг эвдрэх магадлалдаа хувичилж тухайн сүлжээнд нийт эвдрэх уртыг гаргана. Ариутгах татуургын сүлжээний эвдрэл нь ус хангамж, дулаан хангамжын сүлжээ шиг эвдрэх цэгийн урт биш, эвдрэх шугамын уртаар гарахыг анхаарах шаардлагатай.

Ө г ө г д ө л			
Х ө р с н и й ш и н г э р э л т б о л о х м а г а д л а л	Б а г а		
М а т е р и а л	К е р а м и к		
Г а з а р х ө д л ө л т и й н э р ч и м	8	87.0	cm/s
Ү р д ү н			
Э в д р э х м а г а д л а л : Rsm	49.3	%	

Зураг 3.2.4-1 Ариутгах татуургын сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээг тооцох хэсэг

3.2.5 Газар хөдлөлтийн үед дулаан хангамжийн шугам сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээ

Дулаан хангамжийн сүлжээнд эвдрэл үүсэх эрсдлийн үнэлгээний эксел файлыг зураг 3.2.5-1-г үзүүлэв.

Өгөгдөл хэсэгт хөрснөөс хамаарах хэсэгт хөрсний шингэрэлт болох магадлалыг сонголтоор оруулна. Дараа нь шугамын материалын төрөл, голчыг сонголтоор оруулна. Эцэст нь газар хөдлөлтийн эрчмийг сонгоно. Дээрх өгөдлүүдийг оруулсанаар Стандадарт магадлал хэсэг автоматаар бодогдоно.

Эцсийн үр дүн нь эвдрэх цэгийн тоо (км/цэг)-оор гарна. Сонгосон хөрсний зэрэг, газар хөдлөлтийн эрчимд харгалзах дулаанхангажийн сүлжээний нийт уртыг эвдрэх цэгийн тоондоо үржүүлж тухай шугамд үүсэх нийт эвдрэх цэгийн тоог гаргана.

Өгөгдөл			
Хөрсний шингэрэлт болох магадлал	Өндөр	2.40	[C]
Материал	Ширэм	0.30	[Cpd]
Голч	300 мм - 500 мм		
Газар хөдлөлтийн эрчим	8	87.0	cm/s
Стандарт магадлал		0.15	[Rs]
Үр дүн			
Эвдрэх магадлал : Rsm		0.108	Цэг/км

Зураг 3.2.5-1 Ус хангамжийн сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээг тооцох хэсэг

3.2.6 Газар хөдлөлтийн үед цахилгаан шугам сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээ

Цахилгаан дамжуулах агаарын шугамын шонгийн эвдрэл үүсэх эрсдлийн үнэлгээний эксел файлыг зураг 3.2.6-1-г үзүүлэв

Өгөгдөл хэсэгт хөрсний шингэрэлт болох магадлал, газар хөдлөлтийн эрчмийг сонголтоор оруулна.

Үр дүн нь бетон болон модон шонгийн 100 ширхэг ногдох эвдрэх магадлал (%), цахилгаан дамжуулах агаарын болон газар доорх шугам 100 м-т ногдох эвдрэх магадлал (%) бодогдоно. Тухайн сонгосон өгөгдлөл дэх шонгуудын нийт тоо болон дамжуулах шугмуудын нийт уртуудаар үржүүлж эвдрэх шонгийн тоо болон эвдрэх шугмуудын уртыг гаргана.

Өгөгдөл	
Хөрсний шингэрэлт болох магадлал	Болохгүй
Газар хөдлөлтийн эрчим	9

Үр дүн	
Бетон шон	0.46 /100 ширхэг
Модон шон	0.19 /100 ширхэг
Агаарийн кабель	15 %/100 м
Газар доорх кабель	1.17 %/100 м

Зураг 3.2.5-1 Цахилгаан шугам сүлжээнд эвдрэл үүсэх эрсдэлийн үнэлгээг тооцох хэсэг

4-р бүлэг. Дүгнэлт

Тус гарын авлагыг өмнө нь зохион байгуулж байсан сургалтуудад ашигласан материалд тулгуурлан бөгөөд цаашид сургалт зохион байгуулах тохиолдолд ашиглах зорилгоор боловсруулсан болно.

Дээрх аргачлалуудын тухай сургалтад хамрагдасдын ойлголт гүнзгийрэхтэй зэргэцэн сургалтын хөтөлбөр болон материалуудыг өөрчлөн сайжруулах шаардлагатай.

**3: Шинэчлэн боловсруулсан улсын
болон орон нутгийн гамшгаас
хамгаалах төлөвлөгөөний төсөл
болон гамшгаас хамгаалах
төлөвлөгөө боловсруулах гарын
авлага**

Дархан-Уул аймгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө

Гарчиг

1. Дархан-Уул аймгийн танилцуулга
 - 1.1 Газар зүйн байдал
 - 1.2 Хүн ам, аж үйлдвэр
 - 1.3 Засаг захиргааны нэгж
 - 1.4 Дархан-Уул аймагт тохиолдож байсан гамшиг, тулгарч буй асуудал
2. Эрсдэлийн үнэлгээ
 - 2.1 Үндсэн чиглэл
 - 2.2 Эрсдэлийн үнэлгээний аргачлал
 - 2.3 Гамшгийн үүсч болзошгүй цагийн байдал боловсруулах
3. Үндсэн чиглэл
 - 3.1 Үндсэн чиглэл
 - 3.2 Салбар тус бүрийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний чиглэл
4. Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ
 - I. Барилга байгууламж, хот байгуулалт, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ
 - II. Гамшгаас хамгаалах хүн хүч, техник хэрэгсэл
 - III. Мэдээлэл, харилцаа холбоо
 - IV. Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж
 - V. Гамшгаас хамгаалах арга хэмжээ, хүч хэрэгсэл
 - VI. Боловсрол, олон нийт
5. Хөрөнгө санхүүжилт шийдвэрлүүлэх, түүний хяналт удирдлага
 - 5.1 Үндсэн чиглэл
 - 5.2 Салбар тус бүрийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний чиглэл

Дархан-Уул аймгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө

1. Дархан-Уул аймгийн танилцуулга


1961 оны 10 сарын 17-нд Дархан хотын анхны суурийн чулууг тавьсан бөгөөд Монгол улсын 2 дахь томоохон хот хэмээгдэн хөгжсөөр ирсэн. Дархан хотыг хуучин социалист орнууд болох Зөвлөлт Холбоот Улс, Болгар, Польш, Унгар, Чех, Зүүн Герман зэрэг улсуудын техник, эдийн засгийн хамтын ажиллагааны тусламжтайгаар бүтээн байгуулжээ. УИХ-ын 1994 оны 32 дугаар тогтоолоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Дархан хотыг Дархан-Уул аймаг болгон өөрчилсөн.

1.1 Газар зүйн байдал

Дархан-Уул аймаг нь Монгол орны хойд хэсэгт Хэнтийн нурууны салбар уулсын дунд Хараа голын зүүн хойд хөндийг хамарсан 327,5 мянган га газар нутагтай. Нийт газар нутгийн 70,7 хувь буюу 231,7 мянган га талбайг ХАА-н эдэлбэр газар эзэлдэг. Тус аймгийн газар нутгийн хэмжээ бага боловч алт, шохойн чулуу, нүүрс, барилгын материалын төрөл бүрийн түүхий эд зэрэг байгалийн баялгийн нөөц ихтэй.



Зураг 1. Дархан хотын газар зүйн байрлал
(эх сурвалж: mn.wikipedia.org)




Зураг 2. Дархан-уул аймаг, сумууд

Далайн түвшнээс 707 м өндөрт өргөгдсөн харьцангуй нам дор газарт байрлана. Тус аймгийн нутгаар Хэнтийн нуруунаас эх авч Орхон голд цутгадаг Хараа, Зулзага, Шарын гол, Ерөө, Орхон, Хүйтний, Хавчуун зэрэг голууд урсдаг. Хараа голд бусад жижиг услаг голууд голын эхэнд усаа нийлүүлдэг бөгөөд тус гол нь Дархан хот суурины усан хангамжийн (гадаргын болон гүний хэлбэрээр) шууд ба шууд бус эх үүсвэр болдог.

Тус аймаг нь Монгол орны газар зүйн мужлалын ой хээрийн, газар тариалангийн төв бүсэд багтдаг. Хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүнд газар тариалан голлодог. Нутгийн 22.4 хувийг ой, 71.0 хувийг ХАА-н эдэлбэр газар, 0.7 хувийг усны сан бүхий газар, 1.5 хувийг нөөц газар тус тус эзэлнэ.

Агаарын үнэмлэхүй их температур 7-р сард 42.6 °С, үнэмлэхүй бага температур нь 1-р сард -43.7 °С хүрдэг. Жилд дунджаар 310-320 мм хур тунадас ордогийн 85-90% буюу 284-290 мм тунадас дулааны улиралд унадаг. 2018 онд орсон хур тунадасны хэмжээг уур амьсгалын дундажтай харьцуулсаныг үзүүлэв.




Зураг 3. Дархан-Уул аймгийн хур тунадасны хэмжээ (2018он)

1.2 Хүн ам, аж үйлдвэр

(1) Хүн ам

Дархан-Уул аймаг нь 2019 оны байдлаар, нийт 30574 өрхийн 104,090 хүн амтай, үүнээс 86,651 хүн Дархан хотод амьдардаг. Үүнээс эмэгтэй 52,936, эрэгтэй 51,157 байна. Хүн ам зүйн судалгааг сум тус бүрээр харьцуулсаныг дор үзүүлэв. (эх сурвалж : Үндэсний статистикийн хороо)



Зураг 4. Дархан-Уул аймаг. Сумдаар хүн амын тоо (2000~2017он)


Суурин хүн амыг тоо, насны бүлгээр ангилсаныг доорхи хүснэгтээр үзүүлэв. Өндөр настны тоо 4.4% байгаа нь харьцангуй бага үзүүлэлт юм.

Хүснэгт 1. Дархан-Уул аймаг, 5насны бүлгээр, хүн амын тоо (эх сурвалж:Үндэсний статистикийн хороо)

Насны бүлгээр	2002	2007	2012	2017
Нийт хүн ам	87,375.	87,590.	93,939.	101,879.
0-4	5,654.	6,392.	9,195.	11,889.
5-9	7,424.	7,736.	7,176.	10,738.
10-14	10,627.	8,948.	7,478.	7,238.
15-19	10,443.	10,381.	8,362.	7,487.
20-24	8,152.	8,053.	10,476.	7,763.
25-29	7,064.	7,010.	8,749.	9,710.
30-34	7,026.	6,986.	7,862.	8,194.
35-39	7,578.	6,996.	7,497.	7,607.
40-44	6,537.	7,343.	6,576.	7,239.
45-49	5,441.	6,361.	6,357.	6,250.
50-54	3,558.	4,170.	5,000.	5,897.
55-59	2,574.	2,331.	3,250.	4,560.
60-64	2,057.	1,587.	2,054.	2,844.
65-69	1,349.	1,489.	1,481.	1,719.
70+	1,891.	1,807.	2,426.	2,744.

Хүн амын өсөлт бууралт			
	2002-2007	2007-2012	2012-2017
Нийт хүн ам	1.002	1.072	1.085
0-4	1.131	1.439	1.293
5-9	1.042	0.928	1.496
10-14	0.842	0.836	0.968
15-19	0.994	0.806	0.895
20-24	0.988	1.301	0.741
25-29	0.992	1.248	1.110
30-34	0.994	1.125	1.042
35-39	0.923	1.072	1.015
40-44	1.123	0.896	1.101
45-49	1.169	0.999	0.983
50-54	1.172	1.199	1.179
55-59	0.906	1.394	1.403
60-64	0.772	1.294	1.385
65-69	1.104	0.995	1.161
70+	0.956	1.343	1.131

Статистикээс харахад Дархан-Уул аймагт хөдөлмөр эрхлэлдэг хүн 31,526 (2018 оны байдлаар) бөгөөд хүйсийн хувьд 16,816 эрэгтэй, 14,710 эмэгтэй тоологдсон. Доорх графикаар хөдөлмөр эрхлэлтийг эдийн засгийн салбараар харуулав. (Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо)



Зураг 5. Дархан-Уул аймаг, Хөдөлмөр эрхлэлтийн эдийн засгийн салбар

(2) Аж үйлдвэр

○ Мал аж ахуй : 2018 оны мал тооллогын дүнгээр 306014 толгой мал тоологдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 1.6 хувиар буурсан. Үүнд: адуу 17,660, үхэр 44,260, тэмээ 60, хонь 147,060, ямаа 96,970 толгой мал тус тус эзэлж байна.

Нийт тоологдсон малын 98.7 хувийг амины мал, үлдсэн хувь нь аж ахуйн нэгж байгууллагын эзэмшилд байна. Мал тооллогоор тоологдсон малын тоо сумдаар: Дархан сум 68362, Хонгор сум 165314, Орхон сум 41769, Шарын гол сум 30,569 толгой мал байна. 2018 оны мал тэжээвэр амьтдын тооллогоор 1135 гахай, 9476 шувуу, 2376 бүл зөгий, өрхөд тэжээвэр цөөн тооны туулай зэрэг тус тус тоологджээ.

○ Газар тариалан : Дархан-Уул аймаг нь Монголын газар тариалангийн төв бүсэд оршдог учраас хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүнд газар тариалан голлодог бөгөөд газар тариалангийн аж ахуйнууд шинжлэх ухааны баазтайгаа ойрхон байрлаж, түүнтэй хамтран ажилладаг. Аймгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь хүн амын мах махан бүтээгдэхүүний хэрэгцээний 30%, сүү сүүн бүтээгдэхүүний 90%, гурил гурилан бүтээгдэхүүний 70% гаруй хувийг, төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээр бүрэн хангаж байгаа стратегийн ач холбогдол бүхий салбарын нэг юм.

2018 онд 20502.1 га-д тариалалт хийснээс ургамлын төрлөөр авч үзвэл: үр тариа 11944.6 га, үүнээс улаан буудай 11396.6 га, төмс 603.31 га, хүнсний ногоо 1268.24 га, малын тэжээл 2503.7 га, рапс 4182.2 га-д тариалжээ. Өмнөх жилтэй харьцуулахад тариалсан талбай 2026 га-р буурсан байна.

○ Үйлдвэрлэл ба эрчим хүчний байгууламж : Дулааны цахилгаан станц, 220/110 / 35 кВ-ын дулааны цахилгаан станц бүхий дулаан хангамжийн сүлжээтэй. Төмөр, гангийн үйлдвэр, цементийн үйлдвэр, хүнд машин механизм, арьс шир боловсруулах үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр, мах, махан

бүтээгдэхүүний агуулах, химийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, нефть бүтээгдэхүүний агуулах зэрэг төвлөрч байна.

Доорх хүснэгтэд Дархан-Уул аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтийг (2017он) үзүүлсэнийг харуулав. (Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо)

Хүснэгт 2. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт (2017он), сая төгрөгөөр

№	Салбар	Дархан-Уул аймаг	Улсын хэмжээнд
1	Газар тариалан, мал аж ахуйн салбарын нийлбэр	34,800.8	2,842,724.3
1.1	Газар тариалан	15,157.8	216,704
1.2	Мал аж ахуйн	19,499.2	2,591,320.7
1.3	Хөдөө аж ахуй болон бусад	143.9	34,699.6
2	Аж үйлдвэр ба уул уурхайн нийт үйлдвэрлэл	188,913.2	11,527,012.1
2.1	Уул уурхай	51,347	6,761,188.3
2.2	Үйлдвэрлэл	75,910.3	2,939,000.1
2.3	Цахилгаан эрчим хүч, ус, бохир ус, нийтийн үйлчилгээ	54,168	692,252.1
2.4	Барилга	7,488	1,134,571.7
3	Үйлчилгээний салбарын нийт	197,720.8	13,525,787.7
3.1	Худалдаа, Зочид буудал, Ресторан, Зоогийн газар	58,639.9	4,723,865.6
3.2	Тээвэр, Мэдээлэл, харилцаа холбоо	13,170.8	1,924,686.4
3.3	Санхүү, худалдаа арилжаа	50,949.4	3,823,847.5
3.4	Бусад үйлчилгээ	74,960.6	3,053,388.3

1.3 Засаг захиргааны нэгж

Засаг захиргааны нэгжийн хувьд Дархан, Орхон, Шарын гол, Хонгор гэсэн 4 сум 24 багаас бүрддэг. Зүүн, зүүн урд талаараа Сэлэнгэ аймгийн “Баянгол” сум, баруун хойд талаараа Сэлэнгэ аймгийн “Номгон” сум хойд зүүн талаараа Сэлэнгэ аймгийн Жавхлан, Ерөө сумын нутагтай хиллэдэг.

Аймгийн төв Дархан хот нь Монгол Улсын томоохон аж үйлдвэрийн төв юм. Дэд бүтэц сайн хөгжсөн, Улаанбаатар-Алтанбулагийн чиглэлийн олон улсын авто зам, Улаанбаатар-Сүхбаатарын олон улсын төмөр замын зангилаан дээр оршдог, төвийн эрчим хүчний системд холбогдсон, өндөр хурдны шилэн кабель, тоон системийн радио релейны шугам, хөдөлгөөнт холбооны үйлчилгээтэй.

Нийслэл болон бусад аймаг, сумын төвөөс Дархан – Улаанбаатар 220 км, Дархан – Сэлэнгэ 100 км, Дархан – Эрдэнэт 180 км, Дархан – Орхон 45 км, Дархан – Хонгор 25 км, Дархан – Шарын гол 75 км.

1.4 Дархан-Уул аймагт тохиолдож байсан гамшиг, тулгарч буй асуудал

Ойрын жилүүдэд хор хөнөөл учруулсан газар хөдлөлтийн гамшиг тохиолдоогүй боловч Дархан-Уул аймаг нь газар хөдлөлтийн / 7-8 баллын / идэвхитэй бүсэд орших ба 1980-аад оноос өмнө баригдсан хуучин барилгуудад газар хөдлөлтийн нөлөөллийн инженерийн тооцоололгүй баригдсан барилгууд байдаг. Иймээс эдгээр хуучин барилга болон чанар муутай баригдсан барилга байгууламж, өндөр барилга, үйлдвэрийн яндан зэрэг объектуудих хэмжээгээр эвдэрч, сүйрч олон хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулан, орон нутгийн хүн амын амжиргаа болон албан газруудын хэвийн үйл ажиллагаа, улмаар улс орны эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаанд тодорхой хүндрэл үүсгэж, дарамт учруулж, хямрал үүсгэх эрсдэлтэй.

Газар хөдлөлтийн хүч цаг улирлын байдал, Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн хүчин чадлаас шалтгаалан аймгийн нутгийг өөрийн хүчээр аврах, сэргээн босгох хэвийн үйл ажиллагааг хангах боломж хязгаарлагдмал байх болно.

Хэнтийн уулсаас эх аван урсдаг Хараа гол аймгийн төвийн баруун талаар 56 км газар нутгийг дайран өнгөрч Орхон голд цутгадаг. Харин 06-р сарын сүүлч 7, 8-р сард жилийн хур тунадасны ихэнх нь бууж усны түвшин нэмэгддэг тул гол ихэнхдээ үерийн байдалтай байдаг. Зуны улиралд иргэд аялал зугаалга, амралтын өдрүүдээ голын эрэг орчимд өнгөрөөх нь ихсэх ба үүнээс үүдэлтэй хүүхэд, насанд хүрэгчид усанд живж амь насаа алдах тохиолдол их байна.

Сүүлийн 10 жилийн судалгаагаар 15 хүн Хараа голд живж амь насаа алдаад байгаа нь цаашид үер, усны аюулаас ард иргэдийг сэрэмжлүүлэх, хамгаалах ажлын зохион байгуулалтыг Аймгийн засаг захиргааны нэгж, Цагдаа, Онцгой байдлын алба, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар үр дүнтэй томоохон ажил зохиох шаардлагатай байна.

2. Эрсдэлийн үнэлгээ

2.1 Үндсэн чиглэл

Одоогийн байдлаар хийсэн судалгаа болон ажиглалтын үр дүнд үндэслэн ирээдүйд Дархан хотод үүсч болзошгүй газар хөдлөлтийн гамшгийн хохирлын ерөнхий дүр зургийг газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний үр дүнгээр харуулав.

Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний үр дүнд гаргасан хохирлын төсөөллийг дараах зүйлсийг сайтар ойлгосны үндсэн дээр ашиглах нь зүйтэй.

【Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийхэд анхаарах асуудал】

- Эрсдэлийн үнэлгээнд авч үзсэн газар хөдлөлтийн хүчийг БХБЯ-ны “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм”-д заасан газар хөдлөлтийн МСК шаталбарын дагуу 7 баллаар авав. Дархан хотод хохирол үүсгэж болзошгүй газар хөдлөлтийн хүч нь үүнээс ч илүү байх магадлалтай.
- Эрсдэлийн үнэлгээгээр тооцоолсон нийт нутаг дэвсгэрийн хохирлын цар хүрээ болон хохирол илүү гарах хэсэг нь газар хөдлөлтийн голомтын байршил, түүний чиглэлээс хамааран хэлбэлзэнэ. Үүний улмаас, бодит хохирол ба төсөөлөгдөх хохирлын нөхцөл байдал нь өөр өөр байх магадлалтайг харгалзаж үзэх хэрэгтэй.

2.2 Эрсдэлийн үнэлгээний аргачлал

Эрсдэлийн үнэлгээний аргачлал нь ОБЕГ-ын Ажлын хэсгийн боловсруулсан “Газар хөдлөлтийн хохирлыг хялбаршуулсан аргаар тооцох эксел хүснэгт”-ийг ашигласан болно. Уг эксел хүснэгтийн тооцооллын аргачлалыг ОБЕГ боловсруулсан бөгөөд одоогийн байдлаар ОБЕГ-ын даргаар батлуулах шатанд буй “Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний заавар”-т тусгагдсан газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний аргачлалд суурилсан болно.

(1) Газар хөдлөлтийн хүч

“Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм”-д заасан шаталбарын дагуу Дархан хотын газар хөдлөлтийн хүч нь VIII балл юм. Энэхүү газар хөдлөлтийн хүчийг ашигласан болно.

(2) Барилгын хохирол

Барилга байгууламжийг түүний зориулалтын дагуу орон сууц, эзэмшлийн орон сууц, олон нийтийн барилга, гэр болон бусад төрлийн орон сууц гэж ангилсан бөгөөд “Газар хөдлөлийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар”-т үндэслэн хуучин барилгыг газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн 13 зэргээр мөн ангилав. Газар хөдлөлтийн хүчийн баллыг оруулж газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн 13 зэрэг тус бүрийн хохирлын хувь тооцоологдох тул уг хувь хэмжээг барилгын тоо ширхэгт үржүүлж нурах болон ихээр эвдрэх барилгын тоог тооцоолж гаргав.

(3) Хүний хохирол

Нас барсан хүний тоо, гэмтсэн хүний тоог нурсан болон ихээр эвдэрсэн барилгад оршин сууж байсан өрхийн тооноос тооцоолж гаргав. Нийтийн орон сууц болон эзэмшлийн орон сууцанд оршин сууж буй өрхийн тоог тус бүр тооцож эксел хүснэгтэд оруулж тооцоо хийгдэнэ.

(4) Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ

Зам, гүүр, цэвэр ба бохир усны шугам, цахилгаан дамжуулах агаарын шугам болон цахилгааны шонгийн тухайд, тус бүрийн хөрсний байдал, гүүрийн төрөл, шугам хоолойн төрөл болон диаметр, хийц гэх зэрэг өгөгдлийг оруулж газар хөдлөлтийн улмаас үүсэх хохирлын хувь хэмжээг тооцоолж эвдрэл гарах цэгийн тоо болон шугамын уртыг гаргасан болно.

Эдгээр хохирлын тооцооллын дүнг Хүснэгт 2.1-д нэгтгэв.

Хүснэгт 2.1. Дархан хотын газар хөдлөлтийн үүсч болзошгүй хохирлын төсөөлөл

Хохирлын төрөл		Хохирлын хэмжээ	Нэгж
Хүний хохирол	Нас барсан хүний тоо	384	хүн
	Гэмтэж бэртсэн хүний тоо	477	хүн
	Гэр оронгүй болсон хүний тоо	6210	хүн
Барилгын хохирол	Нурсан, их хэмжээгээр эвдэрсэн	амины сууц	1809 ширхэг
		орон сууц	7 ширхэг
	Нурангийн хэмжээ	5400	тонн
Дэд бүтэц, ИШС	Зам	Нэвтрэх боломжгүй болсон	0 цэг
		Гүүр	А аргачлал (нурсан)
		В аргачлал (засварлах шаардлагатай)	байхгүй
	Цахилгааны шон	Нурсан	0 ширхэг
	Цахилгааны шугам	Хохирлын хувь	0.5 %
	Газар доорх шугам	Хохирлын хувь	0.1 %
	Цэвэр ус	Эвдэрсэн	8 цэг
	Бохир ус	Хохирлын хувь	19 %
	Дулаан	Эвдэрсэн	15 цэг

2.3 Гамшгийн үүсч болзошгүй цагийн байдал боловсруулах

Хохирлын төсөөлөл дээр үндэслэн 1. Хот төлөвлөлт, барилга байгууламж, дэд бүтэц, ИШС, 2. Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, 3. Байгаль орчин, 4. Гамшгаас хамгаалах арга хэмжээ, хүч хэрэгсэл, 5. Боловсрол, олон нийтийн оролцоо, 6. Мэдээлэл харилцаа, гэсэн салбаруудаар гамшгийн цагийн байдлыг боловсруулсан.

(1) Хот төлөвлөлт, барилга байгууламж, дэд бүтэц, ИШС

- ✓ 1816 ширхэг барилга нурсан ба ихээр эвдэрсэн, барилга нурсаны улмаас 384 хүн нас барах, 477 хүн бэртэж гэмтэх. Мөн, 6210 хүн гэр оронгүй болох.
- ✓ Сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон иргэдийн олноороо цуглардаг үзвэр, худалдаа үйлчилгээний газрын барилга байгууламжид ихээхэн хохирол үүсэх.
- ✓ Цэвэр усны шугамд 8 цэг дээр гэмтэл гарч 1200 гаруй хэрэглэгчийг цэвэр усаар хангах боломжгүй болох.
- ✓ Бохир усны шугам эвдэрснээс шалтгаалан хөрсний бохирдол үүсэх.
- ✓

(2) Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж

- ✓ Нэгдсэн эмнэлэг 2, өрхийн эрүүл мэндийн төв 5, эх нялхсын эмнэлэг гэх нийт 8 эмнэлэг байдаг

бөгөөд 477 бэртэж гэмтсэн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэхэд хүн хүч дутагдаж хүндрэл үүсэх.

- ✓ Эмчилгээний хэсэг (дотор, мэдрэл)-ийн 12, гэмтэл, мэс заслын 6, хүүхдийн 8 эмч болон эмнэлгийн ажилтан байгаа бөгөөд гэмтэж бэртсэн хүмүүст эмнэлгийн тусламж үзүүлэхэд хүн хүч дутагдаж хүндрэл үүсэх.
- ✓ Тоноглогдсон түргэн тусламжийн автомашинг байхгүйгээс шалтгаалан бэртэж гэмтсэн хүн болон бусад өвчтөнийг тээвэрлэхэд хүндрэл үүсэх.

(3) Байгаль орчин

- ✓ Бохир усны шугам эвдэрснээс шалтгаалан хөрс бохирдож, байгаль орчинд хор хөнөөл учруулах.
- ✓ 2 ширхэг сордог машинаар орон сууцны 150 айл өрхийн л бохирыг зайлуулах бөгөөд хүчин чадал дутагдах.
- ✓ Нурангийн хэмжээ 5400 тоннд хүрэх бөгөөд 10 тонны ачааны машинаар тооцоход 540 ширхэг/удаа рейс хийх шаардлагатай болно. Нуранги хаях зориулалтын цэгийг төлөвлөж тогтоогоогүй, нуранги зайлуулах ажил саатах.

(4) Гамшгаас хамгаалах арга хэмжээ, хүч хэрэгсэл

- ✓ Гамшгийн нөөц дутагдаж гамшигт нэрвэгдэгсдэд хүрэлцэхгүй болох.
- ✓ Эрэн хайх, аврах ангийн бие бүрэлдэхүүн, машин тоног төхөөрөмж хүрэлцэхгүй тул ажиллагаа явуулахад хүндрэл үүсэх.
- ✓ Гэр оронгүй болсон 6210 хүнийг түр хоргодох байранд багтаах хүчин чадал дутагдана. Түр хоргодох байр томилгоожуулсан боловч түр хоргодох байр болгож ашиглахад шаардлагатай техник тоног төхөөрөмж, түр хогодох байрын нөөц байхгүйгээс үйл ажиллагаа явуулах боломжгүй.

5) Боловсрол, олон нийтийн оролцоо

- ✓ 2017 оноос их, дээд сургуулиудад гамшгаас хамгаалах боловсрол олгох үйл ажиллагаа эхлээд удаагүй байгаа тул мэдлэг, мэдээлэл хомс байгаа тул түргэн тусламж үзүүлэх гэх зэрэг ажилд дэмжлэг үзүүлэх боломжгүй байх.
- ✓ Сургуулийн болон сургуулийн өмнөх боловсролын багш, сургагч нарт зориулсан “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөр хэрэгжиж эхлээд удаагүй байгаа тул сургуулийн орчинд хүүхдүүд олноор гамшигт нэрвэгдэх.
- ✓ Нүүлгэн шилжүүлэх дадлага сургууль явагдаагүй тул гамшигт нэрвэгдэгсэд нүүн шилжих явц удаашралтай, зохион байгуулалт муутай явагдах.

6) Мэдээлэл харилцаа

- ✓ Суурин болон үүрэн телефоны холбоо, факс, интернэтийн үйлчилгээ нь кабель шугам болон антенны эвдрэлээс болж ажиллагаагүй болох.
- ✓ Алслагдсан орон нутгийн харилцаа холбооны тоног төхөөрөмжийг яаралтай засварлах, сэргээн босгох ажиллагааг явуулах хүч хэрэгсэл дутагдаж саатах.

Дээрх цагийн байдалд үндэслэн гамшгийн үед авах арга хэмжээг сайжруулахад чиглэсэн 10 жилийн зорилтыг дэвшүүлж, тус зорилтод хүрэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлж, зохистой арга хэмжээг төлөвлөн, тухайн арга хэмжээг эрэмбэлэх, шаардагдах төсөв хөрөнгийн талаар тооцоо судалгаа хийж төлөвлөгөөг боловсруулав.

3. Үндсэн чиглэл

Энэ хэсэгт газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөхөд баримтлах үндсэн чиглэлийг гаргав.

3.1 Үндсэн чиглэл

- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах зохистой арга хэмжээг төлөвлөх
- Тухайн бүс нутагт үүсч болзошгүй газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодит арга хэмжээг хэрэгжүүлэх
- Хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хянах
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ PDCA (төлөвлө, гүйцэтгэ, шалга, хэрэгжүүл) дээр үндэслэн хэрэгжилтийг удирдан хянаж, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийн тулд төлөвлөгөөг тухай бүрт шинэчлэх боломжтой байх.

3.2 Салбар тус бүрийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний чиглэл

(1) Барилга байгууламж, дэд бүтэц, ИШС-ний газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

- Олон нийтийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг үнэлэх болон хангах ажлыг эрчимжүүлэх.
- Зам, гүүрийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг үнэлэх болон хангах ажлыг тогтмол үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.
- Цэвэр, бохир усны хоолойн насжилтын судалгааг хийж, газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээнд үндэслэн хүчитгэх, шинэчлэх ажлын эрчимжүүлэх.
- Цахилгаан үйлдвэрлэх байгууламж болон цахилгаан дамжуулах шугам сүлжээний засвар үйлчилгээг эрчимжүүлж, шаардлагатай бол шинэчлэн сайжруулах.

(2) Хүч хэрэгсэл, боловсрол, сургалт

- Гамшгаас хамгаалан иж бүрэн сургууль, нүүлгэн шилжүүлэх сургууль зэргийг зохион байгуулах.
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн гамшгаас хамгаалах боловсролыг боловсронгуй болгох.

(3) Мэдээлэл, харилцаа холбоо

- Гамшгаас хамгаалах байгууллага хоорондын мэдээллийн сүлжээг гамшгийн үед ашиглах бэлэн байдлыг хангах.

- Гамшгаас хамгаалах байгууллагаас иргэдэд мэдээлэл түгээх үйл ажиллагааг эрчимжүүлэх.

(4) Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж

- Мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэх, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлж боловсронгуй болгох.
- Эрүүл мэнд, эмнэлгийн байгууллагын мэдээлэл дамжуулах чадавхийг бэхжүүлж, тогтолцоог бүрдүүлэн боловсронгуй болгох.

(5) Гамшгаас хамгаалах арга хэмжээ

- Эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаар иргэдэд мэдлэг олгож, таниулан сурталчлах.
- Онцгой комиссын үйл ажиллагааг боловсронгуй болгох.
- Гамшгаас хамгаалах байгууллага хоорондын уялдаа холбоог бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх.

4. Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ

Газар хөдлөлтийн гамшгийн улмаас үүсч болзошгүй хохирлын төсөөлөл дээр үндэслэн гаргасан гамшгийн цагийн байдлын дагуу авах шаардлагатай арга хэмжээг харгалзан, цаашид хэрэгжүүлэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ төлөвлөж доор үзүүлэв.

I. Барилга байгууламж, хот байгуулалт, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ

I.1 Гамшгаас хамгаалах хот төлөвлөлт

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">8 баллын газар хөдлөлтийн үед нурах аюултай барилгуудыг дахин төлөвлөлтөд хамруулах, хүчитгэх, нурааж шинээр барих зэрэг эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсны үр дүнд нурах аюултай барилгуудын эрсдэлийг 30 хувиар бууруулах.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2019 онд багтаан дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах;Ялангуяа түр хоргодох байр болгож ашиглах төлөвлөгөөтэй барилгыг нэн тэргүүнд тэсвэржилтийн үнэлгээ хийх, тэсвэржилтийг хангах.Баригдсан барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварыг үнэлж паспортжуулах ажлыг дуусгаж газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн шаардлага хангаагүй орон сууц болон бусад барилгын талаар авах арга хэмжээний тухай санал боловсруулах,Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг үнэлэх, бууруулах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвт тусгуулах,Боловсон хүчнийг чадавхижуулах сургалтын шат дараатай явуулахГамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгож, аймаг, сумын хөгжлийн бодлогод гамшгийн эрсдэлийг тооцож, уялдуулах,Иргэд, олон нийтэд уг төлөвлөгөөг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах.
< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2029
< Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, СЗДТГ, МХГ, ГХБХБГ, ОБГ, БОАХГ
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 3~4.2 тэрбум төгрөг

I.2 Засаг захиргааны байгууллагын барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">Төрийн байгууллагын барилгын 100%-ийг газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ болон паспортжуулалтын ажилд хамруулан хэрэгжүүлэх.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">Хүчитгэх шаардлагатай барилга байгууламжуудын жагсаалт гаргаж ирэх оны төсөвт

<p>боломжит хэмжээгээр суулгаж өгөх</p> <ul style="list-style-type: none"> • Барилга хувийн хэрэгтэй болгох • Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийж дуусгах • Шаардлага хангахгүй барилга байгууламжуудыг буулгаж, дахин төлөвлөх
<p><Хэрэгжүүлэх хугацаа ></p> <p>2019~2029</p>
<p><Хэрэгжүүлэх байгууллага ></p> <p>АЗДТГ, СЗДТГ, ГХБХБГ, МХГ, ОБГ</p>
<p><Шаардлагатай төсөв хөрөнгө ></p> <p>250~350 сая төгрөг</p>

I.3 Олон нийтийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

<p>< 10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> • Олон нийтийн барилгын тухайлбал, эмнэлэг, суургууль, цэцэрлэгийн барилгуудыг 100 % хүчитгэж дууссан байх
<p>< Арга хэмжээ ></p> <ul style="list-style-type: none"> • Олон нийтийн болон орон сууцны барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэртэй байдлыг шалгах, үнэлэлт өгөх ажлыг шуурхай зохион байгуулах • Төлөвлөгөө боловсрогдож эцэслэсэн тохиолдолд олон нийтийн барилга, байгууламжийг хүчитгэхэд шаардагдах зардлын тооцоог гаргаж байгууллагын ирэх оны төсөвт тусгуулсан байх
<p><Хэрэгжүүлэх хугацаа ></p> <p>2019~2029</p>
<p><Хэрэгжүүлэх байгууллага ></p> <p>АЗДТГ, СЗДТГ, МХГ, ГХБХБГ, ОБГ, БСГ, НБХэлтэс, Эрүүл мэндийн газар</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө ></p> <p>26 ш цэцэрлэг (төрийн)156,0-208,0 сая/төг 16 ш цэцэрлэг (төрийн) 96,0-128,0 сая/төг 18 ш эмнэлэг (төрийн)78,0-104,0 сая/төг 20 ш цэцэрлэг (хувийн) 120,0-160,0 сая/төг 9 ш цэцэрлэг (хувийн) 54,0-72,0 сая/төг 53 ш эмнэлэг (хувийн) 318,0-424,0 сая/төг Нийт 1,096.0 сая/төг</p>

I.4 Орон сууцны барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

<p>< 10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> • Орон сууцны барилгад газар хөдлөлтийн улмаас учирч болзошгүй хохирлын эрсдэлийг 50 %-иар бууруулах
<p>< Арга хэмжээ ></p> <ul style="list-style-type: none"> • Улсын болон орон нутгийн төсөвт эрсдэлийн үнэлгээ хийх болон паспортжуулалтын зардлуудыг тусгуулах • Нийт орон сууцыг эрсдэлийн үнэлгээнд хамруулж дуусгах • Эрсдэлийн үнэлгээгээр барилгажсан хэсгийн 1816 барилга нурсан, эсвэл ихээр сүйдсэн үр дүн гарсан байгаа 1957 оноос хойш 1990 оны хооронд баригдсан барилга байгууламжуудад газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх • Хуучин баригдсан нийтийн орон сууцны ашиглалтын байдлыг сайжруулж, хяналтыг түлхүү тавих

<ul style="list-style-type: none"> Дахин төлөвлөлтөд Эхний ээлжинд 6-р багийн 1 ширхэг барак байрыг буулгаж 60 айлын 5 давхар орон сууц барьж 3 байрны 24 иргэнийг хамруулахаар төлөвлөж ажиллаж байна.
<Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2029
<Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, СЗДТГ, МХГ, ГХБХБГ, ОБГ
<Шаардлагатай төсөв хөрөнгө > <ul style="list-style-type: none"> Орон сууцын 389 барилгын паспортжуулалт: 1,945 сая төгрөг; Дахин төлөвлөлтөөр барих 9 барилга: 3,150 сая төгрөг.

1.5 Зам байгуулалт, замын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none"> Зам засвар, үйлчилгээний ангийн хүн хүч, техникийн хангалтын 50% нэмэгдүүлэх замаар гамшгийн үеийн эвдэрсэн замын сэргээн засварлах бэлэн байдлыг 30% дээшлүүлэх.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none"> Дархан уул-аймгийн орон нутгийн зам, засвар ашиглалтын газрын газар хөдлөлтийн гамшгийн үед замын эвдрэл гэмтлийг сэргээн засварлах шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, шаардагдах тооцоо судалгааг хийх. Газар хөдлөлтийн гамшгийн үед эвдэрсэн замыг сэргээн засварлах Дархан-уул аймгийн зам, засварын газрын бэлтгэл бэлэн байдлыг хангах төлөвлөгөө боловсруулах, шаардлагатай хүн техник, материалын нөөц бүрдүүлэх; Газар хөдлөлтийн үед замын эвдрэл, нурангийг зайлуулж тээврийн хэрэгсэл нэвтрэх нөөц тойруу зам гаргах чиглэлийг тээврийн цагдаагийн албатай хамтран тодорхойлох Байгаль цаг уур, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах Гадаадын орнуудын орчин үеийн ажлын бүтээмж өндөр тоног төхөөрөмжийг ашигладаг болох Мэргэжлийн ажилчдын газар хөдлөлтийн гамшгийн үед үүрэг гүйцэтгэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх Замын чанар байдал, газар хөдлөлтийн тэсвэрлэх чадвар, хохирлын үнэлгээ хийх мэргэжлийн байгууллагыг өргөжүүлж, хөгжүүлэх
<Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2029
<Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, СЗДТГ, МХГ, ГХБХБГ, ОБГ, Дархан-уул аймгийн зам, засварын газар
< Шаардлагатай төсөв хөрөнгө >

1.6 Гүүрийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none"> Гүүр барилга угсралт засварын ангийн хүн хүч, техникийн хангалтын 50% нэмэгдүүлэх замаар гамшгийн үеийн эвдэрсэн гүүрийн сэргээн засварлах бэлэн байдлыг 30% дээшлүүлэх.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none"> Орчин үеийн тоног төхөөрөмжөөр төмөр бетон гүүрийг нэмж барих Засвар арчлалтын хөрөнгө мөнгийг хангалттай шийдвэрлэж өгөх Мэргэжлийн боловсон хүчнийг өндөр түвшинд чадавхижуулах

<ul style="list-style-type: none"> • Гүүрийн газар хөдлөлтийн эрсдэлийн болон хохирлын үнэлгээний хийх мэргэжлийн байгууллагуудыг сургаж бэлтгэх, зөвшөөрөл, лиценз олгох тогтолцоог бүрдүүлэх • Гүүр, гүүрийн байгууламжид газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсэн үнэлгээг хийхэд шаардлагатай газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийх стандарт, норм дүрмийн талаар мэргэжилтнүүдэд сургалт явуулж үнэлгээчдийг бэлтгэх • Гүүрийн барилга байгууламжийн лабораторийн хэрэгцээг бүрэн хангах арга хэмжээг судалж шийдвэрлэх • Дархан –Уул аймгийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлд зам,гүүрийн барилга угсралт, засвар арчлалтын ажлын зардал, техник технологийг сайжруулахад шаардагдах хөрөнгийг танилцуулж шийдвэрлүүлэх
<p>< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2029</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, СЗДТГ, МХГ, ГХБХБГ, ОБГ, Зам гүүрийн мэргэжлийн ангиуд</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө ></p>

1.7 ИШС-ий газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

<p>< 10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> • “ДДС” ТӨХК, “ДУС” ХК-ын газар хөдлөлтийн гамшгийн үеийн цахилгаан дулааны шугам сүлжээ, цэвэр бохир усны шугам сүлжээнд гарах хохирлын эрсдэлийг 50% бууруулах
<p>< Арга хэмжээ ></p> <p>“ДСЦТС” ХК, “ДДС” ТӨХК</p> <ul style="list-style-type: none"> • Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг ЦДАШ, НШ-д 100% гүйцэтгэх • Насжилт нь дууссан ЦДАШ, НШ-ийг 80 хүртэлх хувийг шинэчилж газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах. • 6/0,4 кв дэд станцуудад барилгын засварын ажил хийх. • “ДДС” ТӨХК “ДУС” ХК –ын машин механизм, техник хэрэгслийн 60 хүртлэх хувийг шинэчилж техникийн бэлэн байдлыг хангах. • “ДДС” ТӨХК, “ДУС” ХК-ын инженер, техникийн ажилтнуудыг 100 хувь газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, бэлтгэл бэлэн байдлыг хангах сургалтад хамруулах <p>“ДУС” ХК</p> <ul style="list-style-type: none"> • ЦДАШ, НШ-ийг 80 хүртэлх хувийг шинэчилж газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах. • Гангийн найрлаганд газар хөдлөлтөнд тэсвэртэй бодис орсон ганг захиалж хийлгэх туршиж үзэх. • Цэвэр усны эх үүсвэрийн цахилгаан хангамж хамгийн түрүүнд шийдэх. ДЦТС ХК-тай хамтрах. • Дэд Бүтэц хариуцсан байгууллагууд хоорондын уялдаа, хамтын ажиллагааг хангахад чиглэсэн санамж бичиг байгуулах. • Инженер, техникийн ажилтнуудыг 100 хувь газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, бэлтгэл бэлэн байдлыг хангах сургалтад хамруулах
<p>< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2024</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, “Дархан-Ус суваг “ХХК, “ДДС” ТӨХК, “ДСЦТС” ХК</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө > 20 тэрбум төгрөг</p>

I.8 Хорт химийн бодис гэх мэтийг хадгалдаг аюул бүхий барилга байгууламжийн тэсвэржилтийг хангах

<p>< 10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> Химийн хортой болон аюултай материалын стандартыг хангах замаар химийн хортой бодисын хадгалах, ашиглах, харьцах ажиллагааны үед гарах эрсдэлийг 100% бууруулах
<p>< Арга хэмжээ ></p> <p><u>Дархан-Ус Суваг ХК</u></p> <ul style="list-style-type: none"> Химийн хорт бодисыг газар хөдлөлтөнд тэсвэртэй бат бөх саванд хадгалах арга хэмжээ авах Нөлөөлөлд өртөх магадлалтай хүн амыг мэдээллээр хангах, сургалтад хамруулах Дэд Бүтэц хариуцсан байгууллагууд хоорондоо санамж бичиг байгуулах <p><u>“ДДС “ТӨХК</u></p> <ul style="list-style-type: none"> Хортой аюултай химийн бодисуудыг (H₂SO₄, NH₃, C₂H₅) зэргийг хадгалдаг химийн агуулахыг конторын 1 давхарт шилжүүлэн хүчитгэсэн агуулахад хадгалах Агуулахын хаалгыг газар хөдлөлтөнд тэсвэртэй төмрөөр хийх Даацын төмөр шүүгээнд тус бүрээр нь хоорондоо урвалд орж шатаж, дэлбэрэлтээс сэргийлсэн цоожтой шүүгээнд хийж хадгалах
<p>< Хэрэгжүүлэх хугацаа ></p> <p>2019~2024</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага ></p> <p>Дархан-Ус Суваг ХК, “ДДС “ТӨХК, ДС ЦТС ХК</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө ></p>

II. Гамшгаас хамгаалах хүн хүч, техник хэрэгсэл

II.1 Гамшгаас хамгаалах техник хэрэгсэл

<p>< 10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> Гал унтраах үндсэн болон туслах албаны автомашины нөхөн хангалтыг нийслэлийн жишиг япон улсын автомашинуудаас нийлүүлж 5 жилийн хугацаанд 50% парк шинэчлэлт хийх Холбоо зарлан мэдээллийн багаж хэрэгслийг хүчин чадлыг нэмэгдүүлэх ойрын 5-10 жилийн дотор 80-100%-иар шинэчлэн хангах
<p>< Арга хэмжээ ></p> <ul style="list-style-type: none"> Дараахь машин, тоног төхөөрөмжийг шинэчлэх: Гэрэл холбооны автомашин-1 Аврах ажиллагааны автомашин-1 Гал унтраах үндсэн албаны автомашин-1 Эрт зарлан мэдээллийн систем Богино долгионы радио станцын чанар сайжруулах Тоон радио холбооны систем Радио холбооны хөдөлгөөнт автомашин
<p>< Хэрэгжүүлэх хугацаа ></p> <p>Холбоо зарлан мэдээллийн багаж хэрэгсэл: 2019~2029</p> <p>Парк шинэчлэлт: 2019~2024</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага ></p> <p>ОБГ-ын Холбоо зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, Мэдээлэл харилцаа холбооны алба, Аймгийн ЗДТГ газар хөдлөлт байнгын ажиллагаатай зөвлөл</p>

< Шаардлагатай төсөв хөрөнгө >

- Холбоо зарлан мэдээлийн техник хэрэгсэл: 3 тэрбум төгрөг
- Аврах ажиллагааны автомашин зэрэг парк шинэчлэл: 3 тэрбум төгрөг

II.2 Гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүн

< 10 жилийн зорилт >

- 5 жилийн хугацаанд мэргэшсэн аврагч, гал сөнөөгч, удирдагч 80%-д хүргэнэ.
- Мэргэжлийн анги албадын ажиллах хүн хүч, боловсон хүчин мэргэшсэн албан хаагч 90%- д хүргэнэ.

< Арга хэмжээ >

Хүн хүч хэрэгслийн мэрэгшүүлэх, боловсон хүчнээр хангах, ажил олгох талаар эрчимжүүлэх

< Хэрэгжүүлэх хугацаа >

- Мэргэшсэн аврагч, гал сөнөөгч: 2019~2024
- Мэргэжлийн алба, ангийн мэргэшсэн болоход: 2019~2025

< Хэрэгжүүлэх байгууллага >

ОБЕГ газар, ОБГ, Аймгийн газар хөдлөлт байнгын ажиллагааны зөвлөл

< Шаардлагатай төсөв хөрөнгө >

Тухайн жилийн төсвөөр

II.3 Гамшгийн нөөц

< 10 жилийн зорилт >

- Газар хөдлөлтийн үеийн гамшгийн нөөц, материал хэрэгслийн нөөцийг 50 хувиар нэмэгдүүлэх

< Арга хэмжээ >

- Гамшгийн эрсдэлийн санг байгуулах замаар гамшгийн нөөц бүрдүүлэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх

< Хэрэгжүүлэх хугацаа >

2019~2029

< Хэрэгжүүлэх байгууллага >

Аймгийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл

< Шаардлагатай төсөв хөрөнгө >

ГХ тухай хуулийн 51-р зүйлийн 51.2 заалтыг хэрэгжүүлэх

II.4 Шуурхай тээврийн хүч хэрэгсэл, сүлжээ

< 10 жилийн зорилт >

- Шуурхай тээвэрлэлтийн зохион байгуулалт, тогтолцоог бүрдүүлэх

< Арга хэмжээ >

- Шинэ ангийн байранд шуурхай удирдлагын төвийг байрлуулах
- Шуурхай тээвэрлэлт хийх үед дайчлах автомашиныг нэмэгдүүлэх ("5.9 Нүүлгэн шилжүүлэх зам"-ыг үзэх)

< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2020
< Хэрэгжүүлэх байгууллага > ОБГ, Зам тээврийн алба, Аймгийн ЗД (гэрээ байгуулах), Нөөц хангалтын бүлэг
< Шаардлагатай төсөв хөрөнгө >

III. Мэдээлэл, харилцаа холбоо

III.1 Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none"> Гамшгийн үед Дархан-Уул аймгийн ОБГ болон гамшгаас хамгаалах байгууллагуудын мэдээлэл холбооны хэрэгслийн бэлэн байдлыг 80 дээш хувьд хүргэх
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none"> Дархан бүсэд байгаа тодорхой зай талбайд газар хөдлөлтөд тэсвэртэй богино зарлах хоолой, дуут дохио гэх зэргийг байрлуулах. АТС-н 100 хүний багтаамжтай зөөврийн хаана ч байршуулах давуу талтай станц зөөврийн бага оврын тэжээлийн үүсгүүртэй болох Хохирлын төсөөлөл, болзошгүй цагийн байдалд үндэслэн найдвартай холбоо харилцаа, зарлан мэдээллийн тоног төхөөрөмж суурилуулах. Инженер техникийн ажилчдыг гамшгийн үеийн арга хэмжээг хэрэгжүүлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангахад тогтмол сургаж бэлтгэх Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх, сэрэмжлүүлэх тогтолцоог сайжруулахын тулд сансарын болон радио станцтай болох, агаарын линк буудах. Аймаг сумууд хоорондоо мэдээлэл солилцох зорилгоор богино холбоотой болох 8 балл хөдөлж холбооны байр, кабель шугам, цамхаг, тоног төхөөрөмж гэмтсэн үед хохирлоо тодорхойлох инженер техникийн ажилчдыг томилон агаарын линк, радио станц, кабель шугам засварлах бэлтгэл бэлэн байдлыг хангах арга хэмжээ авах. Харилцаа холбоо тасарсан тохиолдолд нэн түрүүнд сансарын болон радио станцын тусламжтайгаар ажиллагаанд оруулах арга хэмжээ авах Уулан дээр байрлах цамхаг, байнгын антеннын бэхэлгээг сайжруулж нөөц тэжээлийн үүсгүүртэй болгоно. Дархан –Уул аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулахад ашиглах орон зайн болон статистик мэдээллийн санг бий болгох зорилт дэвшүүлж хэрэгжүүлэх
< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2029
< Хэрэгжүүлэх байгууллага > ОБГ, Монголын цахилгаан холбоо ХК
< Шаардлагатай төсөв хөрөнгө > <ol style="list-style-type: none"> Богино долгионы радио станц (гар) 120ш, 600,000 төгрөг Суурин богино долгионы радио станц, 12ш, 1,800,000 төгрөг Дахин дамжуулах антенн 2 сая төгрөг

III.2 Холбоо, мэдээлэл цуглуулах удирдлага зохион байгуулалт

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none"> Монголын цахилгаан холбооны ХК –ын Дархан –Уул аймгийн Холбооны газрын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх
--

<p>< Арга хэмжээ ></p> <ul style="list-style-type: none"> • Радио холбооны сүлжээг өргөтгөх, аймаг, сумын онцгой комисс, Онцгой байдлын газар, хэлтэс, Гамшгаас хамгаалах албад, Мэргэжлийн анги хооронд найдвартай холбоогоор хангах арга хэмжээг судалж, дүн шинжилгээ хийх. • Гамшгийн үед цахилгаан үүсгэх тоног төхөөрөмж, богино холбоог нэн түрүүнд ажиллагаанд оруулах ажлыг судлах • Гамшгийн үед үүрэн телефон, цахилгаан холбоог сэргээн босгох, засварлах арга хэмжээг төлөвлөх. • Монголын цахилгаан холбооны ХК –ын Дархан –Уул аймгийн Холбооны газрын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд доорх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Худаг сувагчлалыг нөөц кабель болгох (Нөөцөнд тодорхой эрсдэлийн хэмжээнд : метр) 2. Агаарын wifi цацах, агаарын link буудах <ul style="list-style-type: none"> • Газар хөдлөлтийн гамшгийн зарлан мэдээллийн системийг бэхжүүлэхийн тулд доорхи арга хэмжээг хэрэгжүүлнэ. 1. Богино долгионы радио холбооны сүлжээг байгуулах 2. Хөдөлгөөнт радио холбооны тоог нэмэгдүүлэх <ul style="list-style-type: none"> • Бүх байгууллагын датабаазтай болох (статистик) Ажилтнуудын гаргасан мэдээллийг нэгтгэх. • Нэгдсэн 1 баазтай болгох. • Мөн тухайн салбарын гаргах үзүүлэлтийг тодорхойлох. • Гаргасан мэдээллээ хугацааны давтамжийн дагуу тодорхойлох тогтмол шинэчлэх.
<p>< Хэрэгжүүлэх хугацаа ></p> <p>2019~2029</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага ></p> <p>ОБГ, Монголын цахилгаан холбоо ХК, үүрэн телефоны оператор компани</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө ></p>

III.3 Иргэдэд зарлан мэдээлэх, сэрэмжлүүлэх мэдээ хүргэх

<p>< 10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> • Газар хөдлөлтийн гамшгийн үеийн иргэдэд амжиж анхааруулах системийг сайжруулах
<p>< Арга хэмжээ ></p> <ul style="list-style-type: none"> • Дархан хотын барилгажсан хороололд газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг хангасан сирен болон зарлан мэдээллийн тоног төхөөрөмжийг суурилуулах
<p>< Хэрэгжүүлэх хугацаа ></p> <p>2019~2029</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага ></p> <p>ОБГ, Монголын цахилгаан холбоо ХК</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө ></p>

IV. Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж

IV.1 Эмнэлэг, орны тоо

<p>< 10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн ор, эм эмийн хэрэгслийн хэрэгцээт нөөцийг 80 доошгүй хувиар бүрдүүлэх.
--

<ul style="list-style-type: none"> Нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, эрүүл мэндийн төвийн барилгуудад газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээг 100 % хийх.
<p>< Арга хэмжээ ></p> <ul style="list-style-type: none"> Нөөц ор (эвхдэг ор г.м.)-ны нөөцийг бүрдүүлэх Сургалтыг тогтмолжуулах, хамрах хүрээг өргөжүүлэх
<p>< Хэрэгжүүлэх хугацаа ></p> <p>1-р үе: 2019~2024</p> <p>2-р үе: 2025~2030</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага ></p> <p>ЭМГ, НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, СУМ, ӨРХ, ХУВИЙН ХЭВШИЛ</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө ></p> <p>100 сая төгрөг</p>

IV.2 Эмч, сувилагч

<p>< 10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> 100,000 хүн амд 366 эмч, 183 эмнэлгийн ажилчин бэлдэх Эмнэлгийн эмч, сувилагч эмнэлгийн ажилтнуудыг газар хөдлөлтийн гамшгийн цагийн байдлын үед ажиллах сургууль дадлагад 100 хувь хамруулах.
<p>< Арга хэмжээ ></p> <ul style="list-style-type: none"> Хөрөнгө санхүүжилт төсөвт тусгаж өгч батлуулах Тэтгэвэрт гарсан мэргэжлийн хүмүүсээс хүний нөөцөө бүрдүүлэх
<p>< Хэрэгжүүлэх хугацаа ></p> <p>2019~2020</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага ></p> <p>ЭМГ, НЭГДСЭН ЭМНЭЛЭГ</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө ></p> <p>100 сая төгрөг</p>

IV.3 Хээрийн эмнэлэг

<p>< 10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> Газар хөдлөлтийн үед нэрвэгдэгсдэд эмнэлгийн тусламж үзүүлэх бэлтгэл бэлэн байдлыг 80 доошгүй хувиар дээшлүүлэх.
<p>< Арга хэмжээ ></p> <ul style="list-style-type: none"> Сайн дурын бүлгэм, оюутны бүлгэм, цэрэг цагдаагийн ажилтнуудыг хээрийн эмнэлэгт дайчлан ажиллуулах Хээрийн эмнэлгийг өргөтгөн зохион байгуулах. Хээрийн эмнэлэгт Майхан-40, эмч 40, Ажилчид 100 ажиллуулахаар бэлтгэх
<p>< Хэрэгжүүлэх хугацаа ></p> <p>2019~2020</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага ></p> <p>ЭМГ, НЭГДСЭН ЭМНЭЛЭГ</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө ></p> <p>100 сая төгрөг</p>

IV.4 Эмийн нөөц

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">• Эм эмийн хэрэгслийн хэрэгцээт нөөцийг 80 доошгүй хувиар бүрдүүлэх.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">• Улсын төсөвт жил бүр тодорхой нэмэгдсэн өртгөөр суулгаж өгвөл шийгдэгдэх болоцоотой.• 5 сарын эмийн нөөцийг бүрдүүлэх• Санамж бичиг байгуулах
< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2020
< Хэрэгжүүлэх байгууллага > ЭМГ, НЭГДСЭН ЭМНЭЛЭГ
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 10 сая төгрөг

IV.5 Мэдээлэл дамжуулах

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">• Радио холбооны хангалтыг 80-аас доошгүй хувиар бүрдүүлэх.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">• Богино догионын радио холбооны сүлжээг бий болгох• Байгууллага иргэдийг гамшгийн удирдлагын сургалтанд хамруулах
< Хэрэгжүүлэх хугацаа > 1-р үе: 2019~2020
< Хэрэгжүүлэх байгууллага > ЭМГ, НЭГДСЭН ЭМНЭЛЭГ
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 10 сая төгрөг

IV.6 Тээврийн зохион байгуулалт

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">• Эмнэлгийн түргэн тусламжийн машин, тусгай тоног төхөөрөмжийн хангалтыг 80 -аас доошгүй хувиар бүрдүүлэх.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">• Зөвхөн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах зориулсан сан байгуулж зарцуулах• Нийт хүн ам 200,000 хүрэх төлөвтэй тул,50 ш түргэний машинтай болох
< Хэрэгжүүлэх хугацаа > 1-р үе: 2019~2020
< Хэрэгжүүлэх байгууллага > ЭМГ, НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, Түргэн тусламжийн тасаг
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 500 сая төгрөг

IV.7 Халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">• Халдвар хамгаалалтын баг 4, эмнэлгийн ажилтан 20 ажиллуулах• ЭМГ болон эмнэлгийн ажилтнуудыг гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургуульд 100% оролцуулах
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">• Хувцас, хэрэгсэл, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэглэлийг нөөцийг хангалттай бүрдүүлэх
< Хэрэгжүүлэх хугацаа > 2021~2024
< Хэрэгжүүлэх байгууллага > ЭМГ, НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, Түргэн тусламжийн тасаг
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 10 сая төгрөг

IV.8 Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">• Гамшгийн үед ажиллах сэтгэл зүйч эмч нарыг тусгайлан бэлдсэн байх.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">• Гамшгийн үед ажиллах сэтгэл зүйч эмч нарыг тусгайлан бэлдсэн байх.• Сэтгэл зүйн тусламж үзүүлэх талаарх сургалт зохион байгуулах
< Хэрэгжүүлэх хугацаа > 2021~2024
< Хэрэгжүүлэх байгууллага > Сэтгэцийн эрүүл мэндийн тасаг, МУЗН
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 1 сая төгрөг

V. Гамшгаас хамгаалах арга хэмжээ, хүч хэрэгсэл

V.1 Сураггүй болсон иргэдийг эрэн хайх

< 10 жилийн зорилт > Эрэн хайх аврах ангийн тоног төхөөрөмжийн хангалтыг 50%-д хүргэх.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">• Эрэн хайх аврах ангийн орон тоог батлуулах талаар ОБЕГ-ын даргаар хэлэлцүүлэх• Эрэн хайх аврах ангийн орон тоо батлагдаж удирдлагаар бүрэн хангагдахад 85%-д хүрэх• Шуурхай удирдлагын төв байгуулагдаж удирдлагаар хангах хэмжээнд хүрнэ.
< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2020
< Хэрэгжүүлэх байгууллага > ОБЕГ, ОБГ, Нутгийн захиргааны байгууллага, Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төв
< Шаардлагатай төсөв хөрөнгө > <ul style="list-style-type: none">• Тухайн төсөвөөр санхүүжилнэ• ЗМШУТөв: 57 сая

V.2 Шарил таниулах, оршуулах

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">Шарил таниулах, оршуулах ажлын тогтолцоо, зохион байгуулалтыг бий болгох
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">Шарил таниулах барилга байгууламжийг байгуулах, шарил хадгалах хөргөгчийн хүчин чадлыг нэмэгдүүлэхГамшиг ослын үед шарил таниулах мэргэжилтэнгийн албаны зүгээс мэргэжүүлэх томилгот үүрэг бүхий алба хаагч байх
< Хэрэгжүүлэх хугацаа > 1 жилд 2 хөргөгч авах, 10 жилд 20 хөргөгч авах
< Хэрэгжүүлэх байгууллага > ЭМ-ийн нэгдсэн эмнэлэг, ОБГ, Буян компани
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 1 хөргөгч 10 сая, 20 хөргөгч 200 сая

V.3 Түр хоргодох байр

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">Газар хөдлөлтийн гамшгийн үед гэр оронгүй болох хүмүүсийг түр хоргодох болон түр орон сууцаар 100 хувь хангах
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">Түр хоргодох байрны хүчин чадал болон тоог нэмэгдүүлэх талаар Аймгийн ИТХ-д танилцуулах.Дархан-Уул аймгийн ойрын 5-10 жилийн аймгийн төлөвлөгөнд тусгаж төсөвт оруулж түр хоргодох байрны нөхөн хангалтыг хэрэгжүүлж, газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангахТүр хоргодох байр болгож ашиглах боломжтой барилга байгууламжийг 1 жилд 2-оос доошгүй бариулах.Түр хоргодох байр болгож ашиглах сургууль, цэцэрлэг их дээд сургуулийн эрсдлийн үнэлгээ хийж паспортжуулах
< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2029
< Хэрэгжүүлэх байгууллага > БСУГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
< Шаардлагатай төсөв хөрөнгө > Нийт 117 барилга байгууллага байгууламж паспортжуулахад 585 сая төгрөг

V.4 Түр хоргодох байран дахь нөөц

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">Түр хоргодох байрын материал, тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэх
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">Аймгийн Засаг Даргатай зөвшилцөж түр хоргодох байрны нөөцийг бүрдүүлэх ЗД-н нөөц сангаас.Нөөц бүрдүүлэх санг нэмэгдүүлэх байгууллагын нөөцөөр гаргаж буй тоог аймгийн хэмжээнд төлөвлөгөөнд оруулах.

< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2029
< Хэрэгжүүлэх байгууллага > Аймгийн ГХ-ийн барилгын зөвлөл ЗДТГ, багийн засаг дарга нар
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 1 хүн хоногт: 5800 төг. 6210 хүн 14 хоногт: 504.2 сая төгрөг

V.5 Нүүлгэн шилжүүлэх байршил

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none"> Нүүлгэн шилжүүлэх байршилд нүүлгэн шилжүүлэх ажлын зохион байгуулалт, тогтолцоог бүрдүүлэх
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none"> Аймгийн Онцгой Комиссын дарга шийдвэрээр зохицуулах Шороон замыг сайжруулснаар нүүлгэн шилжүүлэх байршилд хүрэхэд хүндрэлгүй болгох.
< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2029
< Хэрэгжүүлэх байгууллага > Аймгийн ЗД, Зам тээврийн алба
< Шаардлагатай төсөв хөрөнгө > Улсын төсөвөөс

V.6 Нүүлгэн шилжүүлэх зам

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none"> Нүүлгэн шилжүүлэх ажлын зохион байгуулалт, тогтолцоог бүрдүүлэх
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none"> Нүүлгэн шилжүүлэлтийн үеийн зам тээвэр хүрэлцэн очих хугацааг хэмнэх зорилгоор авто замыг 5-10 жил дотор багтаан хучилттай болгох. Төсөв бүрдүүлэх. Албад мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангуулж хамтран ажиллах гэрээ байгуулах Автобус 40хүн/1800 хүн Микроавтобус 37/444 хүн Суудлын машин 123/492 хүн Хүн 2,736 6,210 хүнийг 3 удаа зөөвөрлөх
< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2020
< Хэрэгжүүлэх байгууллага > ОБГ, Зам тээврийн алба, Аймгийн ЗД (гэрээ байгуулах), Нөөц хангалтын бүлэг
< Шаардлагатай төсөв хөрөнгө >

V.7 Замын хөдөлгөөний зохицуулалт

< 10 жилийн зорилт >
<ul style="list-style-type: none"> Гамшгийн үеийн замын хөдөлгөөний зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх
< Арга хэмжээ >
<ul style="list-style-type: none"> Аймгийн дотор болон гадна замыг эвдрэл гэмтэл гарсан үед зорчиж болох өөр зам шинээр бий болгох.
< Хэрэгжүүлэх хугацаа >
2019~2020
< Хэрэгжүүлэх байгууллага >
ОБГ, Зам тээврийн алба, Аймгийн ЗД (гэрээ байгуулах), Нөөц хангалтын бүлэг
< Шаардлагатай төсөв хөрөнгө >

V.8 Ундны цэвэр ус, хүнс, ахуйн анхдагч хэрэглээний зүйлс

< 10 жилийн зорилт >
<ul style="list-style-type: none"> Гамшгийн нөөц бүрдүүлэх
< Арга хэмжээ >
<ul style="list-style-type: none"> Аймгийн Даргын Нөөц сангаас санхүүжүүлнэ. Ундны цэвэр усны нөхөн хангалт, хадгалалтыг сайжруулах, хүн бүрт бүрт хангагдах зориулалттай блгох 85 %хүртэл. Гамшиг болсон тохиолдолд иргэдэд хоол хүнсний нөөц хангалт 14-25 хоногийн холлох нөхөн хангалтыг бий болгох
< Хэрэгжүүлэх хугацаа >
2019~2029
< Хэрэгжүүлэх байгууллага >
Улаан загалмайн хороо, сайн дурын гишүүд, Аймаг сум багийн ЗД нар, Санхүү нөөц хангалтын алба
< Шаардлагатай төсөв хөрөнгө >
10,000 хүнд тооцоолоход 1 сар 1,7 тэрбум төгрөг 25 хоног 6,210 хүнд 908 сая төгрөг

V.9 Хог хаягдлын арга хэмжээ

< 10 жилийн зорилт >
<ul style="list-style-type: none"> Хог хаягдлын менежментийн тогтолцоог бэхжүүлэх
< Арга хэмжээ >
<ul style="list-style-type: none"> Хөрөнгө мөнгө шийдвэрлэх Хогийг төрөлжүүлэх Хог дахин боловсруулах үйлдвэр барих
< Хэрэгжүүлэх хугацаа >
2019~2024
< Хэрэгжүүлэх байгууллага >
НААҮГазар
< Шаардлагатай төсөв хөрөнгө >

Хог дахин боловсруулах үйлдвэр барихад 5-10 тэрбум төгрөг

V.10 Бие засах газраар хангах, бохир зайлуулах арга хэмжээ

< 10 жилийн зорилт >
<ul style="list-style-type: none">“ДУС” ХК –ын газар хөдлөлтийн гамшгийн үеийн бохир усны шугам сүлжээнд гарах хохирлын эрсдэлийг 50 % бууруулах
< Арга хэмжээ >
<ul style="list-style-type: none">Орчин үеийн хөрсний тодорхойлох багаж авах.Зөөврийн био ариун цэврийн байгууламжтай болох.Парк шинэчлэл хийж багтаамж ихтэй автомашин авах.Зориулалтын агуулахтай болж халдваргүйжүүлэх бодисын нөөцтэй байх
< Хэрэгжүүлэх хугацаа >
2019~2024
< Хэрэгжүүлэх байгууллага >
Дархан Ус суваг ХК, ДШС, СЗДТГ, БОГ, МХГ
< Шаардлагатай төсөв хөрөнгө >
Зөөврийн био-жорлон: 200 сая төгрөг

V.11 Нуранги зайлуулах

< 10 жилийн зорилт >
<ul style="list-style-type: none">Нуранги зайлуулах бэлтгэл, бэлэн байдлын тогтолцоог бий болгох
< Арга хэмжээ >
<ul style="list-style-type: none">Барилгын нуранги зайлуулах машин механизмын тооцоо судалгаа гаргаж, шаардлагатай машин механизмыг дайчлан ажиллуулах төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөг жил бүр тодотгох
< Хэрэгжүүлэх хугацаа >
2019~2024
< Хэрэгжүүлэх байгууллага >
ОБГ
< Шаардлагатай төсөв хөрөнгө >
500 сая төгрөг

VI. Боловсрол, олон нийт

VI.1 Гамшгаас хамгаалах боловсролын хөтөлбөр

< 10 жилийн зорилт >
<ul style="list-style-type: none">Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах боловсрол олгох хөтөлбөрийг ЕБС –ууд, дээд сургууль, коллежуудыг 100 % сургалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхГазар хөдлөлтийн гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалтад нийт иргэдийн 60 -аас доошгүй хувийг хамруулах
< Арга хэмжээ >
<ul style="list-style-type: none">Газар хөдлөлтийн аюулаас авран хамгаалах албан болон албан бус сургалтын стандарт,

<p>хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж сургалт, сурталчилгааг зохион байгуулах</p> <ul style="list-style-type: none"> Газар хөдлөлтийн үед биеэ хамгаалах болон газар хөдлөлтийн хор уршгийн талаар сургалт, сурталчилгааг радио телевизээр явуулах Шинээр баригдаж байгаа СӨБ газар хөдлөлтийн тэсвэртэй орчин үеийн техник технологиор барих, шаардлага хангахгүй барилга байшинг үе шаттайгаар хүчитгэх. (“1.3 Олон нийтийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах”-ыг үзэх) Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах боловсрол олгох хөтөлбөрийг ЕБС-д оруулах
<p><Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2029</p>
<p><Хэрэгжүүлэх байгууллага > БСУГ, ОБГ</p>
<p><Шаардлагатай төсөв хөрөнгө > Радио телевизийн нэвтрүүлгийн зардал: Жилд 8 сая төгрөг, 10 жилд 80 сая төгрөг.</p>

VI.2 Гамшгаас хамгаалах сургалтын материал

<p><10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалтын хэрэглэгдэхүүнийг шинээр хэвлэх олшруулах Гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалтыг их дээд сургуулийн заавал судлах хичээлийн жагсаалтанд оруулсантай холбогдуулан сурах бичгийг хэвлүүлэх, Ерөнхий боловсролын сурагчдыг дадлагажуулах хөгжүүлэхэд чиглэсэн газар хөдлөлтийн гамшгийн талаар дадлага сургалт, тэмцээн уралдаан зохион байгуулах заавар журмын эмхэтгэлийг боловсруулан хэвлүүлэх
<p><Арга хэмжээ ></p> <ul style="list-style-type: none"> Ерөнхий боловсролын болон их, дээд сургуульд хэрэгжүүлэх гамшгаас хамгаалах боловсролын хичээлийн сурах бичиг боловсруулах Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт дадлага зохион байгуулах үед гарын авлага, тараах материал боловсруулах Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах мэдлэг дээшлүүлэх зорилгоор уралдаан тэмцээн зохион байгуулах Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах мэдлэг дээшлүүлэх шторк, видео боловсруулан түгээнэ
<p><Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2029</p>
<p><Хэрэгжүүлэх байгууллага > Онцгой байдлын газар, Багийн засаг дарга, нийгмийн ажилтан нар, Боловсрол соёл урлагийн газар, Их дээд сургуулиудын консерциум</p>
<p><Шаардлагатай төсөв хөрөнгө > Гарын авлага тараах материал боловсруулан хэвлүүлэх-15 сая төгрөг Сургалтын хэрэглэгдэхүүн 10 сая төгрөг Шторк, видео сэрэмжлүүлэг хийх 10 сая 10 жилд 350,000 сая</p>

VI.3 Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагаа

<p><10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> Гамшгаас хамгаалах сайн дурын идэвхитний тоог нэмэгдүүлж, чадавхыг нь дээшлүүлэх Гамшгаас хамгаалах сайн дурын идэвхитнүүдийн иргэдэд чиглэсэн мэдлэг дээшлүүлэх үйл
--

ажиллагааг эрчимжүүлэх
<p>< Арга хэмжээ ></p> <ul style="list-style-type: none"> Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чиглэлээр ард иргэдэд сургалт дадлагыг сайн дурын идэвхитэнтэй хамтран зохион байгуулах Сайн дурын идэвхитнийг бүртгэлжүүлэх Сайн дурын идэвхитнийг сургах, дадлагажуулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах Сайн дурын гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон хүмүүнлэгийн тусламжийн сургалтын төв байгуулах
<p>< Хэрэгжүүлэх хугацаа ></p> <p>2019~2029</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага ></p> <p>Аймаг, сумдын засаг дарга нар, Онцгой байдлын газар, Улаан загалмайн хороо</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө ></p> <ul style="list-style-type: none"> Иргэдэд сургалт зохион байгуулахад 10 сая төгрөг Сайн дурын идэвхитнийг ахисан түвшинд сургах, дадлагажуулах 8 сая төгрөг Тараах материал 7 сая төгрөг Сургалтын төв байгуулах 150 сая төгрөг 10 жилд 1 тэрбум 750 сая төгрөг

VI.4 Орон нутгийн засаг захиргаа ба олон нийтийн харилцан уялдаа

<p>< 10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> Болзошгүй гамшиг аюулт үзэгдэлээс урьдчилан сэргийлэх, эрэн хайх аврах ажиллагаанд орон нутаг, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.
<p>< Арга хэмжээ ></p> <p>Газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагад Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм журам, норм, стандартын хэрэгжилтийг хангуулж үзлэг шалгалт, заавар зөвлөмж хүргүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулах. Аймаг, сум, багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, иргэдийн оролцоонд тулгуурлан жил бүрийн 4 дүгээр сард Газар хөдлөлийн гамшгаас урьдчилан сэргийлэх дадлага сургуулийг зохион байгуулах. Мэдээлэл технологийн албатай хамтран болзошгүй газар хөдлөлийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээлэл бүхий цахим сургалтыг боловсруулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд сурталчилан ухуулан таниулах.
<p>< Хэрэгжүүлэх хугацаа ></p> <p>2019~2029</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага ></p> <p>АЗДТГ, ОБГ, ГХМА, ГХМ-ийн анги, иргэд</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө ></p> <p>1.хуулийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаанд-3 сая 2.Ангилалын сургалт, дадлагын зардал-10 сая 3. Газар хөдлөлийн гамшгаас урьдчилан сэргийлэх цахим сургалт боловсруулж иргэд олон нийтэд сурталчлах-8 сая 10 жилд 138,000,000 төгрөг /138 сая/</p>

5. Хөрөнгө санхүүжилт шийдвэрлүүлэх, түүний хяналт удирдлага

5.1 Үндсэн чиглэл

- Онцгой Байдлын Газар нь гамшгаас хамгаалах холбогдох байгууллагын гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгөтэй холбоотой мэдээллийг жил бүр цуглуулж, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.
- Онцгой Байдлын Газар нь гамшгаас хамгаалах холбогдох байгууллагын гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн талаар мэдээлэлтэй байж, хэрэгжилтийн явцыг удирдан хянах.
- Хэрэгжилтийн явцыг удирдан хянаж, гарсан үр дүнг PDCA (төлөвлө, гүйцэтгэ, шалга, хэрэгжүүл) аргачлал дээр үндэслэн цаашид хэрэгжүүлэх гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тусгах.

5.2 Салбар тус бүрийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний чиглэл

(1) Барилга байгууламж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

【Хөрөнгө санхүүжилт шийдвэрлүүлэх】

- Гамшгийн эрсдэлийг бууруулах гол арга хэмжээ болох барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ, тэсвэржилтийг хангахад шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг нэн тэргүүнд шийдвэрлүүлэх.
- ИШС хариуцсан байгууллага нь гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүжилтийг төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллагаар шийдвэрлүүлэх ажилд оролцох.
- Орон нутгийн төсөвт тусгуулахын тулд Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулах.

【Хяналт удирдлага】

- Барилга байгууламж, дэд бүтэц, ИШС-ний байгууллагын төсөвт тусгуулах болон хэрэгжилтийн хяналтыг ТУЗ-ийн хурал дээр танилцуулах.

(2) Хүч хэрэгсэл, боловсрол, сургалт

【Хөрөнгө санхүүжилт шийдвэрлүүлэх】

- Улсын болон орон нутгийн төсөвт гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний нэг болох хүч хэрэгслээр хангах үйл ажиллагааны хөрөнгийг тусгуулах талаар зохих арга хэмжээ авах.
- Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд зориулан ОБЕГ-аас мэргэжилтэн томилуулах гэх мэт ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгуулах тал дээр ажиллах.
- Орон нутгийн төсөвт тусгуулахын тулд Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулах.

【Хяналт удирдлага】

- Гамшгаас хамгаалах байгууллага, онцгой комисс нь хөрөнгө төсөвлүүлэх ажил болон хэрэгжилтийн тогтмол хяналт удирдлагыг хэргжүүлэх.

(3) Мэдээлэл, харилцаа холбоо

【Хөрөнгө санхүүжилт шийдвэрлүүлэх】

- Салбарын байгууллага тус бүрийн хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлэхээс гадна хамтран хөрөнгө санхүүжилт шийдвэрлэх тал дээр ажиллах.
- Төрийн өмчит болон томоохон компаниудаас хөрөнгө санхүүжилт авах тал дээр ажиллах.

【Хяналт удирдлага】

- Байгууллага, ААН-ийн дотоод аудит, удирдлага хяналтад гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг оруулах.

(4) Эрүүл мэнд

【Хөрөнгө санхүүжилт шийдвэрлүүлэх】

- Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг төсөлд хамрагдах байдлаар шийдэх.
- Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тохирсон даатгалын системийг нэвтрүүлэн уялдуулах.

【Хяналт удирдлага】

- Эрүүл мэнд, эмнэлгийн байгууллагын дотоод аудит, удирдлага хяналтанд гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг оруулах.

(5) Гамшгаас хамгаалах арга хэмжээ

【Хөрөнгө санхүүжилт шийдвэрлүүлэх】

- Гамшгийн эрсдэлийг бууруулахад зориулсан төсвийн 1%-ийг зарцуулалтыг удирдан хянах.
- Гамшгаас хамгаалах байгууллагын гамшгийн эрсдэлийг бууруулах төсвийн бүрдүүлэлтийн талаар тухайн байгууллагад удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

【Хяналт удирдлага】

- ОБГ нь гамшгаас хамгаалах холбогдох байгууллагын гамшгийн эрсдэлийг бууруулах төсвийн бүрдүүлэлт, түүний хэрэгжилтийн явцын талаар мэдээлэлтэй байх.

Өмнөговь аймгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө

Гарчиг

1. Өмнөговь аймгийн танилцуулга
 - 1.1 Газар зүйн байдал
 - 1.2 Хүн ам, аж үйлдвэр
 - 1.3 Засаг захиргааны нэгж
 - 1.4 Өмнөговь аймагт тохиолдож байсан гамшиг, тулгарч буй асуудал
2. Эрсдэлийн үнэлгээ
 - 2.1 Үндсэн чиглэл
 - 2.2 Эрсдэлийн үнэлгээний аргачлал
 - 2.3 Гамшгийн үүсч болзошгүй цагийн байдал боловсруулах
3. Үндсэн чиглэл
 - 3.1 Үндсэн чиглэл
 - 3.2 Салбар тус бүрийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний чиглэл
4. Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ
 - I. Барилга байгууламж, хот байгуулалт, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ
 - II. Гамшгаас хамгаалах хүн хүч, техник хэрэгсэл
 - III. Мэдээлэл, харилцаа холбоо
 - IV. Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж
 - V. Гамшгаас хамгаалах арга хэмжээ, хүч хэрэгсэл
 - VI. Боловсрол, олон нийт
5. Хөрөнгө санхүүжилт шийдвэрлүүлэх, түүний хяналт удирдлага
 - 5.1 Үндсэн чиглэл
 - 5.2 Салбар тус бүрийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний чиглэл

1. Өмнөговь аймгийн танилцуулга

Өмнөговь аймаг нь 1931 онд орон нутгийн засаг захиргааны бүтэц шинээр зохион байгуулагдахад тус оны 2 дугаар сард байгуулагдсан. Өмнөговь аймаг нь Монгол улсын хамгийн өмнөд хэсэгт оршдог бөгөөд урд талаараа БНХАУ-тай, баруун талаараа Баянхонгор, баруун хойд хэсгээр Өвөрхангай, хойд талаараа Дундговь, зүүн талаараа Дорноговь аймгуудтай тус тус хиллэн оршино.

Газар зүйн байдал

Монгол улсын хэмжээнд хамгийн том 165,0 мянган кв.км нутаг дэвсгэртэй ба Алтайн нурууны үргэлжлэл Гурван сайхан, Сэврэй, Ноён богд, Номгон, Тост, Нэмэгт, Алтана уул, Гилбэнт зэрэг д.т.д. 3000 м хүртэл өндөр өргөгдсөн уул нурууд болон 100 гаруй км үргэлжилсэн Хонгорын элс, хэдэн 100 км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг, Сүүжийн алдарт их говиуд бий.



Зураг 1. Өмнөговь аймгийн байршил (Эх сурвалж: mn.wikipedia.org)

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр нь Төв Азийн хуурай, хуурайдуу говь, цөлийн бүсэд багтах бөгөөд далайн түвшинээс дээш 1300-1600м-н дундаж өндөрт оршино. Нутаг дэвсгэрийн хувьд хайрга чулуу элс ихтэй тачир сийрэг бэлчээрийн ургамалтай, уул нуруу, хонхор хөндий, тэгш тал, говь цөл алаглан оршдог.



Зураг 2. Өмнөговь аймгийн газар зүйн болон автозамын зураг

Эх газрын хуурай сэрүүн, эрс тэс уур амьсгалтай, өргөрөгийн дагуу буюу баруун талын уулархаг нутгаасаа зүүн тийш говь уруугаа болох тусам дулаардаг хуурай агаартай хөрсөнөөс уурших чийгийн нөөц бага, агаар нэн хуурай учраас хур тунадасны хэмжээ бага, салхи ихтэй учир шороон

шуургатай өдрийн тоо олон байдаг. Энэ онцлогоороо хөрсний физик өгөршүүлэл ихтэй, тариалан эрхлэхэд тохиромжгүй байдаг ч нар салхины эрчим хүчний их нөөцтэй нутаг юм.

Өвөлдөө -20-30 градус хүртэл хүйтэрдэг, дулааны улиралд халуун нь 30-38 градус, салхины хурд 5-15 м/сек, заримдаа 34-45 м/сек хүрдэг.

2. Засаг захиргааны нэгж

Өмнөговь аймаг нь 15 сум, 59 багтай. Аймгийн төв Даланзадгад хот. Аймгийн төв Даланзадгад хот нь Улаанбаатар хотоос 560 км зайтай. Монгол улсын хэмжээнд хамгийн том 165,0 мянган кв.км нутаг дэвсгэртэй ба хүн амын суурьшил сийрэг 3,4 квадрат километр нутагт 1 хүн, 13,2 квадрат километр нутагт 1 өрх ноогдон хүн ам суурьшиж байна.


3. Хүн ам, аж үйлдвэр

(1) Хүн ам

Өмнөговь аймаг нь 2018 оны жилийн эцэст 68114 хүн амтай болж 2017 оны жилийн эцсийн хүн амын мэдээнээс 3,7 хувиар буюу 2469 хүнээр өслөө. Нийт хүн амын 50,3 хувь эрэгтэйчүүд, 49,7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.


Хүснэгт 1. Өмнөговь аймгийн хүн ам, сумдаар (2014-2018 он)

Аймаг, сум	2014	2015	2016	2017	2018
Өмнөговь	59,665.	61,367.	63,661.	65,645.	69,124.
Даланзадгад	22,187.	22,873.	24,072.	24,863.	25,998.
Баяндалай	2,098.	2,053.	2,098.	2,082.	2,079.
Баян-Овоо	1,706.	1,686.	1,758.	1,733.	1,787.
Булган	2,076.	2,049.	2,066.	2,122.	2,093.
Гурвантэс	4,503.	4,569.	4,729.	4,869.	5,041.
Мандал-Овоо	1,622.	1,607.	1,628.	1,602.	1,629.
Манлай	2,522.	2,440.	2,499.	2,577.	2,586.
Ноён	1,347.	1,259.	1,357.	1,394.	1,408.
Номгон	2,572.	2,534.	2,567.	2,580.	2,560.
Сэврэй	2,015.	2,020.	2,055.	2,009.	2,002.
Ханбогд	5,057.	5,563.	6,387.	6,978.	8,632.
Ханхонгор	2,099.	2,025.	1,992.	2,010.	1,992.
Хүрмэн	1,610.	1,568.	1,590.	1,593.	1,547.
Цогт-Овоо	1,677.	1,662.	1,760.	1,811.	1,807.
Цогтцэций	6,574.	7,459.	7,103.	7,422.	7,963.



Зураг 3. Өмнөговь аймгийн хүн ам (2000-2018 он)

Хөдөлмөр эрхлэх насаар нь ангилвал 32,7 хувийг 0-15 насны хүүхэд, 61,4 хувийг 16-59 насны, 5,9 хувийг 60-аас дээш насны хүн ам эзэлж байна. Өрхийн тоо 21983 болж өмнөх оноос 609 өрхөөр буюу 3,3 хувиар өссөн дүнтэй байна.



Зураг 4. Өмнөговь аймгийн хүн амын ажил эрхлэлтийн байдал

(2) Аж үйлдвэр

Хүнс хөдөө аж ахуй

Газар тариалангийн салбарт нийт 253.1 га талбайд тариалалт хийсний 71.1 га талбайд төмс, 145.9 га талбайд хүнсний ногоо, 36.1 га талбайд тэжээлийн ургамал тариалснаас 571.6 тн төмс, 1050.2 тн хүнсний ногоо, 229.7 тн тэжээлийн ургамал хураажээ. Өмнөх онтой харьцуулахад ургац хураалт төмс 27.3 тн буюу 5.0 хувиар, хүнсний ногоо 330.5 тн буюу 45.9 хувиар өссөн бол тэжээлийн ургамал 46.6 тн буюу 16.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд нийт 7625.9 тн өвс, 983.7 тн гар тэжээл бэлтгэн нөөцөлсөн байна.

Мал аж ахуй

2018 оны эцэст 5951 малчин өрх байгаа нь өнгөрсөн оноос 132 өрхөөр өссөн байна. Аймгийн хэмжээнд 476 мянгат малчинтай болсон байна. Хамгийн олон малтай сумаар Номгон 262292, Ханхонгор 236686, Мандал-Овоо 209916, Манлай 205418, Булган 205265 толгой мал тус тус тоолуулсан байна. Малын таван төрлөөр нь авч үзвэл тэмээгээр Ханбогд сум 30431, адуугаар Манлай сум 12519, үхрээр Ханбогд сум 5022, хониор Манлай сум 70684, ямаагаар Номгон сум 202926 толгойгоор тус тус тэргүүлж байна. Ханбогд сум нь тэмээн сүргээрээ аймагтаа болон улсад тэргүүлж байна. 2018 онд нийт мал 2598440 толгой болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 55.9 мянган толгойгоор буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс тэмээ 11049, хонь 17432 толгойгоор тус тус өссөн, адуу 2107, үхэр 133, ямаа 82189 толгойгоор тус тус буурчээ.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт 2018 оны эхний 12 сарын байдлаар 2361.1 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1092.4 тэрбум төгрөгөөр буюу 86.1 хувиар өссөн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг салбараар авч үзвэл уул уурхайн олборлох үйлдвэр 2356.9 тэрбум төгрөг, хүнсний боловсруулах аж үйлдвэр 3.3 тэрбум төгрөг, цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэр 0.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

Эрүүл мэнд

Тус аймагт эрүүл мэндийн байгууллага 94 ажиллаж байгаагаас улсын төсвийн эмнэлэг 17, өрхийн эмнэлэг 4, цэргийн ангийн 3 эмнэлэг, хувийн эмнэлэг 25, хувийн эмийн сан 27, эргэлтийн эмийн сан 14, эм ханган нийлүүлэх төв 4 тус тус ажиллаж байна. 2018 оны эхний 12 сарын байдлаар аймгийн хэмжээгээр 1536 эх амаржиж, 323 хүн нас барсан нь урьд оны мөн үеэс төрөлт 18.4 хувиар, нас баралт 34.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд оны эхний 12 сарын байдлаар 0-1 насны хүүхдийн эндэгдэл 23 гарсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 10.0 хувиар өсч, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 2 гарсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 60.0 хувиар буурсан байна.

Банк санхүү

Манай аймагт Хаан, Хас, Төрийн банк, Голомт, Капитрон зэрэг банк санхүүгийн байгууллагууд иргэд аж ахуй нэгж байгууллагуудад санхүүгийн найдвартай үйлчилгээг шуурхай үзүүлж байна. Олон улсын мөнгөн гуйвуулагын Western union, Money gram болон олон улсын картын үйлчилгээ болон доллар, евро, рубль, юань зэрэг мөнгөн тэмдэгтийг солилцох боломжоор бүрэн хангагдсан. Тус аймаг нь өөрөө өөрийгөө бүрэн санхүүжүүлдэг төдийгүй жилдээ 66.1 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлдэг санхүүгийн хувьд бэхжсэн томоохон аймгуудын нэг юм.

Хот байгуулалт дэд бүтэц

Өмнөговь аймгийн нийт өрхийн 42,3 хувь нь төвлөрсөн усан болон дулааны хангамж бүхий орон сууцанд амьдардаг. Манай аймгийн нутаг дэвсгэр дээгүүр Дундговь, Улаанбаатар хотыг холбосон 560 км олон улсын чанартай авто зам хатуу хучилттай орон нутгийн зам тус тус дайран өнгөрдөг. Аймгийн төв болон томоохон сум суурин дотор авто болон явган хүний хатуу хучилттай замтай. Дэд бүтэц сайн хөгжсөн аймаг. Олон улсын болон дотоод бүх цэгт холбогдсон холбооны сүлжээтэй. Мобиком, Скайтел, Юнител, Жи-мобайлийн үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 68 мянгад

хүрч бүх сумд, төв суурин газруудад шилэн кабелийн сүлжээ нэвтэрсэн. Үндэсний олон нийтийн телевиз болон орон нутгийн UCTV, Алтанговь, Говийн наран зэрэг телевизийн сувгаар иргэдэд үйлчилж байна. Малчин өрхүүд сэргээгдэх эрчим хүчний эх үүсгэвэрээр бүрэн хангагдсан. Аймгийн хэмжээнд үсчин гоо сайхан зурагчин. цаг , Телевизор засвар, хими цэвэрлэгээ зэрэг нийтийн ахуй үйлчилгээний 80 орчим, худалдаа нийтийн хоолны 540 гаруй цэг ажиллаж байна. Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн цогцолбор барихад зориулж 410 гаруй га талбай олгогдсон бөгөөд цогцолборын ерөнхий төлөвлөгөө гарч дэд бүтэц инженерийн хангамжийн барилга байгууламжийг барьж байгуулах ажил өрнөж байна.

Аялал жуулчлал

Аймгийн төвөөс баруун зүгт 220 км Сэврэй сумын нутагт 800 м өндөр, 150 км үргэлжилсэн Хонгорын голын үзэсгэлэнт элсэн уул, Монгол улсын алдарт 33 говийн нэг хэсэг болох хэдэн арван км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг сүүжийн алдарт их говиуд, 50-120 сая жилийн тэртээ амьдарч байсан эртний үлэг гүрвэлийн чулуужсан яс, өндөг, чулуужсан мод зэрэг палентологийн олдворууд олдсон. Булган сумын нутагт байдаг Баян заг дэлхийд ховорт тооцогдох Нэмэгт, хэрмэн цав, Шаригийн ганга, Бүгийн цав, зэрэг байгалийн тогтоц бүхий үзэсгэлэнт газрууд, онгон зэрлэг байгаль, Хутагт Данзанравжаагийн байгуулсан энергийн төв болох Дэмчогийн хийд, Аймгийн хамгийн баруун сум болох Гурвантэс сумын нутагт байдаг Хэрмэн цав, Аймгийн хамгийн зүүн сум болох Манлай сумын нутагт байдаг үлэг гүрвэлийн чулуужсан мөр Дэлхийд ховордсон ан амьтан, ховор төрлийн ургамлаараа гадаадын жуулчин, аялагчдын сонирхлыг ихээхэн татаж байна.

4. Өмнөговь аймагт тохиолдож байсан гамшиг

Өмнөговь аймагт сүүлийн 15 жилд тохиолдсон байгалийн аюулт үзэгдэл болон ослын талаарх дүн мэдээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Голчлон тохиолдсон байгалийн аюулт үзэгдлийн тоо /15 жилээр/

Гамшгийн төрөл		Гамшгийн нэр	Тохиолдсон гамшгийн тоо
Байгалийн гаралтай	Цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл	Хүчтэй салхи, шуурга	26
		Цас зуд	5
		Үер	8
		Ой, хээрийн түймэр	-
		Аянга	1
	Геологийн гаралтай аюул	Газар хөдлөлт	14
	Биологийн гаралтай аюул	Хүний гоц халдварт өвчин	2
Мал, амьтны гоц халдварт өвчин		36	
Хүний үйл ажиллагаатай холбоотой	Объектийн гал түймэр		392
	Усны осол		8
	Тэсэрч, дэлбэрэх, шатамхай, химийн бодисын осол		6
	Үйлдвэрийн осол		1
НИЙТ			499

Өмнөговь аймгийн хэмжээнд гарсан гамшиг ослын сүүлийн 15 жилийн судалгаанаас үзэхэд цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдэл, мал, амьтаны гоц халдварт өвчлөл, хүн амын нягтаршил,

үйлдвэржилт, техник, технологийн хөгжил дэвшлийг даган гарах гамшиг ослын тоо, давтамж нэмэгдэж түүнээс учрах хохирлын хэмжээ ихсэх хандгатай байна.

Иймд гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх, эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийг гамшгаас хамгаалах арга ажиллагаанд сургаж дадлагажуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах шаардлагатай.

Гамшгаас хамгаалах алба, ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадварыг сайжруулах, техник хэрэгслийн хүчин чадал, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээг орон нутгийн удирдлага, төр, захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж орон нутгийн гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллах шаардлагатай байна.

Өмнөговь аймаг нь Одон орон, геофизикийн хүрээлэнгийн гаргасан тооцоогоор газар хөдлөлтийн 9-10 баллын идэвхтэй бүсэд оршдог байна. Тус бүсд Алтайн уулсын үргэлжлэл Их, Бага богд, Говь гурван сайхан, Нэмэхт, Гилбэнт зэрэг уул нуруудтай төв суурингууд нь газар хөдлөлтийн идэвхитэй бүс нутагт байрлах ба хуучин барилга байгууламж ихтэй, газар хөдлөлтийн нөлөөллийн инженерийн тооцоололгүй баригдсан барилгууд байдаг. Эдгээр хуучин болон чанар муутай баригдсан барилга байгууламж нь 6-7 магнитудыг тэсвэрлэхгүй эвдэрч олон хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, сум, аймаг, улс орны эдийн засаг нийгэмд их хэмжээний хохирол үүсгэх эрсдэлтэй.

Бүсийн нийт нутаг дэвсгэрт шороон болон цасан шуурга салхины хурд 20м/с-ээс дээш тохиолдох нь элбэг байдаг боловч урд талаараа БНХАУ-тай хиллэж Гашуун сухайт, Шивээ хүрэнгийн хилийн боомтууд байнгын үйл ажиллагаатай тул олон улсын хөл хориот өвчний халдвар тээгч орж ирэх магадлалтай. Иймд хилийн боомтын хяналтыг сайжруулах сургалт дадлага зохион байгуулах шаардлагатай.

Цаашид зарлан мэдээллийн системийг боловсронгуй болгох аймаг, сум, аж ахуйн нэгж байгууллага, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, багаж хэрэгсэл тоног төхөөрөмжөөр хангах, нөөцийг нэмэгдүүлэх замаар гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулах, гамшгийн төрлүүдээр мэргэжлийн байгууллагаар эрсдлийн үнэлгээг хийлгэх урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

2. Эрсдэлийн үнэлгээ

(1) Үндсэн чиглэл

Одоогийн байдлаар хийсэн судалгаа болон ажиглалтын үр дүнд үндэслэн ирээдүйд Даланзадгад хотод үүсч болзошгүй газар хөдлөлтийн гамшгийн хохирлын ерөнхий дүр зургийг газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний үр дүнгээр харуулав.

Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний үр дүнд гаргасан хохирлын төсөөллийг дараах зүйлсийг сайтар ойлгосны үндсэн дээр ашиглах нь зүйтэй.

【Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийхэд анхаарах асуудал】

- Эрсдэлийн үнэлгээнд авч үзсэн газар хөдлөлтийн хүчийг БХБЯ-ны “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм”-д заасан газар хөдлөлтийн шаталбар (МСК 8)-ын дагуу авав. Даланзадгад хотод хохирол үүсгэж болзошгүй газар хөдлөлтийн хүч нь үүнээс ч илүү байх магадлалтай.
- Эрсдэлийн үнэлгээгээр тооцоолсон нийт нутаг дэвсгэрийн хохирлын цар хүрээ болон хохирол илүү гарах хэсэг нь газар хөдлөлтийн голомтын байршил, түүний чиглэлээс хамааран хэлбэлзэнэ. Үүний улмаас, бодит хохирол ба төсөөлөгдөх хохирлын нөхцөл байдал нь өөр өөр байх магадлалтайг харгалзаж үзэх хэрэгтэй.

(2) Эрсдэлийн үнэлгээний аргачлал

Эрсдэлийн үнэлгээний аргачлал нь ОБЕГ-ын Ажлын хэсгийн боловсруулсан “Газар хөдлөлтийн хохирлыг хялбаршуулсан аргаар тооцох эксел хүснэгт”-ийг ашигласан болно. Уг эксел хүснэгтийн тооцооллын аргачлалыг ОБЕГ боловсруулсан бөгөөд одоогийн байдлаар ОБЕГ-ын даргаар батлуулах шатанд буй “Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний заавар”-т тусгагдсан газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний аргачлалд суурилсан болно.

1) Газар хөдлөлтийн хүч

“Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм”-д заасан шаталбарын дагуу Даланзадгад хотын газар хөдлөлтийн хүч нь VIII балл юм. Энэхүү газар хөдлөлтийн хүчийг ашигласан болно.

2) Барилгын хохирол

Барилга байгууламжийг түүний зориулалтын дагуу орон сууц, эзэмшлийн орон сууц, олон нийтийн барилга, гэр болон бусад төрлийн орон сууц гэж ангилсан бөгөөд “Газар хөдлөлийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар”-т үндэслэн хуучин барилгыг газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн 13 зэргээр мөн ангилав. Газар хөдлөлтийн хүчийн баллыг оруулж газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн 13 зэрэг тус бүрийн хохирлын хувь тооцоологдох тул уг хувь хэмжээг барилгын тоо ширхэгт үржүүлж нурах болон ихээр эвдрэх барилгын тоог тооцоолж гаргав.

3) Хүний хохирол

Нас барсан хүний тоо, гэмтсэн хүний тоог нурсан болон ихээр эвдэрсэн барилгад оршин сууж байсан ерхийн тооноос тооцоолж гаргав. Нийтийн орон сууц болон эзэмшлийн орон сууцанд оршин сууж буй ерхийн тоог тус бүр тооцож эксел хүснэгтэд оруулж тооцоо хийгдэнэ.

4) Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ

Зам, гүүр, цэвэр ба бохир усны шугам, цахилгаан дамжуулах агаарын шугам болон цахилгааны шонгийн тухайд, тус бүрийн хөрсний байдал, гүүрийн төрөл, шугам хоолойн төрөл болон диаметр, хийц гэх зэрэг өгөгдлийг оруулж газар хөдлөлтийн улмаас үүсэх хохирлын хувь хэмжээг тооцоолж эвдрэл гарах цэгийн тоо болон шугамын уртыг гаргасан болно.

Эдгээр хохирлын тооцооллын дүнг Хүснэгт 2.1-д нэгтгэв.

Хүснэгт 2.1. Даланзадгад хотын газар хөдлөлтийн үүсч болзошгүй хохирлын төсөөлөл

Хохирлын төрөл			Хохирлын хэмжээ	Нэгж
Хүний хохирол	Нас барсан хүний тоо		216	хүн
	Гэмтэж бэртсэн хүний тоо		268	хүн
	Гэр оронгүй болсон хүний тоо		3650	хүн
Барилгын хохирол	Нурсан, их хэмжээгээр эвдэрсэн	амины сууц	671	ширхэг
		орон сууц	12	ширхэг
	Нурангийн хэмжээ			тонн
Дэд бүтэц, ИШС	Зам	Нэвтрэх боломжгүй болсон	1	цэг
	Гүүр	А аргачлал (нурсан)	байхгүй	
		В аргачлал (засварлах шаардлагатай)	байхгүй	
	Цахилгааны шон	Нурсан	0	ширхэг
	Цахилгааны шугам	Хохирлын хувь	3.5	%
	Газар доорх шугам	Хохирлын хувь	0.5	%
	Цэвэр ус	Эвдэрсэн	6	цэг
	Бохир ус	Хохирлын хувь	3	%
	Дулаан	Эвдэрсэн	1	цэг

(3) Гамшгийн үүсч болзошгүй цагийн байдал боловсруулах

Хохирлын төсөөлөл дээр үндэслэн 1. Хот төлөвлөлт, барилга байгууламж, дэд бүтэц, ИШС, 2. Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, 3. Байгаль орчин, 4. Гамшгаас хамгаалах арга хэмжээ, хүч хэрэгсэл, 5. Боловсрол, олон нийтийн оролцоо, 6. Мэдээлэл харилцаа, гэсэн салбаруудаар гамшгийн цагийн байдлыг боловсруулсан.

1) Хот төлөвлөлт, барилга байгууламж, дэд бүтэц, ИШС

- ✓ 683 ширхэг барилга нурсан ба ихээр эвдэрсэн, барилга нурсаны улмаас 216 хүн нас барах, 268 хүн бэртэж гэмтэх. Мөн, 3650 хүн гэр оронгүй болох.
- ✓ Сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон иргэдийн олноороо цуглардаг үзвэр, худалдаа үйлчилгээний газрын барилга байгууламжид ихээхэн хохирол үүсэх.
- ✓ Цэвэр усны шугамд 6 цэг дээр гэмтэл гарч 900 гаруй хэрэглэгчийг цэвэр усаар хангах боломжгүй болох.
- ✓ Бохир усны шугам эвдэрснээс шалтгаалан хөрсний бохирдол үүсэх.

2) Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж

- ✓ Нэгдсэн эмнэлэг 1, өрхийн эрүүл мэндийн төв 5, сумдын эмнэлэг 15 байгаагаас Даланзадгад хотод нийт 7 эмнэлэг байдаг бөгөөд 268 бэртэж гэмтсэн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэхэд хүн хүч дутагдаж хүндрэл үүсэх.
- ✓ Аймгийн хэмжээнд 68 эмч, 59 эмнэлгийн ажилтан байгаа бөгөөд сумдаар тархсан байдаг тул яаралтай эмнэлгийн тусламж үзүүлэхэд Даланзадгад хотод цугларахад цаг хугацаа шаардлагатай болж хүндрэл үүснэ.
- ✓ Тоноглогдсон түргэн тусламжийн автомашин аймгийн хэмжээнд 6 ширхэг байдаг бөгөөд бэртэж гэмтсэн хүн болон бусад өвчтөнийг тээвэрлэхэд хүндрэл үүсэх.

3) Байгаль орчин

- ✓ Бохир усны шугам эвдэрснээс шалтгаалан хөрс бохирдож, байгаль орчинд хор хөнөөл учруулах.
- ✓ Нурангийн хэмжээ 3000 тоннд хүрэх бөгөөд 10 тонны ачааны машинаар тооцоход 300 машин/удаа рейс хийх шаардлагатай болно. Нуранги хаях зориулалтын цэгийг төлөвлөж тогтоогоогүй, нуранги зайлуулах ажил саатах.

4) Гамшгаас хамгаалах арга хэмжээ, хүч хэрэгсэл

- ✓ Гамшгийн нөөц дутагдаж гамшигт нэрвэгдэгсдэд хүрэлцэхгүй болох.
- ✓ Эрэн хайх, аврах ангийн бие бүрэлдэхүүн аймгийн хэмжээнд 580 алба хаагч, машин тоног төхөөрөмж 90 ширхэг байгаагаас сумдад тархан байрлаж байгаа тул Даланзадгад хотод гамшгийн үед хариу арга хэмжээ явуулахад хүндрэл үүсэх магадлал өндөр байх.
- ✓ Гэр оронгүй болсон 3650 хүнийг түр хоргодох байранд багтаах хүчин чадал дутагдана. Түр хоргодох байр томилгоожуулсан боловч түр хоргодох байр болгож ашиглахад шаардлагатай техник тоног төхөөрөмж, түр хогодох байрын нөөц байхгүйгээс үйл ажиллагаа явуулах боломжгүй.

5) Боловсрол, олон нийтийн оролцоо

- ✓ 2017 оноос их, дээд сургуулиудад гамшгаас хамгаалах боловсрол олгох үйл ажиллагаа эхлээд удаагүй байгаа тул мэдлэг, мэдээлэл хомс байгаа тул түргэн тусламж үзүүлэх гэх зэрэг ажилд дэмжлэг үзүүлэх боломжгүй байх.
- ✓ Сургуулийн болон сургуулийн өмнөх боловсролын багш, сургагч нарт зориулсан “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөр хэрэгжиж эхлээд удаагүй байгаа тул сургуулийн орчинд хүүхдүүд олноор гамшигт нэрвэгдэх.
- ✓ Нүүлгэн шилжүүлэх дадлага сургууль 2017 оноос хойш явагдаж байгаа боловч гамшигт нэрвэгдэгсэд нүүн шилжих явц удаашралтай, зохион байгуулалт муутай явагдах.

6) Мэдээлэл харилцаа

- ✓ Суурин болон үүрэн телефоны холбоо, факс, интернэтийн үйлчилгээ нь кабель шугам болон антенны эвдрэлээс болж ажиллагаагүй болох.
- ✓ Алслагдсан орон нутгийн харилцаа холбооны тоног төхөөрөмжийг яаралтай засварлах, сэргээн босгох ажиллагааг явуулах хүч хэрэгсэл дутагдаж саатах.

Дээрх цагийн байдалд үндэслэн гамшгийн үед авах арга хэмжээг сайжруулахад чиглэсэн 10 жилийн зорилтыг дэвшүүлж, тус зорилтод хүрэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлж, зохистой арга хэмжээг төлөвлөн, тухайн арга хэмжээг эрэмбэлэх, шаардагдах төсөв хөрөнгийн талаар тооцоо судалгаа хийж төлөвлөгөө боловсруулав.

3. Үндсэн чиглэл

(1) Үндсэн чиглэл

- Байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах.
- Эрсэдлийг бууруулах төлөвлөгөө, сургалт, дадлагын үйл ажиллагааг боловсронгуй болгох.

(2) Салбар тус бүрийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний чиглэл

1) Барилга байгууламж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

- Олон нийтийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг үнэлэх чиглэлээр 2019 онд орон нутгийн төсөвт 100 сая төгрөг батлагдаж, паспортжуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. 2019 онд батлагдсан хөрөнгөнд нэн яаралтай хамруулах 96 барилгыг багцлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан байна.
- Цаашид, 2020, 2021 онуудад шат дараалан тухайн ажлыг хийж гүйцэтгэн газар хөдлөлтийн тэсвэрлэх чадварыг хангах чиглэлээр бэхэлгээ хүчитгэлийн ажлуудыг хийж гүйцэтгэх.

2) Хүч хэрэгсэл, боловсрол, сургалт

- Гамшгаас хамгаалах байгууллагын хүн хүч, техник хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.
- Гамшгаас хамгаалах байгууллага, албадын төлөвлөгөө, сургалт дадлагыг төлөвшүүлэх.
- Боловсролын системд гамшгаас хамгаалах сургалтыг боловсронгуй болгон хөтөлбөрт оруулах.

3) Мэдээлэл, харилцаа холбоо

- Гамшгаас хамгаалах байгууллага ба иргэдийн мэдээллийн сүлжээ, холбооны зохион байгуулалтыг сайжруулах, дэвшилтэт технологийг ашиглаж нэвтрүүлэх.
- Шинээр мэргэжлийн боловсон хүчинг нэмэгдүүлэх.

4) Эрүүл мэнд

- Гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эмч, мэргэжилтэн. Эм эмнэлгийн хэрэгсэл, шаардлагатай тоног төхөөрмжийн хангалт нөөцийг нэмэгдүүлэн бэлэн байдалд байлгах.
- Эмнэлгийн хог хаягдал, хоол хүнсний аюулгүй байдал, бие засах газрын халдваргүйжүүлэлтийг хангах тогтолцоо, зохион байгуулалтыг сайжруулах.

5) Гамшгаас хамгаалах арга хэмжээ

- Гамшгаас хамгаалах байгууллагын эрсдэлийг даван туулах чадавхийг дэс дараатайгаар нэмэгдүүлэх. (1-2 жил, 3-5 жил, 5-10 жил)
- Гамшгаас хамгаалах албад, иргэдэд зориулсан сургалт сурталчилгааг тогтмолжуулах, өргөтгөх, үр дүнд хүргэх.
- Иргэд эрсдэлийг тооцох арга аргачлал чадавхитай болно.
- Иргэд орон нутагт гамшиг ослыг хохирол багатай даван туулах чадварыг сайжруулах.

4. Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ (Өмнөговь аймаг Даланзадгад хот)

1. Барилга байгууламж, хот байгуулалт, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ

1.1 Гамшгаас хамгаалах хот төлөвлөлт

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">Барилга байгууламж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний 30 хүртэл хувийн шинэчлэн сайжруулсан байх.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">Гамшгаас хамгаалах хот төлөвлөлтийн төлөвлөгөөг шинэчлэхХот төлөвлөлт, барилгажилт, дэд бүтэц, бүтээн байгуулалттай холбогдуулан эрсдэлийн үнэлгээ хийхАймаг, сумын жил жилийн төсөв, үндсэн чиглэлийг ЗД-ын мөрийн хөтөлбөрт хөрөнгийг суулгах
< Хэрэгжүүлэх хугацаа > 2020~2024
< Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, СЗДТГ, МХГ, ГХБХБГ, ОБГ
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 3 тэрбум төгрөг

1.2 Засаг захиргааны байгууллагын барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">Төрийн байгууллагын барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийж тэсвэржилтийг хангах
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">Барилга байгууламжийн насжилт, газар хөдлөлтөнд тэсвэрлэх чадавхийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар нарийвчилсан үзлэг хийж тогтоолгохБарилга хувийн хэрэгтэй болгохТэсвэржилтийг хангах, хүчитгэх арга хэмжээнд шаардагдах санхүү, зардлын тооцоог аймгийн үндсэн чиглэлд жил бүр суулганШаардлага хангахгүй барилга байгууламжуудыг буулгаж, дахин төлөвлөх
< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2021
< Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, СЗДТГ, ГХБХБГ, МХГ, ОБГ
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 100 сая төгрөг /паспортжуулалт/, 2020, 2021 онуудад шаардлагатай төсөв хөрөнгийг суулгаж өгөх

1.3 Олон нийтийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">Барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийлгэж гарсан үр дүнг 30 %-аар дээшлүүлж тэсвэржүүлэх
< Арга хэмжээ >

<ul style="list-style-type: none"> • Олон нийтийн болон орон сууцны барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийх ажлыг шуурхай зохион байгуулах • Дахин төлөвлөлтөнд оруулах барилга байгууламжийн шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх
<p>< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2024</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, СЗДТГ, МХГ, ГХБХБГ, ОБГ, БСГ, НБХэлтэс, Эрүүл мэндийн газар</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө > Аймгийн төсвөөс.</p>

1.4 Орон сууцны барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

<p>< 10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> • Орон сууцны барилгад газар хөдлөлтийн улмаас учирч болзошгүй хохирлын эрсдэлийг 60 %-иар бууруулах
<p>< Арга хэмжээ ></p> <ul style="list-style-type: none"> • Орон сууцны барилга болон аж ахуйн аргаар барьсан барилга барьсан барилга байгуулмжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээг нэгдсэн журмаар хийх • Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцны оршин суугчидтай харилцан трхиролцсны үндсэн дээр нь дахин төлөвлөлтөд оруулах
<p>< Хэрэгжүүлэх хугацаа > 2020~2024</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, СЗДТГ, МХГ, ГХБХБГ, ОБГ</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө ></p>

1.5 Зам байгуулалт, замын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

<p>< 10 жилийн зорилт ></p> <ul style="list-style-type: none"> • Зам засварын ангийн техник хэрэгслийг сайжруулан бэхжүүлж, авто замын хүчитгэл, засвар болон шинээр барьж байгуулах ажлыг урт хугацааны төлөвлөлттэй уялдуулж хэрэгжүүлэх
<p>< Арга хэмжээ ></p> <ul style="list-style-type: none"> • Зам засвар, зам барих ажлыг эрчимжүүлэх • АЗЗА-н үйл ажиллагааг сайжруулах • Тоног төхөөрөмжийг жил бүр нэмэгдүүлэх • Санхүүгийн асуудлыг орон нутаг болон улсын төсөвт суулгах
<p>< Хэрэгжүүлэх хугацаа > 2020~2025</p>
<p>< Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, СЗДТГ, Дардан говь, Дам зам</p>
<p>< Шаардлагатай төсөв хөрөнгө > Орон нутгийн төсөвт суулгах.</p>

1.6 Гүүрийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

< 10 жилийн зорилт > Гүүрийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангаж гамшгийн эрсдэлийг бууруулах.
< Арга хэмжээ > • Аймгийн хэмжээнд 3 гүүр байдаг бөгөөд гүүрийн үзлэг шалгалт хийх.
< Хэрэгжүүлэх хугацаа > 2020~2024
< Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, СЗДТГ
< Шаардлагатай төсөв хөрөнгө >

1.7 ИШС-ий газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

< 10 жилийн зорилт > • ИШСүлжээний газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах
< Арга хэмжээ > • Цахилгааны эх үүсвэр болох ДЦС-ын шинэчлэл хийх, зураг төсөл гаргах • Олон жил болж хуучирч муудсан шугам сүлжээг шинэчлэх (төсөв гаргах) • ЦДАШ болон дэд станцуудын насжилтийг тогтоох, шинэчлэх • ЦДАШ-ын бетон тулгуурыг шинэчлэх, шаардлагатай газарт кабель шугам хийх • Цэвэр, бохир шугамын шинэчлэлт хийх • ИШСүлжээний ТП-ний угсралт бэхлгээ, газардуулга, сувагжилтын дутуу хийгдсэн ажлыг хийж дуусгах, шинээр хийх • ИШСүлжээний байршлын зургийг олон жилийн хэтийн төлөвийг тооцоолж гаргах • Техникийн албыг газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалтанд хамруулах • Техник, технологийн бүрэн бүтэн байдал, шинэчлэлтийн талаар төлөвлөгөө гаргах • ИШС-г шинэчлэн сайжруулахад шаардагдах машин, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх
< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2025
< Хэрэгжүүлэх байгууллага > ДЦСтанц, Дулаан хангамж, ӨМБЦТС ТӨХК, МХЕ ТӨХК
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 5 тэрбум төгрөг

1.8 Хорт химийн бодис гэх мэтийг хадгалдаг аюул бүхий барилга байгууламжийн тэсвэржилтийг хангах

< 10 жилийн зорилт > • Химийн хортой болон аюултай материалын хадгалах, ашиглах, харьцах стандартыг хангаж, болзошгүй эрсдэлийг бууруулах
< Арга хэмжээ > • Стандартын лабораторид хадгалах, хугацаа дууссаныг нь устгах • Химийн бодисын судалгаа гаргаж, яаралтай устгах ажлыг 2019 онд шийдвэрлэх • Хугацаа дууссан бодис устгах арга техник судлах • Химийн бодисын стандартын лаборатори, сургалтын баазаар хангах
< Хэрэгжүүлэх хугацаа >

<Хэрэгжүүлэх байгууллага>
<Шаардлагатай төсөв хөрөнгө>

2. Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж

2.1 Эмнэлэг, орны тоо

< 10 жилийн зорилт >
<ul style="list-style-type: none"> Эмнэлгийн ор, эм эмийн хэрэгслийн хэрэгцээт нөөцийг бүрдүүлж, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн барилгуудад газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээг хийх.
< Арга хэмжээ >
<ul style="list-style-type: none"> Төсөв хөрөнгийн тооцог гаргаж, шийдвэрлүүлэх Хүний нөөцийг бодлогоор сургах (Зөгийн үүр хөтөлбөр) Төрийн албан хаагчийн дэмжих хөтөлбөрт шаардлагатай хүний нөөцийг хамруулах. Эрүүл мэндийн яам, НЭМҮТ, бусад холбогдох байгууллагад хүсэлт илгээж, дэмжлэг авч ажиллах Онцгой комиссын шийдвэрээр салбар дундын хамтын ү/а-г өрнүүлэх Хувийн хэвшлийн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулах
< Хэрэгжүүлэх хугацаа >
<ul style="list-style-type: none"> Өрхийн ЭМТөвийг байгуулахаар - 5-10 жил Гэмтлийн тасгийг байгуулах - 2 жил ЯТТ-н хэсгийг сайжруулах - 3 жил Эмч бэлдэх - 2-8 жил
< Хэрэгжүүлэх байгууллага >
Аймгийн Онцгой комисс, АЗДТГ, НБХ, ЭМГ, 15 сумын ЭМТ, Өрхийн ЭМТ
< Шаардлагатай төсөв хөрөнгө >
5 тэрбум 500 сая төгрөг

2.2 Эмч, сувилагч

< 10 жилийн зорилт >
<ul style="list-style-type: none"> Яаралтай тусламж, эрэмбэлэн ангилалт, гэмтэл мэс заслын эмч, мэргэжилтнийг үе шаттай бэлтгэх. Хүүхдийн болон тусгаарлах хэсэг байгуулах талаар төлөвлөгөөнд оруулж, хүний нөөц бэлтгэх.
< Арга хэмжээ >
<ul style="list-style-type: none"> Аймгийн онцгой комиссд танилцуулах төсвийг үе шаттай шийдвэрлүүлэх Орон нутагт гэрээ хийж боловсон хүчний нөөц бэлдэх. Эрүүл мэндийн салбарын боловсон хүчинг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх Дотоод зохион байгуулалтыг сайжруулах Хөгжлийн сургалт зохион байгуулах
< Хэрэгжүүлэх хугацаа >
2019~2029
< Хэрэгжүүлэх байгууллага >
АЗДТГ, НБХ, БОЭТ, ЭМТ, 15 сумын ЭМТөв, ӨЭМТөв
< Шаардлагатай төсөв хөрөнгө >

1 тэрбум 500 сая төгрөг

2.3 Хээрийн эмнэлэг

< 10 жилийн зорилт > Тоног төхөөрөмж, материаллаг баазын хангалтыг сайжруулж хээрийн эмнэлэг байгуулах чадавхийг бэхжүүлэх.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">• Туршлага судлах, олон улсын сургалтад хамрагдах• Гал тогооны хэрэгсэл, нөөцийг бий болгох• Шинжилгээ хийх зөөврийн багаж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах
< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2029
< Хэрэгжүүлэх байгууллага > Аймгийн онцгой комисс, НБХ, БОЭТ, ЭМГ
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 890 сая төгрөг

2.4 Эмийн нөөц

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">• Эм эмийн хэрэгслийн хэрэгцээт нөөцийг нэмэгдүүлж бэлэн байдлыг хангах.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">• Хувийн хэвшлийн эмийн бөөний төвтэй онцгой үед хамтарч ажиллах гэрээ байгуулах• Эмийн бөөний төв, хувийн эмийн сангаас тусламж дэмжлэг авах
< Хэрэгжүүлэх хугацаа > Сургалтууд зохион байгуулах, гэрээ байгуулах: 2019~2020, цаашид жил бүр
< Хэрэгжүүлэх байгууллага > Аймгийн онцгой комисс, БОЭТ, Эмийн холбоо, НБХ, ЭМГ
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 690 сая төгрөг

2.5 Мэдээлэл дамжуулах

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">• Радио холбооны хангалтыг бүрдүүлж мэдээлэл дамжуулах тогтолцоог бэхжүүлэх.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">• Эмнэлгийн ажилтнуудад сургалт зохион байгуулах• Богино долгионы станцаар бүх ЭМ-ийн байгууллагыг хангах• Радио холбоо ашиглах хялбарчилсан журам гаргах
< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2029
< Хэрэгжүүлэх байгууллага > Онцгой комисс, АЗДТГ, НБХ, ЭМГ, БОЭГ
< Шаардлагатай төсөв хөрөнгө >

1 тэрбум төгрөг

2.6 Тээврийн зохион байгуулалт

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">• Эмнэлгийн түргэн тусламжийн машин болон тоног төхөөрөмжийн хангалт, сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлэх.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">• Иргэдийн авто машиныг дайчлах• Орон нутагт болон улсын тсөвт үе шаттай авто машин суулгах• Төсөл хөтөлбөр бичих
< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2023
< Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, НБХ, БОЭТөв
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 800 сая төгрөг

2.7 Халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">• Халдвар судлал, халдваргүйжүүлэлтийн мэргэжлийн боловсон хүчний хангалтыг бүрдүүлэх
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">• Халдвар судлаач эмч бэлтгэх• Сургалт тогтмол зохион байгуулах
< Хэрэгжүүлэх хугацаа > 2021~2024
< Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, БОЭТөв, ЭМГ
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 100 сая төгрөг

2.8 Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх

< 10 жилийн зорилт > <ul style="list-style-type: none">• Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйч эмч 2 хүн бэлдэх.
< Арга хэмжээ > <ul style="list-style-type: none">• Гамшгийн үед ажиллах сэтгэл зүйч эмч нарыг тусгайлан бэлдсэн байх.• Сэтгэл зүйн тусламж үзүүлэх талаарх сургалт зохион байгуулах
< Хэрэгжүүлэх хугацаа > 2019~2022
< Хэрэгжүүлэх байгууллага > АЗДТГ, БОЭТөв, ЭМГ
< Шаардлагатай төсөв хөрөнгө > 8 сая төгрөг

3. Байгаль орчин

3.1 Хог хаягдлын арга хэмжээ

Ажлын хэсгийг 4 бүлэгт хуваана. Тухайлбал, 1-р бүлэг “Хот байгуулалт, газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг хангах”, 2-р бүлэг “Хүч хэрэгсэл, харилцаа холбоо”, 3-р бүлэг “Эрүүл мэнд, гамшгаас хамгаалах арга хэмжээ”, 4-р бүлэг “Боловсрол, сургалт” гэж ангилна. Бүлэг тус бүр доорх хүснэгтэд үзүүлсэн агуулгын дагуу Төлөвлөгөө боловсруулах ерөнхий дараалалд дурдсан /6/ Цагийн байдал үүсгэх, /7/ Гамшгийн эрсдэлийг бууруулах үндсэн чиглэлийг тодорхойлох, /8/ Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилт дэвшүүлэх, /9/ Урьдчилан сэргийлэх, Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах ажлыг гүйцэтгэнэ. /7/

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндсэн чиглэлийг тодорхойлох ажлыг /9/ Урьдчилан сэргийлэх, Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах-ын дараа оруулж хийж болно. Ажлын хэсгийн гишүүд хариуцаж байгаа салбарын бүлэгт тус тус орж ажиллана.

<p>(1-р бүлэг)</p> <p>1. Барилга байгууламж, хот байгуулалт, дэд бүтэц, ИШС</p> <p>1.1 Гамшгаас хамгаалах хот төлөвлөлт</p> <p>1.2 Засаг захиргааны байгууллагын барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах</p> <p>1.3 Олон нийтийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах</p> <p>1.4 Орон сууцын барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах</p> <p>1.5 Зам байгуулалт, замын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах</p> <p>1.6 Гүүр, үерийн далангийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах</p> <p>1.7 ИШС-ий газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах</p> <p>1.8 Хорт химийн бодис гэх мэтийг хадгалдаг аюул бүхий барилга байгууламжийн тэсвэржилтийг хангах</p> <p>(2-р бүлэг)</p> <p>2. Хүч хэрэгсэл</p> <p>2.1 Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл</p> <p>2.2 Гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүн</p> <p>2.3 Гамшгийн нөөц</p> <p>2.4 Шуурхай тээврийн хүч хэрэгсэл, сүлжээ</p> <p>3. Мэдээлэл, харилцаа холбоо</p> <p>3.1 Мэдээлэл холбооны дэд бүтэц</p> <p>3.2 Холбоо, мэдээлэл цуглуулах удирдлага зохион байгуулалт</p>	<p>(3-р бүлэг)</p> <p>4. Эрүүл мэнд</p> <p>4.1 Эмнэлэг, орны тоо</p> <p>4.2 Эмч, сувилагч</p> <p>4.3 Хээрийн эмнэлэг</p> <p>4.4 Эмийн нөөц</p> <p>4.5 Мэдээлэл дамжуулах</p> <p>4.5 Тээврийн зохион байгуулалт</p> <p>4.6 Халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ</p> <p>4.7 Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх</p> <p>5. Гамшгаас хамгаалах арга хэмжээ</p> <p>5.1 Сураггүй болсон иргэдийг эрэн хайх</p> <p>5.2 Шарил таниулах, оршуулах</p> <p>5.3 Түр хоргодох байр томилгоожуулах</p> <p>5.4 Түр хоргодох байран дахь нөөц</p> <p>5.5 Нүүлгэн шилжүүлэх зам</p> <p>5.6 Замын хөдөлгөөний зохицуулалт</p> <p>5.7 Ундны цэвэр ус, хүнс, ахуйн анхдагч хэрэглээний зүйлс</p> <p>5.8 Хог хаягдлын арга хэмжээ</p> <p>5.9 Бие засах газраар хангах, бохир зайлуулах арга хэмжээ</p> <p>5.10 Нуранги зайлуулах</p> <p>(4-р бүлэг)</p> <p>6. Боловсрол, сургалт</p> <p>6.1 Гамшгаас хамгаалах боловсрол, сургалтын хөтөлбөр</p> <p>6.2 Гамшгаас хамгаалах сургалтын материал</p> <p>6.3 Сургууль болон хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаа</p> <p>6.4 Олон нийтийн гамшгаас хамгаалах сайн дурын байгууллага</p> <p>6.5 Орон нутгийн засаг захиргаа ба олон нийтийн харилцан уялдаа</p> <p>6.6 Иргэдэд зарлан мэдээлэх, сэрэмжлүүлэх мэдээ хүргэх</p>
---	---

2) Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүснэгтийн бүтэц

「1.1 Барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах арга хэмжээ」, 「1.2 Засаг захиргааны байгууллагын барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах」 гэх

зэрэг салбарын хэсэг тус бүрээр «Одоогийн байдал, цагийн байдал», «10 жилийн зорилт», «Тулгамдаж буй асуудал», «Шийдвэрлэх арга хэмжээ» гэсэн бүтцээр хүснэгт боловсруулна. Бүлгээрээ асуудлыг хэлэлцэхийн тулд А0 хэмжээний цаасан дээр хүснэгтээ хэвлэж, оруулах мэдээллийг наадаг цаасан дээр бичиж наах нь зохимжтой. Хүснэгтийн бүтцийн жишээг доор үзүүлэв.

Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ

1-р бүлэг: Барилга байгууламж, хот байгуулалт, дэд бүтэц, ИШС

Салбар	Арга хэмжээ	Одоогийн байдал	10 жилийн зорилт	Тулгамдаж буй асуудал	Хэрэгжүүлэх арга хэмжээ
1. Барилга байгууламж, хот байгуулалт, дэд бүтэц, ИШС	1.1 Барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах арга хэмжээ				
	1.2 Засаг захиргааны байгууллагын барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах				
	1.3 Олон нийтийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах				
	1.4 Орон сууцны барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах				
	1.5 Зам байгуулалт, замын газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах				
	1.6 Гүүрийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах				
	1.7 ИШС-ий газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах				
	1.8 Хорт химийн бодис гэх мэтийг хадгалдаг аюул бүхий барилга байгууламжийн тэсвэржилтийг хангах				

3) Цагийн байдал үүсгэх

Эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн салбар тус бүрийн цагийн

байдлыг үүсгэнэ. Гамшиг тохиолдвол ямар нөхцөл байдал үүсэх тухай аль болох бодит төсөөллийг бий болгож, мэдээллийг ямарваа нэгэн эрэмбэ дараалалд баригдалгүй жагсаана. Мэдээллийг наадаг цаасан дээр бичиж оруулна. Энд “1.7 ИШС-ий газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах” хэсгээр жишээ болгож доор үзүүлэв.

Цагийн байдал үүсгэх жишээ

Салбар	Арга хэмжээ	Одоогийн байдал
1. Барилга байгууламж, хот байгуулалт, дэд бүтэц, ИШС	1.7 ИШС-ий газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах	<p>【Төсөөлөл】</p> <ul style="list-style-type: none"> Цэвэр ус: 8 цэгт эвдэрсэн. Цэвэр усны 8 цэгт гэмтэл гарснаар дундажаар 1200 хүнийг усаар хангах боломжгүй болно. Тухайн гэмтэл гарсан цэгүүд нь 2 талаасаа тэжээгддэг тохиолдолд хүндрэл үүсэхгүй. Тэжээлгүй тохиолдолд усны машинаар ус түгээж иргэдийг усаар хангана. Цэвэр усны гэмтэл дээр Усан хангамжийн алба болон Орон сууцны албаны дарга 2, инженер 7, засварчин 48 зэрэг нийт 57 ажилтан ажиллана. Бохир ус: хохирлын хувь 19% Бохир усны шугамд гэмтэл гарснаар хөрсний бохирдол үүсэх аюултай. Бохир усны гэмтэл дээр албаны дарга 1, инженер 3, засварчин 10 зэрэг нийт 14 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана. Гамшгийн үед Хяналтын инженерүүд 10, албадын дарга нар 3, инженер 10, бригадын 58 засварчин, автокранист 1, экскаваторчин 1, сордог машины жолооч 2, ковшын жолооч 1, гагнуурчин болон машин 2, шуурхай үйлчилгээний машин 3 зэрэг нийт 90 хүн, 10 техник хэрэгслийн хүчин чадалтайгаар гамшгийн үед ажиллана. Дулаан дамжуулах сүлжээний 15 цэг дээр гэмтэл гарсан. Дулаан түгээх сүлжээний 552 цэг дээр гэмтэл гарсан. Компанийн хэмжээнд 1 өргөх зөөх, 3 тусгай зориулалтын ба зөөврийн, 2 ачааны, 2 хүн тээврийн машин орон тооны бус 7 хүний бүрэлдэхүүнтэй, мэргэжлийн 54 хүнтэйгээр ажилладаг. Цахилгаан эрчим хүч ДУА-ийн 610, 4 КВ хуучин модон тулгуурууд 8 баллын газар хөдлөлтөнд унана. Гүний 1,2-р шугамын ЦЭХ тасалдана. Хэрэглэгчид ус, дулаангүй болно. Том том ААНБ-ын үйлдвэрлэл зогсоно.

4) Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилт дэвшүүлэх

Гамшгийн үед үүсч болзошгүй хохирлын төсөөлөлд үндэслэн гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтыг дэвшүүлнэ. Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтыг бодит тоогоор илэрхийлж дэвшүүлнэ. Жишээг доор үзүүлэв.

Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтын жишээ

Салбар	Арга хэмжээ	10 жилийн зорилт
1. Барилга байгууламж, хот байгуулалт, дэд бүтэц, ИШС	1.7 ИШС-ий газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах	<ul style="list-style-type: none"> Цахилгаан дамжуулах агаарын шугам, НШ-д Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг 100% гүйцэтгэж, газар хөдлөлтийн эрсдэлийг 0% болгох. "ДДС" ТӨХК, "ДУС" ХК-ын газар хөдлөлтийн гамшгийн үеийн цахилгаан, дулааны шугам сүлжээ, цэвэр бохир усны шугам сүлжээнд гарах хохирлын эрсдэлийг 50 % бууруулах. Насжилт нь дууссан ЦДАШ, НШ, дулааны шугам сүлжээ, цэвэр

		бохир усны шугам сүлжээний 80 хүртэлх хувийг шинэчилж газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах. <ul style="list-style-type: none"> • “ДДС” ТӨХК, “ДУС” ХК-ын машин механизм, техник хэрэгслийн 60 хүртлэх хувийг шинэчилж техникийн бэлэн байдлыг хангах.
--	--	--

5) Тулгарч буй асуудал

3)-т дэвшүүлсэн гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлж дурдана. Эдгээр асуудлыг ч мөн ямарваа нэгэн эрэмбэ дараалалд баригдалгүй жагсаана. Мэдээллийг наадаг цаасан дээр бичиж оруулна. Жишээг доор үзүүлэв.

Тулгарч буй асуудлын жишээ

Салбар	Арга хэмжээ	Тулгарч буй асуудал
1. Барилга байгууламж, хот байгуулалт, дэд бүтэц, ИШС	1.7 ИШС-ий газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах	<ul style="list-style-type: none"> • Зөвшөөрөлгүй барьсан барилга байгууламж (хамгаалалтын зурваст орсон). • Машин механизмын хүчин чадал хүрэлцээ муу. • Шугам хоолойн насжилт өндөр. • ЦДАШ,НШ-н насжилт өндөр. • Дэд станц барилга байгууламж хуучирсан. • Тусгай зориулалттай машин механизм дутмаг. • ДУА-гийн 6/0,4 кв-ын ЦДАШ-ын модон тулгуур нь 20% эзэлж байна. • Мэргэжлийн ангийн 3 бүлэг, ослын 16 бригад (250 ажилтантай)-тай боловч газар хөдлөлтийн үеийн гамшгийн сургалт, бэлэн байдал сул. • ЦЭХ-ний дэд станц шугам тоног төхөөрмжинд гарсан ослыг таслан зогсоох засвар үйлчилгээ хийх, хойшлуулахгүй сэргээн босгох ажил гүйцэтгэх бэлэн байдал, чадавхи сул. • Ажилчдын хөрөнгө мөнгийг хасаж танадаг.

6) Тулгарч буй асуудлыг арилгахад чиглэсэн арга хэмжээ

3)-т дэвшүүлсэн гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээг дурдана. Аль болох бодит, хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг дурдана. “Боловсронгуй болгоно”, эсвэл “эрчимжүүлнэ” гэх мэт арга хэмжээ байх бус, бодитоор хэрэгжүүлэх ажлуудыг тоон үзүүлэлтийн хамт оруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээний жишээ

Салбар	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ
1. Барилга байгууламж, хот байгуулалт, дэд бүтэц, ИШС	1.7 ИШС-ий газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах	<ul style="list-style-type: none"> • Шугам шинэчлэлийн ажилд цэвэр усны шугам хоолойг газар хөдлөлтөд тэсвэртэй хоолойгоор солих. 10 жилийн хугацаанд цэвэр усны нийт шугам сүлжээний 50%-ийг шинэчлэх. • Зөвшөөрөлгүй 12 барилгыг дахин төлөвлөлтөд оруулж дахин барих, эсвэл хүчитгэх. • ЦДАШ,НШ-н шинэчлэлт хийх, нөөц дулааны шугам сүлжээний бэлтгэл байдалд тогтмол үзлэг үйлчллгээ,засвар шинэчлэлт хийж байх. • 6/0,4 кв дэд станцуудад барилгын засварын ажил хийх, газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг хангах. • Дамжуулах сүлжээний гэмтэл гарсан хэсэгчилэн солих (5 жилийн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх)

		<ul style="list-style-type: none"> • Хуучирсан машин механизмыг актлах шинэчлэн сайжруулах талаар байгууллагын бизнес төлөвлөгөөнд тусгах, тусгай төхөөрөмжтэй машин механизмын хүчин чадал нэмэгдүүлэх. <p><u>“ДДС” ТӨХК</u></p> <ul style="list-style-type: none"> • ЦЭХ-ний нөөц эх үүсгэврийн бий болгох • Аваарын нөөцийг тогтмол бэлэн байлгах • Нийт ажилтнуудыг гамшгийн үед цагийн байдлын дагуу сургалтыг зохион байгуулж тогтмол хэвшүүлэх, гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалтыг мэргэжлийн түвшинд хүргэх <p><u>“ДУС” ХК</u></p> <ul style="list-style-type: none"> • Шугам хоолойг хүчитгэх • Шаардлагатай судалгаануудыг хийж төсөв хөрөнгийг шийдвэрлэж , эрсдэлийн үнэлгээ хийх. • Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг бодит байдалд ойртуулж үнэлэх арга зүйд суралцах, эрсдэлийн үнэлгээг цахилгаан дулаан, цэвэр усны шугам сүлжээнд хийх. • Цэвэр усны эх үүсвэрийн цахилгаан хангамж хамгийн түрүүнд шийдэх. ДЦТС ХК-тай хамтрах. Шаардлагатай үед ДДС-с генератор авах. ДДС ТӨХК-тэй хамтрах.
--	--	---

7) Хэрэгжүүлэх байгууллага, хэрэгжүүлэх арга хэмжээг эрэмбэлэх

Дээрх жишээнд үзүүлсэнчлэн хэрэгжүүлэх байгууллага тус бүрээр тухайн арга хэмжээг бичиж оруулсан байгаа бөгөөд, эсвэл арга хэмжээ тус бүрээр хэрэгжүүлэх байгууллагыг бичиж оруулна. Мөн, хэрэгжүүлэх арга хэмжээг хэрхэн эрэмбэлэх талаар анхаарна.

Монголын хувьд гамшгийн өмнөх гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд шаардагдах хөрөнгө төсөвлүүлэхэд хүндрэлтэй байдаг тул урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ төдийлөн хэрэгждэггүй гэсэн асуудал байдаг бөгөөд урьдчилан гамшгийн эрсдэлийг бууруулахад шаардлагатай хөрөнгийг төсөвлөж, тухайн хөрөнгө оруулалт нь гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох болон урт хугацааны сэргээн босголтод зарцуулагдах хөрөнгөтэй харьцуулахад үр дүнгээрээ илүү байдаг гэдгийг ойлгож, юуны түрүүнд шаардлагатай хөрөнгийг төсөвлөх ажлыг хэрэгжүүлэх талаар анхаарах.


Үр дүнтэй хөрөнгө оруулалт хийхийн тулд бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хосолсон зохистой хувилбарыг тодорхой болгож үүсч болзошгүй эдийн засгийн хохирол ихтэй салбарт нэн тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн, хэрэгжүүлэхэд цаг хугацаа ихээр зарцуулдаг бүтцийн арга хэмжээний хэрэгжүүлэх шат дарааллыг тодорхой болгож төлөвлөгөөнд тусгана.

8) Хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө төсөв

Хэрэгжүүлэх арга хэмжээг эрэмбэлсний дараа тухайн арга хэмжээ тус бүрд

шаардагдах төсөв хөрөнгийн хуваарилалтын төлөвлөгөөг боловсруулна. Доор жишээг үзүүлсэн бөгөөд асуудлыг хэлэлцэх явцад хэрэгжүүлэх арга хэмжээний агуулга болон арга хэмжээний хэрэгжүүлэх эрэмбэ, шат дарааллыг мөн өөрчилж болно. Үүний адилаар, гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтыг ч өөрчлөх шаардлага гарч ирэх магадлалтай бөгөөд эдгээр өөрчлөлтийг аливаа зүйлд захирагдахгүйгээр ажлын хэсэг дээр чөлөөтэй ярилцаж өөрчлөлт оруулах, улмаар шаардлагатай төсөв хөрөнгийн төлөвлөгөөг гаргана. Ингэхдээ, хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлүүлж төсөвт тусгуулах арга зам, хяналт шинжилгээний аргачлалын талаар ярилцаж төлөвлөгөөнд тусгана.

Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд шаардагдах төсөв хөрөнгийн хуваарилалтын төлөвлөгөө (жишээ)

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тухайн жилд зарцуулах хөрөнгийн хэмжээ (2020~2029)
<p><Цахилгаан түгээх сүлжээ, цахилгаан станц></p> <p>1. ЦДАШ-ний газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг 100% хийж гүйцэтгэх.</p> <p>2. Насжилт өндөр ЦДШ-ын 80%-ийг шинэчилж газар хөдлөлтөд тэсвэртэй болгох.</p> <p>3. 6/0,4кВ дэд станцуудад барилгын засварын ажил хийх.</p> <p>4. “ДДС” ТӨХК-ын машин механизм, техник хэрэгслийн 60 хүртлэх хувийг шинэчилж техникийн бэлэн байдлыг хангах.</p> <p>5. “ДДС” ТӨХК “ДУС” ХК –ын инженер, техникийн ажилтнуудыг 100 хувь газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, бэлтгэл бэлэн байдлыг хангах сургалтад хамруулах.</p> <p><Ус суваг, дулаан></p> <p>1. Дулаан, цэвэр, бохирын шугам сүлжээний 80 хүртэлх хувийг шинэчилж газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах.</p> <p>2. Гангийн найрлаганд газар хөдлөлтөнд тэсвэртэй бодис орсон ганг захиалж хийлгэх, туршиж үзэх.</p> <p>3. Цэвэр усны эх үүсвэрийн цахилгаан хангамж хамгийн түрүүнд шийдэх. ДЦТС ХК-тай хамтрах.</p>	<p align="center">2020  2029</p> <p>1. 2020~2021 онд, нийт төсөв 22,000,000 төг.</p> <p>2. 2025~2029 онд, нийт төсөв 2 тэрбум 480 сая төг.</p> <p>3. 2020~2024 онд, нийт төсөв 348 сая төг.</p> <p>4. 2020~2029 онд, нийт зардал 4 тэрбум 460 сая төг.</p> <p>5. 2020~2029 онд, нийт зардал 80 сая төг.</p> <p>1. Нийт 115 сая төг. 2025 оноос 2029 он хүртэлх орон нутгийн хөгжлийн стратеги төлөвлөгөөнд тусгаж, батлуулах.</p> <p>2. Нийт төсөв 21 сая төг. 2020 оноос 2024 он хүртэлх хугацаанд улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулах.</p> <p>3. Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар цахилгаан хангамжийн тоног төхөөрөмжийг бүрдүүлэх. 2025~2029 онд нийт 100 сая төг.</p>

4. Дэд Бүтэц, ИШС хариуцсан байгууллагууд хоорондоо санамж бичиг байгуулах.	4.. 2020~2021 онд
5. Химийн хорт бодисыг газар хөдлөлтөнд тэсвэртэй бат бөх саванд хадгалах арга хэмжээ авах.	5. 2025~2026 онд, нийт төсөв 20 сая төг. Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар худалдан авалт хийх.
6. Инженер, техникийн ажилтнуудыг 100 хувь газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, бэлтгэл бэлэн байдлыг хангах сургалтад хамруулах.	6. 2020~2029 онд, нийт төсөв 80 сая төг.

5. Урьдчилан сэргийлэх, Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах

1) Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүснэгтийн мэдээллийг Урьдчилан сэргийлэх, Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөнд тусгаж боловсруулна. Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүснэгтийн ангилал тус бүрийн дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах зорилт, арга хэмжээ, хэрэгжүүлэх байгууллага, шаардагдах төсөв хөрөнгийн төлөвлөгөөний мэдээллийг тусгаж оруулна. Жишээг доор үзүүлэв.

1.7 ИШС-ий газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах

<p>< Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилт (10 жилийн) ></p> <ul style="list-style-type: none"> • "ДДС" ТӨХК, "ДУС" ХК-ын газар хөдлөлтийн гамшгийн үеийн цахилгаан, дулааны шугам сүлжээ, цэвэр бохир усны шугам сүлжээнд гарах хохирлын эрсдэлийг 50 % бууруулах • Цахилгаан дамжуулах агаарын шугам, НШ-д Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг 100% гүйцэтгэж, газар хөдлөлтийн эрсдэлийг 0% болгох.
<p>< Хэрэгжүүлэх арга хэмжээ ></p> <p>"ДДС" ТӨХК</p> <ol style="list-style-type: none"> ① Цахилгаан дамжуулах агаарын шугам, НШ-д Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг 100% хийж гүйцэтгэн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг хангах. ② Насжилт өндөр цахилгаан дамжуулах шугамын 80%-ийг шинэчилж, газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг хангах. ③ 6/0,4 кв дэд станцуудад барилгын засварын ажил хийх. ④ Цахилгаан станцын тоног төхөөрөмжийн 60%-ийг шинэчилж бэлэн байдлыг хангах. ⑤ инженер, техникийн ажилтнуудыг 100 хувь газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, бэлтгэл бэлэн байдлыг хангах сургалтад хамруулах. <p>"ДУС" ХК</p> <ol style="list-style-type: none"> ⑥ Дулаан, цэвэр, бохирын шугам сүлжээний 80 хүртэлх хувийг шинэчилж газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах. ⑦ Гангийн найрлаганд газар хөдлөлтөнд тэсвэртэй бодис орсон ганг захиалж хийлгэх, туршилтаар нэвтрүүлэх. ⑧ Цэвэр усны эх үүсвэрийн цахилгаан хангамж хамгийн түрүүнд шийдэх. ДЦТС ХК-тай хамтрах. ⑨ Дэд Бүтэц, ИШС хариуцсан байгууллагууд хоорондоо санамж бичиг байгуулах. ⑩ Химийн хорт бодисыг газар хөдлөлтөнд тэсвэртэй бат бөх саванд хадгалах арга хэмжээ авах. ⑪ Инженер, техникийн ажилтнуудыг 100 хувь газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, бэлтгэл бэлэн байдлыг хангах сургалтад хамруулах. <p>< Хэрэгжүүлэх хугацаа ></p>

2020~2029 он										
< Хэрэгжүүлэх байгууллага >										
Аймгийн ЗДТГ, ДУС ХК, Дулаан хангамж, ДСЦТС, ДДС										
< Төсөв хөрөнгө > (10 мянган төгрөг)										
Дугаар/он	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029
①	1100	1100								
②	24800	24800	24800	24800	24800	24800	24800	24800	24800	24800
③	6960	6960	6960	6960	6960					
④	44600	44600	44600	44600	44600	44600	44600	44600	44600	44600
⑤	800	800	800	800	800	800	800	800	800	800
Нийт (ДДС)										
⑥	1150	1150	1150	1150	1150	1150	1150	1150	1150	1150
⑦	420	420	420	420	420					
⑧						2000	2000	2000	2000	2000
⑨						1000	1000			
⑩	800	800	800	800	800	800	800	800	800	800
Нийт (ДУС)										

Хэрэгжүүлэх арга хэмжээ, он, хэрэгжүүлэх байгууллага тус бүрээр төсөв хөрөнгийн хэмжээг тоочон гаргана. Иймэрхүү байдлаар урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсрогдоно.

2) Төлөвлөгөө боловсруулах Заавартай уялдуулах

Боловсруулсан урьдчилсан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний заалт хэсгүүд нь “Аймаг сумын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”, “Нийслэл дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын заалтуудтай нийцэж байгаа эсэхийг нягталж үзнэ.

6. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тухайд, бүтцийг “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-т үндэслэн дараах байдлаар боловсруулна. Мөн, төлөвлөгөөний зорилго болон үндсэн чиглэлийг дээр дурдсаны дагуу сүүлийн удаагийн сургалт воркшопын үед тодорхойлох нь зүйтэй. Хөрөнгө санхүүжилт шийдвэрлүүлэх арга зам болон хяналтын зохион байгуулалт зэргийг энэ үед төлөвлөнө.

Газар хөдлөлтийн гамшгийн үеийн шуурхай хариу арга хэмжээ, хор уршгийг арилгах төлөвлөгөө, гамшгийн үеийн хойшлуулшгүй сэргээн босгох болон гамшгийн дараах сэргээн босголтын ажлын төлөвлөгөөний тухайд одоо мөрдөгдөж буй төлөвлөгөөнд үндэслэн төлөвлөлт хариуцсан албан тушаалтан, мэргэжилтэн нь тодотгол хийж нэмж оруулна.

– Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүтэц –

1. Тухайн орон нутгийн ерөнхий танилцуулга
2. Төлөвлөгөөний зорилго
3. Үндсэн чиглэл
4. Төлөвлөгөөнд засвар оруулах
5. Гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалт
6. Хамтын ажиллагааны санамж бичиг
7. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ болон урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт
 - 7-1 Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, үүсч болзошгүй цагийн байдлын төсөөлөл ба хохирлын үнэлгээ
 - 7-2 Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт
8. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө
 - 8-1 Барилга байгууламж, дэд бүтэц, ИШС-ий газар хөдлөлтийн тэсвэржилтийг хангах
 - 8-2 Хүч хэрэгсэл
 - 8-3 Мэдээлэл, харилцаа холбоо
 - 8-4 Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ
 - 8-5 Гамшгаас хамгаалах арга хэмжээ
 - 8-6 Боловсрол, сургалт болон дадлага сургууль
9. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн шуурхай хариу арга хэмжээ, хор уршгийг арилгах төлөвлөгөө
 - 1 0. Газар хөдлөлтийн гамшгийн дараах хйошлуулшгүй сэргээн босгох болон сэргээн босголтын төлөвлөгөө
 - 1 1. Төлөвлөгөөний биелэлтийг удирдан хянах

**4: Гамшгаас хамгаалах Цагаан ном,
Цагаан ном боловсруулах гарын
авлага**

“ГАМШГААС ХАМГААЛАХ ЦАГААН НОМ БОЛОВСРУУЛАХ ГАРЫН АВЛАГА”

УЛААНБААТАР
2019

ӨМНӨХ ҮГ

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас дэлхий нийтэд тохиолдох гамшгийн аюул, түүнээс учрах хохирол нэмэгдэж, улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна.

Япон улсын Сендай хотод 2015 онд зохион байгуулагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Дэлхийн III бага хурлаас НҮБ-ын 187 улс “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030” баримт бичгийг баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн 3.4.2-т гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, 2018 оны Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурлаас баталж гаргасан “Улаанбаатарын тунхаглал” баримт бичигт “... Гамшгийн эрсдэлийг бууруулахад үндэсний болон орон нутгийн платформд худалдааны танхим, бизнесийн байгууллагуудын оролцоог дэмжих” гэснийг тус тус мөрдлөг болгон ажиллах бодлогын шаардлага тавигдаж байна.

Онцгой байдлын алба үүсэн байгуулагдсанаас хойш гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогыг олон улсын жишиг, ирээдүйн чиг хандлагад нийцүүлэн хэрэгжүүлж иргэд, олон нийтэд тулгуурласан гамшгаас хамгаалах, ялангуяа аливаа аюулт үзэгдэл, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах өөрийгөө болон бусдыг хамгаалах олон талын үйл ажиллагааг эрчимтэй явуулж байгаа билээ.

Олон улсын хэмжээнд болон бусад улс орнуудад гамшгаас хамгаалах албад нь “цагаан ном”-оор дамжуулан гамшгаас хамгаалах салбарт авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлах, мэдлэг, шинэ санал санаачлага, тэргүүн туршлага, ололт амжилтуудыг түгээн дэлгэрүүлэх замаар иргэд хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог хангах, дэмжлэг туслалцаанд тулгуурлан хамтран ажилладаг байна.

Онцгой байдлын ерөнхий газар, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага хамтран 2016-2019 онд хэрэгжүүлж буй “Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд Монгол улсын гамшгаас хамгаалах бодлого, үйл ажиллагаа, гамшгийн нөхцөл байдлын талаарх бодит мэдээллийг иргэд, олон нийтэд таниулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын “Гамшгаас хамгаалах цагаан ном-2017”-ыг анх удаа боловсруулж, нийтийн хүртээл болголоо.

“Гамшгаас хамгаалах цагаан ном-2017”-ын агуулгад гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, түүний шинэчлэл, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, олон талт хамтын ажиллагаа, галын аюулгүй байдал, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламж, газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах судалгааны ажил болон гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төсөв, хөрөнгө оруулалтын талаарх танилцуулга, тайлан зэргийг тусгасан.

Гамшгаас хамгаалах цагаан ном боловсруулах энэхүү заавар, аргачлалыг цагаан номын бүтэц, агуулгыг тодорхойлох, мэдээ мэдээлэл цуглуулах, тулгарч байсан асуудлууд, түүнийг хэрхэн шийдвэрлэх, дараа дараагийн номыг боловсруулахад удирдамж болгох зорилгоор боловсруулан хүргэж байна.

Нэг. Цагаан ном боловсруулах арга зүй

Гамшгаас хамгаалах цагаан номыг боловсруулахдаа дараах шат дарааллыг баримтална.

1. Цагаан ном боловсруулах ажлын хэсэг байгуулах

“Гамшгаас хамгаалах Цагаан ном” боловсруулахад газар хэлтсүүдийн оролцоог хангахын тулд ажлын хэсэг байгуулах шаардлагатай.

- ①Төсөв гаргах,
- ②Цагаан номын бүтэц, агуулгын талаар санал солилцох,
- ③Цуглуулах мэдээлэл болон мэдээллийн эх сурвалжийг тодорхой болгох, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах,
- ④Цуглуулсан мэдээллийг эмхэтгэх,
- ⑤Номын эх бэлтгэх,
- ⑥Эхийг хянах, засварлах,
- ⑦Англи хэл рүү орчуулах, хянах,
- ⑧Хэвлэх компанийг сонгох,
- ⑨Хэвлэлийн компанийн эх бэлтгэлийг хянах гэх зэрэг ажлууд орно.

Дээр дурдагдсан ажлуудыг Ажлын хэсэгт багтсан гишүүдэд хуваарилна.

2. Цагаан ном боловсруулах ажлын төлөвлөгөө гаргах

Ажлын хэсэг цагаан ном боловсруулах ажлын төлөвлөгөөг гаргана. Цагаан ном боловсруулах ажлын төлөвлөгөөний жишээг доор үзүүлэв.

Хүснэгт №1: Цагаан ном боловсруулах ажлын төлөвлөгөө (загвар)

	11 сар		12 сар		1 сар		2 сар		3 сар		4 сар	
Ажлын хэсэг байгуулах	△											
Ажлын төлөвлөгөө боловсруулах	△											
Бүтэц, агуулга, хэв загварыг гаргах												
Даргын зөвлөлд оруулж санал авах												
ОБЕГ-ын даргаар батлуулах												
Мэдээлэл цуглуулах ажлын төлөвлөгөө боловсруулах												
Мэдээлэл, материал цуглуулах												
Цуглуулсан мэдээллийг эмхэтгэх												
Эх зохиох												
Зохиосон эхийг ажлын хэсэг хянах												
Хавсралт хэсгийг боловсруулах												
ОБЕГ дээр танилцуулах												
ОБЕГ-ын даргаар батлуулах												
ОБЕГ-ын даргын өмнөх үг												
Цагаан ном тараах газруудыг тодорхой болгох												
Хэвлэлийн компани сонгох												
Номын эхийг хянан тохиолдуулах												
Орчуулагч сонгох												
Орчуулга												
Номын эхийг эцсийн байдлаар хянах												
Хэвлэх, тараах												

Ажлын хэсэг нь боловсруулсан ажлын төлөвлөгөөний дагуу ажлаа зохион байгуулна. “Гамшгаас хамгаалах Цагаан ном – 2017”-ыг боловсруулах явцыг доор товчхон танилцуулав.

Гамшгаас хамгаалах цагаан ном боловсруулах ажил 2017 оны 02 дугаар сараас эхэлсэн бөгөөд бэлтгэл ажил, материал цуглуулах, эмхэтгэх, хянуулах, орчуулах, хэвлэлийн компани сонгох, эх бэлтгэх, хэвлэх зэрэг ажил 1.5 жил орчим үргэлжилсэн. Ажлын төлөвлөгөөг Цагаан ном хэвлүүлж гаргах хугацаанаас нь тооцож нарийн төлөвлөх шаардлагатай.

Хүснэгт №2: “Гамшгаас хамгаалах Цагаан ном – 2017”-г боловсруулах ажлын төлөвлөгөөний биелэлт

№	Үйл ажиллагаа	Зарцуулсан хугацаа						
1	Цагаан номын талаар судлах	2017.02-03 сар 1 сар						
2	Цагаан номын бүтэц, агуулга боловсруулах төлөвлөгөөг боловсруулж батлуулах		2017.04-05 сар					
3	Нэгжүүдээс материал цуглуулах			2017.07-2017.12 сар				
4	Материалыг нэгтгэж боловсруулах			6 сар				
5	Даргын зөвлөлийн гишүүдээс санал авах, хянуулах					2018.01-02 сар 14 хоног		
6	Орчуулах, хянах						2018.05 сар 14 хоног	
7	Хэвлэх үйлдвэр сонгох, гэрээ байгуулах						2018.06 сар 14 хоног	
8	Цагаан номыг хэвлүүлэх							2018.07-09 сар 2 сар

Хоёр. Цагаан номын бүтэц, агуулга, загварыг тодорхойлох

“Гамшгаас хамгаалах цагаан ном-2017”-ын агуулгыг анх Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, шинэчлэл, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, олон талт хамтын ажиллагаа, галын аюулгүй байдал, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламж, газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, гамшиг судлал, гамшгаас хамгаалах судалгааны ажил, төсөл, хөтөлбөр, төсөв, хөрөнгө оруулалт зэрэг асуудлуудыг тусгасан оршил, 8 бүлэг, дүгнэлт, хавсралт хэсэгтэй байхаар төлөвлөсөн.

Агуулгын хувьд эрх зүйн болон бодлогын баримт бичиг, зарим нэг асуудлыг дэлгэрэнгүй тайлбарлаж, аль нэг нэгжийн үйл ажиллагааны тайлан, танилцуулгыг орхигдуулахгүй байх зарчмыг баримталсан.

Хавсралт хэсэгт хууль, тогтоомжийг дэлгэрэнгүй байдлаар тусгахаар төлөвлөж байсан боловч номын агуулга нэлээн өргөн хүрээтэй болсон учраас зөвхөн гамшгаас хамгаалах эрх зүйн баримт бичгийн жагсаалтыг оруулсан.

Жил бүр хэвлэн нийтэлж олны хүртээл болгох Цагаан ном анхны хэвлэл гэдэг утгаараа энэ удаагийн хэвлэлд 2017 оноос өмнө батлагдсан бодлогын баримт бичиг, хэрэгжсэн зарим үйл ажиллагааг тусгасан тал бий.

Монгол Улсад мөн батлан хамгаалах, цагаатгал, гэмт хэрэг, эдийн засаг, бизнес, гадаад худалдаа, мэдээллийн технологийн гэх мэт салбарууд цагаан номоо хэвлүүлсэн байдаг бөгөөд дээрх номын бүтэц, агуулгыг судлан үзэх нь зүйтэй.

Цагаан номын бүтэц, агуулгыг тодорхойлон Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, боловсруулах, ажлын төлөвлөгөө, бүтцийг Онцгой байдлын ерөнхий газрын даргаар батлуулна.

Гурав. Ажлын төлөвлөгөө гаргах

Цагаан ном тухайн жилийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, аюулт үзэгдэл, осол, гамшгийн нөхцөл байдал зэргийг тусгасан тайлан учраас дараа оны нэгдүгээр улиралд хэвлэгдэж олон нийтэд хүрэхээр байгууллагын төлөвлөгөөнд туссан байдаг.

Иймд цагаан номын агуулга, бүтцээ тодорхойлсны дараа мэдээлэл цуглуулах ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргах нь зүйтэй. (Загварыг хүснэгт №3 болон зураг №1-ээс үзнэ үү).

Хүснэгт №3. Монгол Улсын Гамшгаас хамгаалах цагаан номын мэдээлэл цуглуулах ажлын төлөвлөгөөний загвар

№	Бүлэг, гарчиг	Боловсруулах хугацаа	Хариуцах газар
Нэгдүгээр бүлэг. Монгол Улсын гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, шинэчлэл.			
1.1.	Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж	2017 оны 07 сар	БЗХАГ
1.2.	Гамшгаас хамгаалах талаар гаргасан бодлогын баримт бичиг	2017 оны 07 сар	БЗХАГ
1.3.	Гамшгаас хамгаалах тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт	2017 оны 08 сар	БЗХАГ, ЗУГ
Хоёрдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа.			
2.1.	Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	2017 оны 08 сар	ГЭУГ ГУСГ
2.2.	Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа	2017 оны 09 сар	ГУСГ
2.3.	Гамшгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ	2017 оны 10 сар	ГШУГ
2.4.	Гамшгийн үеийн зарлан мэдээлэл, шуурхай удирдлага зохицуулалт	2017 оны 10 сар	ГШУГ
2.5.	Гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ	2017 оны 12 сар	УОК, ГШУГ
2.6.	Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл	2017 оны 12 сар	ГШУГ
2.7.	Гамшгаас хамгаалах дэдлага, сургууль	2017 оны 12 сар	ГУСГ
Гуравдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах хамтын ажиллагаа.			
3.1.	Гамшгаас хамгаалах олон улсын хамтын ажиллагаа	2017 оны 12 сар	БЗХАГ
3.2.	Гамшгаас хамгаалах албадын харилцан ажиллагаа	2017 оны 11 сар	ГШУГ
3.3.	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгэм, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо	2017 оны 11 сар	БЗХАГ
Дөрөвдүгээр бүлэг. Галын аюулгүй байдал.			
4.1.	Галын аюулгүй байдлын талаарх баримт бичиг	2017 оны 09 сар	ГТТГ
4.2.	Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа	2017 оны 09 сар	ГТТГ
Тавдугаар бүлэг. Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламж.			
5.1.	Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн талаарх баримт бичиг	2017 оны 09 сар	УНХТГ
5.2.	Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа	2017 оны 09 сар	УНХТГ
Зургаа дугаар бүлэг. Газар хөдлөлтийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа			
6.1.	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл	2017 оны 08 сар	ГШУГ

6.2.	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай баримт бичиг	2017 оны 08 сар	ГШУГ
6.3.	Монгол Улсын газар хөдлөлтийн төлөв байдал, судалгаа шинжилгээ	2017 оны 10 сар	ГШУГ
6.4.	Улаанбаатар хотын ойр орчим дахь хагарлын судалгаа	2017 оны 10 сар	ГШУГ
6.5.	Улаанбаатар хотын газар хөдлөлтийн шуурхай арга хэмжээний төлөвлөгөө	2017 оны 11 сар	НОБГ
6.6	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх дадлага-сургууль	2017 оны 12 сар	ГУСГ
Долоодугаар бүлэг. Гамшиг судлалын хүрээлэнгийн үйл ажиллагаа.			
7.1.	Гамшиг судлалын хүрээлэнгийн судалгаа шинжилгээний ажлууд	2017 оны 11 сар	ГСХ
7.2.	Гамшигийн мэдээллийн сан	2017 оны 12 сар	ГСХ
Наймдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах төсөв, хөрөнгө оруулалт.			
8.1.	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	2017 оны 12 сар	СХХОГ
8.2.	Гадаадын хөрөнгө оруулалт	2017 оны 12 сар	СХХОГ
8.3	ОБЕГ-т хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр	2017 оны 09 сар	БЗХАГ
8.4.	Гамшигт нэрвэгдэгсэдэд олгох нөхөн олговор	2017 оны 11 сар	СХХОГ
8.5.	Гамшигийн хор уршгийг арилгах талаар авсан арга хэмжээ	2017 оны 12 сар	УОК СХХОГ
Есдүгээр бүлэг. 2017 оны гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тайлан.			
9.1.	Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, зохион байгуулалт, зохицуулалтыг боловсронгуй болгох талаар	2018 оны 01 сар	БЗХАГ
9.2.	Хүний нөөцийн хөгжлийг хангаж, чадавхийг бэхжүүлэх талаар	2018 оны 01 сар	ЗУГ
9.3	Гамшигийн эрсдэлийг бууруулах хөгжлийн бодлого, хөтөлбөр	2018 оны 01 сар	ГЭБГ
9.4.	Гамшгаас урьдчилан сэргийлэх, сургалт, мэдээлэл сурталчилгаа зохион байгуулах талаар	2018 оны 01 сар	ГУСГ
9.5.	Гамшигийн шуурхай удирдлага, зохицуулалтын чадавхийг дээшлүүлж, бэлэн байдлыг хангах чиглэлээр	2018 оны 01 сар	ГШУГ
9.6.	Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулах талаар	2018 оны 01 сар	ГТТГ
9.7	Улсын нөөцийн удирдлага, зохицуулалт, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах талаар	2018 оны 01 сар	УНХТГ
9.8	Төсөв, санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын талаар	2018 оны 01 сар	СХХОГ
9.9	Гамшиг судлалын шинжлэх ухааныг нэвтрүүлэх, гамшигийн мэдээллийн сангийн судалгааны талаар	2018 оны 01 сар	ГСХ
	Монгол Улсын гамшгаас хамгаалах цагаан номын зорилго, өмнөх үгийг бэлэн болгох	2018 оны 01 сар	Ажлын хэсэг
	Монгол Улсын гамшгаас хамгаалах цагаан номын эхийг бэлтгэх	2017 оны 10 сараас 2018 оны 01 сар	Ажлын хэсэг
	Монгол Улсын гамшгаас хамгаалах цагаан номын хэвлүүлэх	2018 оны 02 сар	Ажлын хэсэг
	Хавсралтуудыг бэлэн болгох	2017 оны 11 сар - 2018 оны 01 сар	Ажлын хэсэг

			2017						2018							
			5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6
Нэгдүгээр бүлэг. Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны өнөөгийн байдал																
1.1.	Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж	6/1/2017														
1.2.	Гамшгаас хамгаалах талаар гаргасан бодлогын баримт бичиг	6/1/2017														
1.3.	Гамшгаас хамгаалах тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт	8/1/2017														
Хоёрдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа																
2.1.	Гамшгаас урьдчилан сэргийлэх болон гамшигын эрсдэлийг бууруулах арга хэмжээ	8/1/2017														
2.2.	Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа	9/1/2017														
2.3.	Гамшигийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ	10/1/2017														
2.4.	Гамшигийн үеийн зарлан мэдээлэл, шуурхай удирдлага зохицуулалт	10/1/2017														
2.5.	Гамшигийн хор уршгийг арилгах арга хэмжээ	12/1/2017														
2.6.	Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл	12/1/2017														
2.7.	Гамшгаас хамгаалах дадлага, сургууль	12/1/2017														
Гуравдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах хамтын ажиллагаа																
3.1.	Гамшгаас хамгаалах олон улсын хамтын ажиллагаа	12/1/2017														
3.2.	Гамшгаас хамгаалах албадын харилцан ажиллагаа	11/1/2017														
3.3.	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгэм, төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоо	11/1/2017														
Дөрөвдүгээр бүлэг. Галын аюулгүй байдлын хангах үйл ажиллагаа																
4.1.	Галын аюулгүй байдлын талаарх баримт бичиг	9/1/2017														
4.2.	Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа	9/1/2017														
Тавдугаар бүлэг. Улсын нөөцийн үйл ажиллагаа																
5.1.	Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн талаарх баримт бичиг	9/1/2017														
5.2.	Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа	9/1/2017														
Зургаа дугаар бүлэг. Газар хөдөлмөрийн болгоошгүй аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа																
6.1.	Газар хөдөлмөрийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл	7/1/2017														
6.2.	Газар хөдөлмөрийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зарчимжуулах тухай баримт бичиг	7/1/2017														
6.3.	Монгол Улсын газар хөдөлмөрийн төлөв байдал, судалгаа шинжилгээ	10/1/2017														
6.4.	Улаанбаатар хотын ойр орчим дахь хагарлын судалгаа	10/1/2017														
6.5.	Улаанбаатар хотын газар хөдөлмөрийн шуурхай арга хэмжээний төлөвлөгөө	12/1/2017														
6.6.	Газар хөдөлмөрийн гамшгаас урьдчилан сэргийлэх дадлага-сургууль	12/1/2017														
Долоодугаар бүлэг. Гамшиг судлалын хүрээлэнгийн үйл ажиллагаа																
7.1.	Гамшиг судлалын хүрээлэнгийн судалгаа шинжилгээний ажлууд	11/1/2017														
7.2.	Гамшигийн мэдээллийн сан	12/1/2017														
Наймдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах төсөв, хөрөнгө оруулалт																
Есдүгээр бүлэг. 2017 оны гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тайлан																
9.1.	Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, зохион байгуулалт, хөшүүрчлэл, бодисын хөдөлгөөний боллох талаар	1/1/2018														
9.2.	Хүний нөөцийн хөгжлийг хангаж, чадавхийг бэхжүүлэх талаар	1/1/2018														
9.3.	Гамшигийн эрсдэлийг бууруулах хөгжлийн бодлого, хөтөлбөр	1/1/2018														
9.4.	Гамшгаас урьдчилан сэргийлэх, сургалт, мэдээлэл сурталчилгаа зохион байгуулах талаар	1/1/2018														

Зураг №1. Цагаан ном боловсруулах ажлын календарьчилсан төлөвлөгөөний загвар

Цагаан номын агуулгад орж буй мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааны тайланг олон эх үүсвэрээс цуглуулж, нэгтгэн боловсруулах учир тухайн мэдээлэл, судалгаа, сэдэв, бүлгийг хариуцсан нэгж, мэргэжилтэнд энэхүү төлөвлөгөөний талаар болон чухам ямар агуулгатай мэдээлэл хэзээ хэрэгтэйг урьдчилан танилцуулах нь цаг алдахгүй байх ач холбогдолтой.

Мөн тодорхойлсон агуулгыг боловсруулахад хаанаас ямар эх сурвалж ашиглахыг тодорхойлж чиглүүлэх нь цаг хугацаа хэмнэх, ажлыг хялбарчлахад дөхөм болно. (Загварыг хүснэгтээс харна уу.)

Хүснэгт №4. Материал боловсруулахад ашиглах эх сурвалж


№	Бүлэг, гарчиг	Эх сурвалж	Хариуцах газар
Нэгдүгээр бүлэг. Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны өнөөгийн байдал.			
1.1.	Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж	-Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017 он -Монгол Улсын галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2015 он -Монгол Улсын нөөцийн тухай хууль 2009 он www.legalinfo.mn;	БЗХАГ
1.2.	Гамшгаас хамгаалах талаар гаргасан бодлогын баримт бичиг	УИХ-ын “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр батлах тухай” 22 дугаар тогтоол. 2011 он -Монгол Улсын Засгийн газрын “Төлөвлөгөө батлах тухай” 2012 оны 30 дугаар тогтоол. Гамшгаас хамгаалах талаарх бодлогын баримт бичгүүд эмхтгэл. 2016 он. www.legalinfo.mn -Монгол Улсын Шадар Сайдын 2015 оны “Төлөвлөгөө батлах тухай” 112 дугаар тушаал. “ОБЕГ –ын дунд хугацааны стратеги төлөвлөгөө” УБ хот. www.nema.gov.mn	БЗХАГ ЗУГ
1.3.	Гамшгаас хамгаалах тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт	-Монгол Улсын Засгийн газрын “Салбар нэгжийг шинэчлэн батлах тухай” 2016 оны 66 дугаар тогтоол. -Монгол Улсын Шадар сайдын 2016 оны “Журам батлах тухай” 79 дүгээр тушаал. ОБАЭБ-ын бүс, бүсийн төвийн ажиллах журам. -ОБАЭБ-ын бүсийн төвүүдийн танилцуулга. www.nema.gov.mn.	БЗХАГ ЗУГ
Хоёрдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа.			

2.1.	Гамшгаас урьдчилан сэргийлэх болон гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ	-Монгол Улсын Засгийн газрын “Хөтөлбөр батлах тухай” 2015 оны 303 дугаар тогтоол. “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”. Гамшгаас хамгаалах талаарх бодлогын баримт бичгүүд эмхтгэл. УБ хот.2016 он. хуудас - 20. -Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоол. “ Ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн жагсаалт батлах тухай.	ГУСГ
------	---	--	------

Дөрөв. Санал авах, хянуулах, орчуулах, хэвлэх

Цагаан номын төслийг боловсруулж дууссаны дараа Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжүүдээс санал авна. Ирүүлсэн саналыг тусган Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж зөвшөөрсний үндсэн дээр хэвлэлтэд шилжүүлнэ.

Монгол Улсад 2018 оны 07 дугаар сард Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурлыг зохион байгуулсантай холбогдуулан цагаан номыг монгол, англи хэлээр хэвлүүлсэн. Хурлын үеэр цагаан номын хураангуйг англи хэлээр хэвлүүлж хуралд оролцогчдод тараасан.



Зураг №2. Гамшгаас хамгаалах цагаан номын танилцуулгын хэсгээс

Номын орчуулга цаг хугацаа, зардал мөнгө их шаардсан, орчуулсан үг хэллэг мэргэжлийн үг хэллэгээс бага зэргийн зөрүүтэй байсан, орчуулсан материалыг хэн хянах зэрэг асуудлуудыг төлөвлөөгүй байсан. Хэд хэдэн орчуулагчдад номыг бүлэг, хэсгээр хуваан өгч ОБЕГ-ын цахим хуудаст байршуулсан бодлогын баримт бичгээс мэргэжлийн үг хэллэг, нэр томъёоны орчуулгыг ашиглахыг зөвлөснөөр дээрх асуудлыг шийдвэрлэсэн.

Иймд цаг хугацаа, орчуулсан материалыг хянах, түүний ажлын хөлс гэх мэт асуудлыг урьдчилан төлөвлөх нь зүйтэй.

5. САНАЛ

2018 оны цагаан ном дараах бүтэцтэй байх саналыг дэвшүүлж байна.

- Гарчиг
- Товчилсон үг
- Өмнөтгөл
- Нэгдүгээр бүлэг. Төв, орон нутагт тохиолдсон гамшиг, аюулт үзэгдлийн төлөв байдалд хийсэн дүн шинжилгээ
- Хоёрдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны 2018 оны тайлан
- Гуравдугаар бүлэг. Шинэчлэл, онцлох үйл явдал
- Дөрөвдүгээр бүлэг. Сургамж, дүгнэлт
- Тавдугаар бүлэг. Санал, зөвлөмж
- Хавсралт
- Нэр томъёоны тайлбар

2018 оны цагаан номын агуулгад Монгол Улсын Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа бүсчилсэн тогтолцоонд шилжсэнтэй холбогдуулан тохиолдсон аюулт үзэгдэл, түүний учир шалтгаан, хор хохирол, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 21 аймаг эсвэл бүсээр танилцуулах,

хийсэн дүн шинжилгээг тусгавал цаашид судалгаанд ашиглах, харилцан мэдээлэл, туршлага солилцоход ач холбогдолтой гэж үзэж байна. (Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016 харах)

Түүнчлэн “Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг”-т тодорхойлсон зорилго, зорилт, Монгол Улсад хэрэгжүүлэх стратеги, төлөвлөгөөний талаар оруулах нь зүйтэй.

Тухайн онд болсон бодлогын болон бүтцийн шинэчлэл, ололт амжилтын талаар онцлох үйл явдлуудыг энгийн үг хэллэгээр тайлбарлаж зураг, хүснэгт, графиктай оруулвал иргэдэд ойлгомжтой, сонирхолтой байх болно.

Цаашид бусад салбарын цагаан номыг холбогдох эрдэмтэн, судлаачаас бүрдсэн судалгааны мэргэжлийн байгууллага, баг томилон боловсруулж буй жишигт нийцүүлэн Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газар, Гамшгийн шуурхай удирдлагын газрын Орон зайн мэдээлэл, технологийн тасаг, Гамшиг судлалын хүрээлэн хамтран боловсруулах нь зүйтэй.

Ингэхдээ зөвхөн статистик тоо баримтыг дурдаад зогсохгүй шалтгаан нөхцөл, үр дагаварт бусад мэргэжлийн байгууллагатай хамтран анализ хийж, цаашид бууруулах арга замыг шинжлэх ухааны үндэслэлтэй эрэлхийлэх, иргэдэд зориулсан зөвлөмж, аргачлалыг түлхүү оруулах нь зүйтэй.

Тоо баримт, мэдээ мэдээлэл, судалгааны ажлын үр дүнг алба хаагчид, нэгж төдийгүй оюутан, багш, судлаачид, бусад байгууллага, иргэд үйл ажиллагаандаа ашиглахуйц дэлгэрэнгүй оруулвал энэхүү номын үр өгөөж, ач холбогдол нэмэгдэнэ.

Холбогдох суурь судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэй хийх, түүнд тулгуурлан иргэдийн аюулгүй амьдрах мэдлэг, боловсролыг дээшлүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын үр дүн нэмэгдэх боломж бүрдэнэ.

Энэхүү номыг Онцгой байдлын албаны төв, орон нутгийн салбар нэгжүүд, Онцгой байдлын сургууль, Олон улсын болон төрийн бус байгууллагууд, иргэд, олон нийтэд аль болох хүртээмжтэй байлгах үүднээс хэвлэх тоо ширхэг, зардал мөнгийг шийдвэрлүүлэх асуудал чухал юм. Иймд Гамшгаас хамгаалах цагаан ном боловсруулж, хэвлүүлэх ажлыг байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах зардлыг төсөвт тусгах шаардлагатай.

АЖЛЫН ХЭСЭГ